

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2020 №4 (74)
18 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД
ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237
ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D)

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D)

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан, шийдвэрлэх арга зам” судалгааны тайлан	Г.Оюунболд	6
Шүүгчийн танин мэдэх үйл явц, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлс	Б.Батзориг	18
Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдсан зарим асуудал	Н.Жинжиймаа	22
Шинэ үеийн терроризмын нөлөө, терроризм, эдийн засгийн хамаарал	Э.Дашгаадан	29
Гэр бүлийн орчин өсвөр насны хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болох нь	Д.Цэрэнлхам	36

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсын Эрүүгийн хууль, түүний онцлог	Г.Гантөмөр Нгуен Ван Хунг	42
--	------------------------------	----

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчийн эд хөрөнгийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хангах асуудал	Б.Батхуяг	50
Газар, орон байранд үзлэг хийх ажилагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд	Т.Мөнхбадрах	54

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Гадаадын зарим улсын цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж, алба хаагчийн үйл ажиллагаа	Б.Баянмөнх	58
Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн тухай ойлголт, бүтэц, зохион байгуулалт, ашиглах аргачлал, анхаарах зарим асуудал	Ш.Чулуун	67
Организация контроля за поведением условно осужденных органами полиции Монголии	А.Баасанцэрэн	76

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол Улс дахь албадан сургалтын эрх зүйн зохицуулалт, түүнийг боловсронгуй болгох нь	Ц.Алтанцэцэг С.Эрдэнэболор О.Хишигмөнх	79
Хорих анги, цагдан хорих байрны харуул хамгаалалтад гар станцны чихэвч ашиглах хэрэгцээ, шаардлага	Б.Сандаг	87

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хөрс судлалыг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглах нь	Б.Номин	89
--	---------	----

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Сэтгэл санааны гэм хорын хохирлын хэмжээг тогтооход тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам	<i>Ц.Оюунбилэг</i>	96
The unique nature of letter of credit and its legal source	<i>Bui Le Thuc Linh</i>	100
ICSID Amendment Proposal: What is changing?	<i>Ninjin Bataa</i>	112
Territoriality of Intellectual Property Rights Foundations of IP Territoriality and Reverberations of Territorial Exclusivities on Trade	<i>O.Bugra Beydogan</i>	117

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

“НИЙТИЙН АЛБАНЫ АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН СУУРЬ ШАЛТГААН, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

I. Судалгааны арга зүй, зохион байгуулалт

Монгол Улсад 2018-2019 онд шүүхээр шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болгосон ЭХ-ийн 23 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн нөхцөл байдал, статистик үзүүлэлт, эрүүгийн хавтаст хэргийн судалгааг 2019 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын болон Улсын Ерөнхий Прокурорын газрын бүртгэл, судалгаа хариуцсан нэгж, Улсын Ерөнхий Прокурорын газрын архивын материалд түшиглэн явууллаа.

Судалгаанд сүүлийн 2 жилд буюу 2017-2018 онд нийслэлийн дүүргүүдийн шүүхээр нийтлэг шийдвэрлэгдсэн дараахь төрлийн хэргийг багтаан судалсан болно. Үүнд:

- ЭХТА-ийн 23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх
- ЭХТА-ийн 23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах
- ЭХТА-ийн 23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух
- ЭХТА-ийн 23.4 дүгээр зүйл.Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх
- ЭХТА-ийн 23.5 дугаар зүйл.Хайнга хандах
- ЭХТА-ийн 23.6 дугаар зүйл.Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах
- ЭХТА-ийн 23.7 дугаар зүйл.Нийтийн албан тушаалтныг заналхийлэх

Судалгааны зорилго

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ЭХ-ийн 23 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн суурь шалтгааныг судлах ажлын хүрээнд дараахь зорилтыг дэвшүүлэн ажиллаа:

- Нийтийн албаны эсэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Энэ төрлийн гэмт хэрэг гарах болсон суурь шалтгааныг илрүүлэх
- Тухайн гэмт хэрэг үйлдэгдэх болсон нөхцөл, шалтгааныг шийдвэрлэх арга замыг боловсруулах

Судалгааны хамрах хүрээ

Судалгааны хүрээнд нийт 21 эрүүгийн хэргийг тодорхой аргачлал, төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэргийн төрөл тус бүрт /эрүүгийн хэргийн архивт байгаа/ судалгаа хийсэн болно. Зөвхөн судалгаанд хамрагдсан буюу уншиж судалсан хэргийн хүрээнд судалгааны дүнг тодорхойлсон болно. Судалгааны ажлын урьдчилсан тайланг энэ чиглэлээр дагнан бие даан судалгаа хийдэг экспертүүдээр хянуулав. Экспертүүдээс ирүүлсэн санал, дүгнэлт зөвлөмж, тоон статистик үзүүлэлтүүдийг нэмж тусгалаа.

P.s: 2019 онд үйлдэгдсэн зарим хэргүүд нь эцэслэн шийдвэрлэгдээгүй, эрүүгийн хэргийн төв болон нийслэлийн архивт ирээгүй, ажиллагаанд буцсан зэргээс шалтгаалж судалгаанд хамруулах боломжгүй байсан болно.

Судалгааны арга зүй

Судалгааны ажлын зорилгоны хүрээнд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглав. Үүнд:

а.Тоон судалгаа: Судалгааны хүрээнд шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг тодруулах, түүнд дүн шинжилгээ хийхийн тулд цагдаагийн байгууллага, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас гаргадаг албан ёсны тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийв.

б.Чанарын судалгаа: Судалгааны зорилгын хүрээнд шийдвэрлэгдсэн эрүүгийн хавтаст хэрэг боловсруулсан асуулгын хүрээнд судлаж, тухайн хэргийн онцлогийг харгалзан

¹ Монголын Криминалогичдын холбоо, судлаач Г.Оюунболд 2019 онд ГХУСА33-ийн захиалгаар хийсэн.


цугларсан нотлох баримтыг үнэлсэн болно. Тухайлбал яллагдагч, гэрч, хохирогчийн мэдүүлэг, тодорхой төрлийн ажиллагаа, шүүхийн шийтгэх тогтоолыг түүвэрлэн авав. Мөн энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэсэн өмгөөлөгч, мөрдөгч, прокуроруудтай фокус бүлгийн ярилцлагын судалгаа явуулав.

Мэдээлэл боловсруулалт

Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг удирдамжид заагдсан аргачлалын боловсруулж, тайланг нэгтгэв.

II. Судалгааны дүн

НЭГ. МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН НИЙТИЙН АЛБАНЫ АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Зүйл, хэсэг	ЦБ	ПБ		Шүүх	
	Шинээр БГХ	Нийт ХБМБ явуулсан	Тайлант онд ШҮХ	Шийдвэрлэвэл зохих	Шийдвэрлэсэн
Бүлгийн дүн	237	509	393	105	89
23.1	85	154	125	82	73
23.2	137	303	230	20	14
23.3	8	22	17	1	-
23.4	-	11	7	-	-
23.5	5	17	12	3	2
23.6	-	-	-	-	-
25.7	2	2	2	-	-

- 23.4, 23.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 2018 онд ЦБ-д бүртгэгдээгүй байна.

- 23.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 2018 онд ПБ-д шийдвэрлэгдээгүй байна.

- 23.4, 23.6, 23.7 дугаар зүйлд заасан гэмт хэрэг 2018 онд шүүхэд шийдвэрлэгдээгүй байна.

Энэ бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд 237 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 25 хэргээр буюу 9.5%-иар, Нийслэлийн хэмжээнд 137 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 29 хэргээр буюу 17.4%-иар тус тус буурсан, орон нутагт 99 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 3 хэргээр буюу 3.1%-иар өссөн байна. ЦБ-д бүртгэгдсэн нийт 36220 хэргээс энэ бүлэгт заасан гэмт хэрэг 237 бүртгэгдсэн нь 0.65%-ийг эзэлж байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын хувь
	2017 он	2018 он		2017 он	2018 он	
Нийслэлд	166	137	-17.4	0.51%	0.37%	-0.14%
Орон нутагт	96	99	+3.1%	0.29%	0.27%	-0.02%
Улсын дүн	262	237	-9.5%	0.81%	0.65%	-0.16%

Холбогдогч (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ бүлэгт заасан гэмт хэрэгт нийт 119 хүнийг холбогдуулан МША явуулсан бөгөөд үүнээс 66 тохиолдол нь согтуугаар, 23 тохиолдол нь бүлэглэж, 9 тохиолдол нь урьд нь ял шийтгүүлсэн хүн үйлджээ.

Нийт холбогдогчоос 25-29, 30-34 насны хүмүүс энэ бүлгийн гэмт хэрэгт хамгийн их холбогдож байна. Эмэгтэй 26 хүн байгаа нь Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах (23.2), Хууль сахиулагчийг эсэргүүцэх (23.1) гэмт хэрэг дийлэнх нь байна. ГХИ 35.9%-тай, илрээгүй 139 хэрэг байна.

Хохирогч, хохирол (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ бүлэгт заасан гэмт хэргийн улмаас 176 хүн, хуулийн этгээд хохирч, үүнээс 3 нь хуулийн этгээд байна. Хохирогчдын дунд 25-29, 30-34 насны хүмүүс хохирсон үзүүлэлт өндөр байна. Энэ бүлгийн гэмт хэргийн улмаас учирсан 12157768535 төгрөгийн хохирлоос 119116000 төгрөг буюу нийт хохирлын 0.97%-ийг нөхөн төлүүлж, 35950001 төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

ПБ-аас энэ бүлэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 509 хэргийн ХБМБА-нд хяналт тавьжээ.

ШҮХ-т нийт 157 хүнийг яллагдагчаар татсан бол үүнээс 112 нь эрэгтэй, 44 нь эмэгтэй, урьд нь ял шийтгүүлж байсан 8 хүн, эрхэлсэн тодорхой ажилгүй 141 (89.8%) хүн байна. ПБ-ын бүртгэлээс үзвэл энэ бүлэгт заасан гэмт хэргийн улмаас 203 хүн, хуулийн этгээд хохирсноос 2 нь хуулийн этгээд, 3 хүн нас барсан, 42 хүн гэмтсэн гэж бүртгэсэн нь ЦБ-ын тоо бүртгэлээс харьцангуй зөрүүтэй байна.

Зүйл, хэсэг	Нийт ХБМБ явуулсан	Тухайн жил шинээрүүссэн	Шийдвэрлэлт					Үлдэгдэл хэрэг	
			ХБ-ийн хэрэг хаасан	Нэгтгэгдсэн	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн	Шүүхэд шилжүүлсэн	ХБ-ийн үлдэгдэл	МБ-ын үлдэгдэл
Бүлгийн дүн	509	393	190	3	15	0	109	171	21
23.1.	154	125	39	2	2	0	77	28	6
23.2.	303	230	123	1	13	0	25	129	12
23.3.	22	17	11	0	0	0	3	6	2
23.4.	11	7	6	0	0	0	2	3	0
23.5.	17	12	10	0	0	0	2	4	1
23.7.	2	2	1	0	0	0	0	1	0

ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Шүүхийн шатанд нийт шийдвэрлэвэл зохих 105 эрүүгийн хэргээс 89 эрүүгийн хэргийг шийдвэрлэж, үүнээс 1 хэргийг цагаатгажээ. Энэ бүлэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан нийт 79 хүн ял шийтгүүлсний 11 нь эмэгтэй, урьд нь ял шийтгүүлж байсан 16, хорих ялаар шийтгүүлсэн 14, үүнээс 2 нь эмэгтэй хүн байна.

Нийт ял шийтгүүлсэн 79 хүний тоон үзүүлэлтээс авч үзвэл 28 (35.4%) нь 35-с дээш насны, 26 (32.9%) нь 22-29 насны, 32 (40.5%) бүрэн дунд боловсролтой, 32 (40.5%) нь бакалаврын зэрэгтэй, 35 (44.3%) нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 7 (8.8%) нь ААН-ийн албан тушаалтан гэж бүртгэгдсэн нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэгчийн ерөнхий дүр зургийг харуулж байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ (хорих ял эдэлж буй ялтны үзүүлэлтээр)

Энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас нийт 2 хүн хорих ял эдэлж байна. Үүнээс 23.1 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас 2 хүн хорих ял эдэлж байна.


Хоригдлууд нь 26-33 насны, бүрэн дунд боловсролтой байна.

Шүүхийн тоо бүртгэлээс үзвэл энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэний улмаас ял шийтгүүлсэн 79 хүнээс 63 хүнд торгох ял, 2 хүнд НТАХЯ, 1 хүнд ХЧААХ хэрэглэхээр шийтгэсэн үзүүлэлт харагдаж байна.

Бүлгийн харьцуулсан үзүүлэлт

№	Нутаг дэвсгэрийн нэр	ЦБ (БГХ)	ПБ (ШҮХ)	Шүүх (шийдвэрлэсэн)
Орон нутаг		99	165	55
1	Архангай	5	9	0
2	Баян-Өлгий	10	23	1
3	Баянхонгор	3	12	5
4	Булган	5	11	6
5	Говь-Алтай	1	6	0
6	Говьсүмбэр	-	1	0
7	Дархан-Уул	6	8	3
8	Дорноговь	14	13	3
9	Дорнод	3	5	2
10	Дундговь	4	6	4
11	Завхан	5	7	3
12	Орхон	2	6	1
13	Өвөрхангай	2	4	1
14	Өмнөговь	5	5	2
15	Сүхбаатар	3	3	0
16	Сэлэнгэ	9	12	6
17	Төв	7	9	3
18	Увс	3	6	5
19	Ховд	7	10	4
20	Хөвсгөл	1	2	0
21	Хэнтий	4	7	6
Улаанбаатар хот		137	228	34
1	Тээврийн ПГ	-	5	-
2	Нийслэлийн ПГ	-	11	-
3	Багануур	8	8	7
4	Налайх, Багахангай	2 (2+0)	4	0 (0+0)
5	Баянгол	16	20	5
6	Баянзүрх	24	36	2
7	Сонгинохайрхан	9	13	6
8	Сүхбаатар	52	71	6
9	Хан-Уул	10	24	2
10	Чингэлтэй	16	36	6
Улсын дүн		237	393	89
Хилийн чанад		1	-	-

**Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэмт хэрэг
(Эрүүгийн хуулийн 23.2 дугаар зүйл)**



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА:

Энэ зүйлд заасан гэмт хэрэг нийслэлд 93 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 6 хэргээр буюу 6.06%-иар буурсан, орон нутагт 43 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 14 хэргээр буюу 48.27%-иар, улсын хэмжээнд 137 шинээр бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 9 хэргээр буюу 7.03%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

ЦБ-д бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (36220)-ийн 0.37%-ийг энэ зүйлд заасан гэмт хэрэг дангаараа эзэлж байна.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралт	Нийт хэрэгт эзлэх хувь		Өсөлт, бууралтын хувь
	2017 он	2018 он		2017 он	2018 он	
Нийслэлд	99	93	-6.06%	0.30%	0.25%	-0.05%
Орон нутагт	29	43	+48.27%	0.08%	0.11%	+0.03%
Улсын дүн	128	137	+7.03%	0.39%	0.37%	-0.02%

Холбогдогч: (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ зүйлд заасан гэмт хэрэгт нийт 32 хүнийг холбогдуулан МША явуулсан бөгөөд үүнээс 16 тохиолдол (50%) нь эмэгтэй хүн, 5 тохиолдол нь бүлэглэж үйлджээ.

Нийт холбогдогчоос 25-29, 30-34 насны хүмүүс энэ бүлгийн гэмт хэрэгт хамгийн их холбогдож байна.

ГХИ 17.8%-тай, илрээгүй 111 хэрэг байна.

Хохирогч, хохирол (ЦБ-ын тоо бүртгэл)

Энэ зүйлд заасан гэмт хэргийн улмаас 83 хүн, хуулийн этгээд хохирч, үүнээс 3 нь хуулийн этгээд байна.

Хохирогчдын дунд 25-29, 30-34 насны хүмүүс хохирсон үзүүлэлт өндөр байна.

Энэ зүйлд заасан гэмт хэргийн улмаас учирсан 11723430535 төгрөгийн хохирлоос 80141000 төгрөг буюу нийт хохирлын 0.68%-ийг нөхөн төлүүлж, 12600000 төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

ПБ-аас энэ зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан улсын хэмжээнд нийт 303 хэргийн ХБМБА-нд хяналт тавьжээ.

ШҮХ-т нийт 56 хүнийг яллагдагчаар татсан бол үүнээс 29 нь эрэгтэй, 26 нь эмэгтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй 53 (94.6%) хүн байна.

ПБ-ын бүртгэлээс үзвэл энэ зүйлд заасан гэмт хэргийн улмаас 80 хүн, хуулийн этгээд хохирсноос 2 хуулийн этгээд байна гэж бүртгэсэн нь ЦБ-ын тоо бүртгэлээс харьцангуй зөрүүтэй байна.

Зүйл, хэсэг	Нийт ХБМБ явуулсан	Тухайн жил шинээр үүссэн	Шийдвэрлэлт					Үлдэгдэл хэрэг	
			ХБ-ийн хэрэг хаасан	Нэгтгэгдсэн	Хэрэгсэхгүй болгосон	Түдгэлзүүлсэн	Шүүхэд шилжүүлсэн	ХБ-ийн үлдэгдэл	МБ-ын үлдэгдэл
Бүлгийн дүн	509	393	190	3	15	0	109	171	21
23.2.	303	230	123	1	13	0	25	129	12

ШҮҮХИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Шүүхийн шатанд нийт шийдвэрлэвэл зохих 87 эрүүгийн хэргээс 72 эрүүгийн хэргийг шийдвэрлэж, үүнээс 1 хэргийг цагаатгажээ.

Энэ зүйлд заасан гэмт хэрэгт холбогдуулан нийт 32 хүн ял шийтгүүлснээс урьд нь ял шийтгүүлж байсан 13, хорих ялаар шийтгүүлсэн 1 хүн байна.

Нийт ял шийтгүүлсэн 32 хүний тоон үзүүлэлтээс авч үзвэл 22 (68.75%) нь 35-с дээш насны, 9 (28.1%) нь 30-34 насны, 17 (53.1%) бүрэн дунд боловсролтой, 12 (35.5%) нь бакалаврын зэрэгтэй, 26 (81.2%) нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 34 (17.9%) нь малчин, 2 (6.2%) нь ААН-ийн албан тушаалтан гэж бүртгэгдсэн нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэгчийн ерөнхий дүр зургийг харуулж байна.

ХОЁР. ЭРҮҮГИЙН ХАВТАСТ ХЭРЭГТ ХИЙСЭН СУДАЛГАА

Судалгааны хүрээнд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хойш шийдвэрлэгдсэн НИЙТИЙН АЛБАНЫ АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ нийт 21 эрүүгийн хэргийг хамруулсан болно. Үүнд: ЭХТА-ийн 23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх, 23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах, 23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух, 23.4 дүгээр зүйл.Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх, 23.5 дугаар зүйл.Хайнга хандах гэсэн хэргүүдийг судлав. Харин ЭХТА-ийн 23.6 дугаар зүйл.Хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах, 23.7 дугаар зүйл.Нийтийн албан тушаалтныг заналхийлэх гэсэн хэргүүд шүүхээр шийдвэрлэгдээгүй байх тул уншиж судлах боломжгүй байлаа.

№	Зүйл, хэсэг, заалт	Судалсан хэрэг
1	ЭХТА-ийн 23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх	8
2	23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	6
3	23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух	4
4	23.4 дүгээр зүйл.Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх,	1
5	23.5 дугаар зүйл.Хайнга хандах	6

2.1. ЭХТА-ийн 23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх

Дээрх хэргийг судлан үзвэл Хууль сахиулагчийг эсэргүүцэх, Хуурамч баримт бичиг үйлдэх гэмт хэргүүд түгээмэл гарч, шийдвэрлэгддэг байх ба цагдаагийн алба хаагчдын хувьд түгээмэл хохирч байна. Цагдаагийн болон бусад хууль сахиулагчийн зан үйлийн горим, дүрэм журам тодорхой бус байгаагаас эсэргүүцсэн хүнд биеийн хүч, албадлага, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж чадахгүй байдал нийтлэг ажиглагдлаа. Мөнхууль сахиулагчийн нэг бүрийн тусгай хэрэгслийн хангалт түүнийг хэрэглэх дадал чадвартай ч холбоотой байна.

Хэргийн дугаар: 2019.....ЭХТА-ийн 23.1 дүгээр зүйл.Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг: Холбогдсон хэргийн талаар: Шүүгдэгч Б.Э, Д.О нар нь бүлэглэн 2019 оны 01 дүгээр сарын 09-нөөс 10-нд шилжих шөнө 06 цагийн үед Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Benz /Бенз/ нэртэй караокены гадна талд Баянгол дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Б.Т, цагдаагийн ахлах ахлагч Б.Э, эргүүлийн офицер, цагдаагийн ахмад Э.М нарыг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэн эсэргүүцэж биед нь халдаж цагдаагийн алба хаагч нарын шар өнгийн хантаазыг урж нийт 271.200 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Хохирогч мэдүүлэхдээ: Нарлаг цагдаагийн хэсэгт 24 цагийн үүргийг цагдаагийн дэд ахлагч Б.Т-гийн хамт гүйцэтгэн ажиллаж байхад 06 цагийн орчимд гаднаас үл таних хүн орж ирээд Бенз караокенд зодоон болоод байна гэсэн. Тэгээд би д/а Т-гийн хамтаар Бенз караоке дээр очиход гадаа нь 3 залуу байхаар нь Т юу болсон талаар асуухад зүүн нүд нь цус болчихсон хүрэн өнгийн ноосон цамцтай залуу чулуу барьсан гараараа Т-гийн дух руу цохисон. Тэгэхээр нь би очоод яагаад цагдаагийн алба хаагчийн биед халдаж байгаа юм бэ гээд шаардлага тавихад

тэр залуу би бүгдийг чинь ална гэсэн. Тэгсэн хажууд нь байсан цэнхэр куртиктэй залуу алаад өгье гээд Т-гийн энгэрийн камерийг аваад шидчихсэн тэгээд бид хоёр луу газраас чулуу, тоосго аваад шидэж эхэлсэн. Тэгээд нилээн хэдэн чулуунд оногдоод тухайн залуучуудыг барьж авах гэхэд зүүн нүд нь цус болчихсон залуу гартаа чулуу барьж байгаад миний баруун гарын сарвуу, булчин хэсэг рүү цохиод байсан.

“Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийн шалтгаан, нөхцлийн тухайд урьд энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан эсхүл захиргааны хяналтанд байсан хүний зүгээс үйлдэх нь их байна. Түүнчлэн, Цагдаагийн алба хаагч болон бусад хууль сахиулагчийн зүгээс албан үүргээ гүйцэтгэх үедээ тухайн нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэж чадаагүйн улмаас гэмт хэргийн хохирогч болсон нөхцөл нийтлэг ажиглагдаж байна. Үүний шалтгаан нь зөрчил гаргагчид биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэсэн тохиолдолд байгаа тодорхой журам нь алба хаагчийн эрх зүйн хамгаалалт болж чадахгүй, өөрсдөө эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдах явдал их байгаагаас аль болох зөрчил гаргагчид биеийн хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх явцдаа гэмт халдлагад өртдөг байна.

Цагдаагийн албаны хууль болон зөрчил, гэмт хэргийг шалган шийдвэрлэх процессын хуульд хэв журам сахиулах чиглэлээр хийж гүйцэтгэх хууль сахиулагчийн зан үйл, албдалга тэдгээрийн дэс дараалал тодорхой бус байна. Нийгэмд хууль сахиулагчаас авч хэрэгжүүлэх нийтлэг албадлага болох биеийн хүч, нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх нь хүний эрхийн зөрчил гэсэн хандлага хүчтэй байгаагаас тавьсан шаардлагыг эсэргүүцэх, улмаар хүч хэрэглэн довтолох, амь бие, эрүүл мэндэд халдах тохиолдол судалсан хэргээс нийтлэг ажиглагдлаа.

Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага.

Цагдаагийн алба хаагч Г: Хэдийгээр манай албаны журамд зөрчил гаргасан хүнд биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх талаар тодорхой журам байдаг ч энэ нь дараа нь бидний буруутгахад хамгаалалт болж чаддаггүй. Энэ байдлаар буруутгагдсан алба хаагч байдаг. Иймд шаардлага тавих явцдаа илэрхий хүч хэрэглэж эсэргүүцээгүй л бол биеийн хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэхийг оролддог. Гэтэл ихэнхидээ зүй ёсны шаардлага тавих явцад албан үүрэгтэй холбогдуулан шууд халдан довтолдог.

Цагдаагийн алба хаагч Д: Нэг бүрийн тусгай хэрэгслийн хангалт хүрэлцээгүйгээс ердөө нүцгэн гараараа тулах хэрэг ч гардаг. Хэдийгээр гав, бороохой байдаг ч бүгдэд хүрэлцдэггүй. Илэрхий бүлэглэн эсэргүүцэж хүч хэрэглэх үед цахилгаанаар цохигч болон гааз, үрлэн сумтай буу хэрэг болдог. Нөгөө талаас алба хаагчийг буюу хууль сахиулагчийг эсэргүүцсэн үед шууд авах арга хэмжээг код, журмаар биш хуулиар зохицуулах шаардлагатай.

Өмгөөлөгч Ц: Хууль сахиулагчийг эсэргүүцэх хэргийг ихэнхи нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлддэг. Илэрхий эрүүл саруул байхдаа хууль сахиулагч руу халдаж, эсэргүүцэх тохиолдол бараг байдаггүй. Гэтэл хууль сахиулагчийг эсэргүүцсэн согтуу хүн дараа нь албадлага хэрэглэх явцад эсхүл өөрөө гэмтэлтэй холбоотойгоор тухайн албаны дотоод хяналт, шалгалтад гомдол гаргадаг. Хууль сахиулагчийг эсэргүүцэж болохгүй гэдгийг ер нь бүгд мэддэг боловч согтуудаа өөрийгөө хянах чадвараа алдаж энэ хэргийг их үйлддэг.

Эргүүлийн цагдаа Б: ЦБ-ын тухай хуулинд л үйлчилгээг тусад нь заагаад өгчих хэрэгтэй. Олон нийтийн үйлчилгээний байгууллага гэж зарласныг буруу ойлгосон. Яаруу ийм шийдвэр гаргасан. “Үйлчлэх” гэдэг нь үүргийн нэг төрөл болохоос гол зүйл биш, бас албадах ч үүрэг цагдаад байдаг юм. Өрөөсгөл сурталчилгаа явсан. Манай Цагдаагийн PR муу байна. Түүнчлэн, уншиж судалсан хоёр эрүүгийн хэрэгт биеийн хүч хэрэглэх, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх дүрэм журмаа сайтар ойлгоогүй, түүнийг хэрэглэж талаар албаны сургалтанд хамрагдаж байгаагүй нь тогтоогдов. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах чиг үүргийг гүйцэтгэхэд асуудалд орсон, эрсдэл учруулж болзошгүй, бухимдалтай хүмүүстэй байнга харьцдаг учраас цагдаагийн алба хаагч өөрөө эрсдэл бүхий орчин, нөхцөлд үүрэг гүйцэтгэж байна.

2.2.ЭХТА-ийн 23.2 дугаар зүйл.Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах

Мэдээллийн техник, технологийн ололтыг ашиглаж, төрийн бүртгэлийн системийн хяналт сул далимдуулж төрийн зүгээс эх олгож үүргээс чөлөөлсөн баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг түгээмэл гарах болжээ. Энэ нь тодорхой төсөл, тендерт өрсөлдөх, гадаад улсад ажиллахаар виз мэдүүлэх, боловсорлын байдлыг хуурмаглах зэрэг хэлбэртэй байна.

Нэн ялангуяа мэргэжил, боловсорлын зэргийг нотолсон баримт бичгийг хуурамчаар үйлдэж мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын бүртгэлийн системээс энэхүү хууль бус үйлдэл нь илэрч баригдсан тохиолдол ч байна.

Кейс: Яллагдагч Б нь “Э” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Задгай болон савалгаатай фемент ачиж буулгах байгууламжийн төсөл”-д зориулан 300 сая төгрөгийн хөнгөлөлттэй нөхцлийн зээлийг Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас авах зорилгоор зээл, төслийн материал бүрдүүлж өгөхдөө Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 000 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8-д заасан “Харилцдаг татварын байгууллагын татварын өргүй талаарх тодорхойлолт”-ыг 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдөр ... дүүргийн ... дугаар хороо, Ажилчны 1 дүгээр гудамж, “Э” төвийн 000 тоотод байрлах өөрийн компанийн байранд цахим хэрэгсэл ашиглан Татварын ерөнхий газрын цахим төлбөрийн баримтын системд нэвтрэн “Э” ХХК-ийн татварын албанд 27.294.215 төгрөгийн өртэй гэсэн тодорхойлолтыг хэвлэн авч, мөн өдрийн байдлаар татварын өр төлбөргүй болгон бүртгэлийн бар кодыг засварлах зэргээр үүргээс чөлөөлсөн баримт бичгийг хуурамчаар үйлдэж, 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдөр Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд төслийн материалын хамт өгч ашигласан гэх гэмт хэрэг үйлджээ.

Дээрхи хэргийн гэрчээс “Миний хувьд судлаад хуралд оруулах үгүйг шийдээд миний ажил дуусдаг. ...Би хуралд оролцож шийдвэр гаргадаггүй. “Э” ХХК-ийн зээл хүссэн төслийн материалд ямар нэгэн бичиг баримт хуурамч байсан эсэхийг мэдэхгүй байна. Манайд ирдэг зээл хүссэн материалууд нь зарим эх хувиараа, зарим нь хуулбарлан авчирсан, зарим нь интернэтээс хэвлээд авчирсан, зарим нь ТҮЦ /Төрийн үйлчилгээний цахим- машинаас хэвлэн авчирсан байдаг учир ямар нэгэн байдлаар хуурамч эсэхийг нь мэдэх боломж байдаггүй юм...” гэснээс үзэхэд хуурмагласан баримт бичгийг үнэн зөв эсэхийг мэдэх ур чадвар, техникийн боломж, нэгдсэн бүртгэлд орж хандах боломж төрийн алба хаагчдад байхгүй байгааг харуулж байна.

Төрийн албаны зүгээс иргэд байгууллагад гаргаж өгдөг зарим тодорхойлолт, баримт бичгийг цахим хэлбэрээр, эсхүл ТҮЦ машинаас өгдөг болсон зэргээс хамаараад түүнийг тулгаж хянадаг тогтолцоо байхгүй нь эргээд энэ гэмт хэргийн суурь шалтгаан болж байна.

Мөн хууль бус зар сурталчилгаанд тавих хянал дутмаг, хүнийг аливаа байдлаар ажилд авахад тухйн баримт бичгийг үнэн зөв эсэхийг шалгадаг төрийн албан хаагч, иргэдэд зориулсан цахим бүртгэлийн систем хөгжөөгүй учраас өөрөө гэмт хэрэгт холбогдон шалгагдах тохиолдол гарч байна. Тухайлбал, Ч.Н нь /17110..... дугаартай эрүүгийн хэрэг/ 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын ... дугаар сургуульд нийгмийн ажилтнаар ажилд орохдоо Монгол Улсын Их Сургуулийг 2007 онд “Нийгмийн ажилтан” мэргэжлээр суралцаж төгссөн гэх D2007... дугаартай бакалаврын дипломыг хуурамч гэдгийг мэдсээр байж ашигласан гэмт хэрэгт холбогджээ.

Ч.Н мөрдөн шалгах ажиллагаанд мэдүүлэхдээ: “...Би 2003 онд Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургуульд сурч байгаад 2004 онд сургуулиа хаяад бизнес хийсэн юм. Тэгээд наймаа хийж байгаад 2007 онд 40 орчим насны эгчтэй “диплом гаргана” гэсэн зарын дагуу утас руу нь ярьж танилцсан юм. Ямар сонин гэдгийг одоо санахгүй байна, сонинд гарсан “диплом гаргана” гэсэн зарын дагуу холбогдсон юм. Тэгээд тэр эгч надад 3,000,000 /гурван сая/ төгрөг өгчих би Монгол Улсын Их Сургуулийг төгсгөөд өгье гэж хэлээд мөнгө авч явсан. Тэгээд би сургуульд очиж сураагүй байж байхад хавар надад диплом чинь гарчихсан гэж хэлээд Монгол Улсын Их Сургуулийн нийгмийн ажилтны диплом авчирч өгсөн. Тухайн үед би хуурамч эсэхийн шалгаагүй аав, ээждээ үзүүлээд тэгээд ашиглаагүй юм. 2015 онд уг дипломоор Төв аймагт очиж Төрийн албаны шалгалт өгсөн. Тэгээд 2015 оны 11 сарын үед “Улаанбаатар” банкны 4 давхард байдаг нотариатад очиж батлуулах гэтэл хуурамч байна. гэж хурааж аваад Чингэлтэй дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст шалгагдаад дипломыг устгаж намайг явуулсан. Би тухайн дипломоор 2012 онд “Цэцэг Гүн” дээд сургуулийн магистрын ангид элсэн орж төгссөн. Тэгээд 2016 онд Нийслэлийн 138 дугаар сургуульд ажилд орох гэж нөгөө хуурамч дипломын канондсон хуулбараар нь шалгалт өгсөн.” гэж мэдүүлжээ.

Төрийн албанд ашигладаг бүртгэлийн систем²-ийг ашиглан хуурамч баримт бичиг үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх боломж бага байдаг тухай ярилцлагын судалгаанд оролцогчид тодорхой баримттай өгүүлсэн болно. Тухайлбал, урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан хуурамч баримт бичиг үйлдэх замаар гэрээ, хэлцэл хийж залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэж байна.

Урьд хийгдсэн криминологийн судалгаагаар “хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах”, “залилах” гэмт хэргийн суурь шалтгааныг иргэдийн гэнэн итгэмтгий байдал, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэтгэлгээ, хууль бус зар сурталчилгаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна гэж тодорхойлсон боловч нийгэм эдийн засгийн болон хувь хүнээс үүдэлтэй суурь шалтгааныг үндсэндээ дурдаагүй байх юм. Энэ талаар хийгдсэн судалгааны ажлаас болон шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн судалгаанаас үзвэл дараахь үндсэн суурь шалтгаан тодорхойлогдож байна. Үүнд:

1.Иргэд иргэний эрх зүй, эдийн, санхүүгийн суурь мэдлэг дутмаг байгаагаас хуурамч баримт бичиг үйлдэх ашиглах, залилан мэхлэх гэмт хэрэгт өртөж байна.

2.Худалдаа үйлчилгээ, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө зуучлал зэргийн талаар суурь мэдлэггүйгээс хувь хүн өөрөө дур мэдэн хувь хүнээс зээл авах, зээлэх, эсхүл өөрийн үл хөдлөх хөрөнгөө эрсдэл үл харгалзан зарж борлуулах гэх зэргээр хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах, залилан мэхлэх гэмт хэрэгт ихээр өртөж байна.

3. Төрийн албанд ашигладаг бүртгэлийн систем сул, хуурамч баримт бичгийг илрүүлэх, түүнийг богино хугацаанда шалгах боломж тааруугаас энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

2.3.ЭХТА-ийн 23.3 дугаар зүйл.Баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт хулгайлах, устгах, гэмтээх, нуух

Нийтийн албанд гарч байгаа энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг судлан үзэхэд үзэхэд албан тушаал буурах, эсхүл ажлаас халагдах тохиолдолд тухайн ажлын байраа хүлээлгэн өгөхгүй байх, нийтийн албаны үйл ажиллагаа явуулах, өөрт ашигтай шийдвэр гаргуулахад нөлөөлөх зорилгоор үйлдэх нь түгээмэл байна.

Тухайлбал, Шүүгдэгч Х.Ө нь 2017 оны ... дугаар сарын ...-ний өдөр аймгийн засаг даргын Б/30 дугаартай захирамжаар аймгийн тосгоны цэцэрлэгийн эрхлэгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш ажлаа хүлээлцүүлж өгөлгүйгээр тухайн байгууллагын эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тэмдэгийг зориуд нуусан гэмт хэрэгт холбогджээ. Х.Ө-гийн ажлыг хүлээлцүүлэхээр 11 дүгээр цэцэрлэг дээр очсон боловч ажлын байран дээрээ байхгүй, өрөө нь цоожтой, олон хоног хөөцөлдөж орон гэрт нь хүртэл очсон боловч тухайн үед гэртээ байхгүй, гар утас руу нь залгасан боловч холбогдохгүй 2 сар гаран болсон. Цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн бус явагдаж, төрийн сангаас мөнгө, төгрөгний гүйлгээ зогсож, цэцэрлэгийн багш, ажилчдын цалин хөлс болон цэцэрлэгийн хүүхдүүдийн хоол болон бусад зардлыг хэсэг хугацаанд огт шийдвэрлээгүй байжээ. Шүүхийн шийтгэх тогтоолд гэмт хэрэг гарахад төрийн албан хаагч, ёс зүйн хэм хэмжээгээ зөрчсөн, үүргээ ухамсарлахгүй байгаа зэрэг өөрөөс нь шалтгаалсан нөхцөл байдлууд нөлөөлснийг тэмдэглэх нь зүйтэй гэсэн байна.

Төрийн алба хаагчийг төрийн албанд авах, сахилга ёс зүйн хариуцлага тооцох процедур судалгааны ажлын тайлан бичих явцад ч тодорхой бус байсан бөгөөд төрийн албаны төрөл, онцлогоос шалтгаалж, төрийн албад гардаг сахилгын зөрчлийг нотлож, сахилгын хариуцлага хүлээлгэх тогтолцоо өөр байдаг нь энэ төрлийн гэмт хэрэг суурь шалтгаан болсоор байна. Судалгааны ажлын явцад Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн гарч хэрэгжиж эхэлсэн боловч дээрхи асуудлыг хараахан шийдвэрлээгүй байна.

Мөн бусад гурван эрүүгийн хэрэгт хулгайлах гэмт хэргийг үйлдэх явцдаа бусдын баримт бичгийг хулгайлж, ашиглан залилах, завших хэргүүдийг давхар үйлдсэн байна. Өөрөөр хэлбэл бусдын иргэний үнэмлэх, банкны зээлийн картыг хулгайлсны дараагаар түүнийг ашиглан банкны теллерийг залилах, эсхүл зээлийн картыг ашиглан худалдааны болон үйлчилгээний байгууллагад тооцоо хийх зэргээр давхар гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн байна.

² <http://uda.ub.gov.mn/?p=1442>

ЭХТА-23.4 дүгээр зүйл.Улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх

Дээрхи гэмт хэргийг шийдвэрлэсэн нэг тохиолдол байсан ба бусад байдлаар шийдвэрлэсэн хэрэг эрүүгийн хэргийн архивт шилжин ирээгүй байна. шийдвэрлэсэн хэргийг судлан үзэхэд авлига албан тушаалын гэмт хэрэгтэй давхар зүйлчлэгдсэн шийдвэрлэгдсэн байх ба тодорхой нөхцлөөр зээл авахын тулд төрийн албан хаагчид хээд хахууль өгч төрийн албан мэдээллийн санд худал мэдээлэл оруулах гэмт хэргийг үйлдсэн байна.

Кейс: *Шүүгдэгч Я.Б-г хахууль авсан, Л.Х, Б.А Э.Б-г хахууль өгсөн, Э.Б-г улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичгийг үйлдсэн, хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тус тус тооцжээ.Энэ тохиолдолд бүртгэл судалгаа хариуцсан ажилтанд тавих хяналт сул байгаагаас дэрх гэмт хэрэг гарчээ.*

Түүнчлэн, зарим тохиолдолд шуурхай зээл олгодог, гадаад улсын виз мэдүүлэх үйл ажиллагаа зөвшөөрөлгүй эрхэлдэг нэр бүхий хүнтэй хамтран эсхүл тэдгээрийн захиалгаар эсхүл арилжааны банкнаас зээл авч буй иргэдэд улсын бүртгэлд хуурамч мэдээлэл оруулж өгснийхөө төлөө шан харамж авсан байна. Өөрөөр хэлбэл дээрхи хэргийг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгохын тулд үйлджээ. Энэ нь цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлоготой хослуулах шаардлагатайг харуулж байна.

ЭХТА-ийн 23.5 дугаар зүйл.Хайнга хандах

Шүүгдэгч Х.Ж нь Төрийн банкны аймгийн тооцооны төвийн теллерээр ажиллаж байх хугацаандаа албан тушаалын байдлаа ашиглаж, бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг завшиж банкны нэр бүхий харилцагчийн нэр дээр тэдний өмнөөс хуурамч материал бүрдүүлэн, гарын үсгийг хуурамчаар зурж, 9 удаагийн үйлдлээр тэтгэврийн, цалингийн, малчны зээл болон хадгаламж барьцаалж, депозит данснаас бэлнээр мөнгө гаргаж нийт 18 459 519 төгрөгийн хохирлыг төрийн банкинд учруулсан,

Шүүгдэгч Л.З нь Төрийн банкны аймгийн тооцооны төвийн салбарын Захирлаар ажиллаж байх хугацаандаа албан тушаалын байдлаа ашиглаж, бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг завшиж банкныхаа нэр бүхий 43 харилцагчийн нэр дээр тэдний өмнөөс хуурамчаар материал бүрдүүлэн, гарын үсгийг хуурамчаар зурж, 59 удаагийн үйлдлээр тэтгэврийн, цалингийн, малчны зээл болон хадгаламж барьцаалж, мөн хадгаламж, харилцах болон депозит данснаас бэлнээр мөнгө гаргаж Төрийн банкинд 249 523 030 төгрөгийн болон хохирогч Г.Д-д 4 839 383 төгрөгийн, хохирогч С.Эд 3 000 000 төгрөгийн, хохирогч Г.Бийн 1 655 788, хохирогч Ц.Бд 3 877 474 төгрөгийн, нийт 262 895 675 төгрөг буюу их хэмжээнээс дээш хохирол учруулсан,

Шүүгдэгч Б.У нь Төрийн банкны ... аймгийн ... тооцооны төвийн теллерээр ажиллаж байх хугацаандаа хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бусдад 213 812 100 төгрөгийн хохирол буюу их хэмжээний хохирлыг төрийн банкинд учруулсан гэмт хэрэг үйлджээ. /Яллах дүгнэлтэд бичигдсэнээр/

Шүүгдэгч Б.У мэдүүлэхдээ: “Анх 2012 онд сургуулиа төгсөж ирээд 2012 оны 7 сард Хадгаламж банк байхад нь Төрийн банкинд орж байсан. Би банкны мэргэжилтэй хүн биш. Эдийн засгийн сургууль төгссөн гэж шалгалт өгөөд орж байсан. Надад ямар нэгэн сургалт, заавар зөвлөмж өгч байгаагүй. Манай зээлийн эдийн засагч дарга хэлэхэд ингэж явдаг юм байна гэж бодсон. Би 2012 онд ороод 2 хүүхдээ гаргаад 2 жил ажилласан. Ажиллаж байх хугацаанд 3 сар тутам Төрийн банкнаас шалгалт ирж шалгадаг. Жилд 1 аудит ирж шалгадаг. Шалгалтаар ийм асуудал гарлаа гэж байгаагүй болохоор ийм байдлаар явагддаг юм байна гэж бодсон. 2017 онд жирэмсний амралтаа аваад төрөх гэж байтал банкнаас шалгалтын хүмүүс ирээд ийм асуудал үүссэн. гэж мэдүүлжээ.

Дээрхи нөхцөл байдлаас дүгнэн үзэхэд албаны чиг үүрэгтээ хайнга хандсаны улмаас арилжааны банкны салбар болон аж ахуйн нэгжид залилах завших, үрэгдүүлэх гэмт хэрэг гарахад хүргэх тохиолдол нийтлэг байна.

Мөн судалсан хэргийн 3/1 орчим тохиолдолд хууль сахиулагчийн зүгээс албандаа хайнга хандсан үндэслэлээр холбогдон шалгагдаж ял шийтгүүлжээ. Үүнд тахарын албаны нэг, цагдаагийн алба хаагч ял шийтгүүлсэн тус бүр хоёр тохиолдол байгаагаас дуудлагаар очиж хүнийг эрүүлжүүлэх, түр саатуулах тохиолдолд албандаа хайнга хандсаны улмаас хүн нас барсан, эрүүл мэндэд хүнд хохирол учирчээ.

Шүүгдэгч Монгол Улсын иргэн Б.С, ... дүүрэг дэх Цагдаагийн 3 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасагт эргүүлийн офицер, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамтран эргүүлийн офицерийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа “Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль”, Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны 629 дугаартай “Албадан эрүүлжүүлэх” код журамд заасан үүргээ биелүүлээгүй буюу согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн Н.У-г эрүүлжүүлэх байр эсвэл хамгаалах хүнд хариуцуулж өгөөгүйн улмаас 2018 оны 10 дугаар сарын 02-ноос 03-нд шилжих шөнө ... дүүргийн ... дүгээр хороо, ... гудамжинд Н.У нь осгож нас барсан гэмт хэрэгт холбогджээ. Хэргийн нөхцөл байдлыг судлан үзвэл хууль сахиулагчаас авч хэрэгжүүлэх ёстой арга хэмжээний талаар цагдаагийн үйл ажиллагааны журамд нарийвчлан заагаагүйгээс тухайн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна. Хууль сахиулагчдын зүгээс ч дээрхи код болон бусад баримт бичиг хууль ёсны ажиллагааг зөвтгөх үндэслэл болохгүй зарим тохиолдолд өөрсдөө буруудач гол шалтгаан болж байгаа гэж өгүүлж байсан.

Ярилцлагын судалгаа: Цагдаагийн алба хаагч Д өгүүлэхдээ “Согтуу, биеэ авч явах чадваргүй хүнийг эрүүлжүүлэх ажиллагааг манай алба хаагч хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн. Гэтэл одоо өөрсдөө шалгагдаж байгаа. Тухайн үед дээрхи үйлдлийг камераар бичиж баримтжуулаагүй учир бид өөрсдөө буруутгах нөхцөл үүсээд байна. Алба хаагчийг энгэрийн камер бусад агсамжаар хангаагүй байж эргээд биднээс ийм зүйл нэхэж байгаа нь утгагүй. Зөрчил гаргагчийн эрх гэж ярьдаг мөртлөө цагдаагийн алба хаагч, хууль сахиулагчийн эрхийн талаар хэн ч ярьж, хамгаалахгүй байгаа нь харамсалтай.”

Цагдаагийн алба хаагч Ш: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүнийг түр болон удаан хугацаагаар саатуулах тухай зохицуулалт боломжийн. Гэтэл амьдрал дээр хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах явцад гарч байгаа нийтлэг тохиолдолд эдгээр хуулийн аль зохицуулалтад хамрагдахгүйгээр хүнийг эрүүлжүүлэх, цагдаагийн байгууллагад арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Цагдаагийн албаны хууль дээр тодорхой зохицуулалт бий боловч үндэслэл, журмууд нь тодорхой бус байна. Олон код, журамтай ба алба хаагчид тэр бүр танилцаж чаддаггүй учраас алдаа гаргаж албандаа хайнга хандсан гэдлгээр шалгагддаг.

Цагдаагийн алба хаагч Ж: Сургалт хангалтгүйгээс өөрсдөө албандаа хайнга хандсан гэж шалгагддаг шүү дээ. Ер нь цагдаагийн албаны дотоод сургалт гэж ор нэр төдий байгаа нь утгагүй, үр дүнгүй байна. Бусад оронд алба хаагч заавал жилд нэг сараас дээш хугацаагаар орчноосоо хөндийрч сургалтанд хамрагддаг. Ингэхдээ хийвэл зохих үйлдэл, алдадлага бусад шаардлагатай зүйлсийн талаар үргэлж суралцаж, дэдлагажиж байдаг. Хуулийн шинэчлэлтийг гүйцэж амжихгүй ойлгох ядаж байтал ахиад л нэг хууль, журам гардаг. Анх сургууль төгссөнөөсөө хойш нэг ч сургалтанд суугаагүй арав хорин жил болсон алба хаагчид байдаг нь нууц биш. Мэдлэг, үр чадвар гэдэг зүйлийг байнга шинэчилж байх шаардлагатай.

Дүгнэлт

1. Иргэд иргэний эрх зүй, эдийн, санхүүгийн суурь мэдлэг дутмаг байгаагаас хуурамч баримт бичиг үйлдэх ашиглах, залилан мэхлэх гэмт хэрэгт өртөж байна. Худалдаа үйлчилгээ, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө зуучлал зэргийн талаар суурь мэдлэггүйгээс хувь хүн өөрөө дур мэдэн хувь хүнээс зээл авах, зээлэх, эсхүл өөрийн үл хөдлөх хөрөнгөө эрсдэл үл харгалзан зарж борлуулах гэх зэргээр хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах, залилан мэхлэх гэмт хэрэгт ихээр өртөж байна.

2. Энэ төрлийн гэмт гаралт нэмэгдэж хууль сахиулагчид холбогдон шалгагдаж байгаа нь хууль сахиулах албаны үйл ажиллагааны журам тодорхой бус байгаатай холбоотой байна. Үүний шалтгааныг цагдаагийн алба хаагчдын хувьд хууль эрх зүйн орчин тодорхой бус байна гэж үзжээ. Мөн хуульд заасан нэрлэн журмууд хэрэгжих боломж тааруу, эрх зүйн орчинд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна. Тухайлбал, хуульд заасан журмыг хэрэгжүүлэх албан бичиг баримт, маягууд нь хэт нуршуу, техник ажиллагаа их шаарддагаас алба хаагчид залхах, төвөгшөөх байдал гарч, үйл ажиллагааны журамтайгаа гүйцэд танилцаагүй байна.

3. “Хууль сахиулагчийг эсэргүүцэх” гэмт хэргийн шалтгаан, нөхцлийн тухайд урьд энэ төрлийн зөрчил, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан эсхүл захиргааны хяналтанд байсан хүний зүгээс үйлдэх нь их байна. Түүнчлэн, Цагдаагийн алба хаагч болон бусад хууль сахиулагчийн зүгээс тухайн нөхцөд байдлыг зөв үнэлж дүгнэж чадаагүйн улмаас гэмт хэргийн хохирогч болсон тохиолдол нийтлэг байна. Үүний шалтгаан нь биеийн хүч, тусгай хэрэгсэл

хэрэглэсэн тохиололд тодорхой журам нь алба хаагчийн эрх зүйн хамгаалалт болж чадахгүй, өөрсдөө хэрэгт холбогдон шалгагдаж байгаагаас аль болох зөрчил гаргагчид хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх явцдаа гэмт халдлагад өртөж байна.

4. Мэдээллийн техник, технологийн ололтыг ашиглаж, төрийн бүртгэлийн системийн хяналт сул далимдуулж төрийн зүгээс эх олгож үүргээс чөлөөлсөн баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэмт хэрэг түгээмэл гарах байна. Энэ нь тодорхой төсөл, тендерт өрсөлдөх, гадаад улсад ажиллахаар виз мэдүүлэх, боловсролын байдлыг хуурмаглах зэрэг хэлбэртэй байна. Түүнчлэн, эрх олгож, үүргээс чөлөөлсөн баримт бичгийг үнэн зөв таньж эсэхийг мэдэх ур чадвар, техникийн боломж, нэгдсэн бүртгэлд орж хандах боломж төрийн алба хаагчдад байхгүй байна.

5. Энэ хэзарим гэмт хэргийг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгохын тулд үйлджээ. Энэ нь цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлоготой хослуулах шаардлагатайг харуулж байна.

Зөвлөмж

1. Орчин үеийн криминологийн чиг хандлага нь хэрэг өсөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийн тухай илүү гүнзгий судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг нийгмийн хөгжилтэй уялдуулан тодорхойлж байна. Ингэхдээ нийгмийн хөгжилд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга³ зүйгээр явуулах шаардлагатай /crime prevention through social development/ Тухайн улс, орон нутгийн түвшинд хэрэгжиж байгаа нийгмийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө эсхүл зорилтот бүлгүүдэд чиглэсэн ажил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, тусламж дэмжлэгт тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг хэлэх бөгөөд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах. Цаашид Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу арга хэмжээ зохион байгуулахдаа шинэлэг арга барилаар ажиллах шаардлагатай.

2. Цагдаагийн албаны хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” болон Зөрчлийн тухай хууль”-д хууль сахиулагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх, өөрийгөө хамгаалах заалтыг тусгах, албдлага хэрэглэх, зөрчил үйлдэгчийг саатуулах гэх мэт шийдвэрийг гаргах талаар нэг мөр ойлголтыг хууль сахиулагчид өгөх нь зүйтэй байна. Цаашид цагдаагийн үйл ажиллагааг нарийвчлан эрх зүйн орчныг бий болгох зохицуулах шаардлагатай.

3. Төрийн албаны бүртгэлийн тогтолцоог сайжруулах төрийн алба хаагч тодорхой баримт бичгийг тулгаж хянах, ур чадварыг эзэмшүүлэх, төрийн албанд дотоод хяналтын системийг сайжруулах, ажлын байранд авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлийг тооцох, үнэлэх аргачлал бий болгож мөрдүүлэх.

4. Хууль сахиулах албанд нэг бүрийн тусгай хэрэгсэл, техник хэрэгслийг шинэчлэх, алба хаагчдад олгох, байгууллагын бүх нэгжид бүрдүүлэх шаардлага байна. Түүнчлэн хууль сахиулах байгууллагуудын сургалтын тогтолцоог өөрчилж, сургал дадлагын төвүүдийн арга барил, сургалтын хөтөлбөрийг шинэчилж, урт хугацаанд байга аорчноос нь хөндийрүүлж сургалт зохион байгуулах

5. Судалсан хэргээс дүгнэн үзэхэд албаны чиг үүрэгтээ хайнга хандсаны улмаас арилжааны банкны салбар болон аж ахуйн нэгжид залилах завших, үрэгдүүлэх гэмт хэрэг гарахад хүргэсэн тохиолдол нийтлэг гарч байна. Арилжааны банк аж ахуйн нэгжид хяналтын тогтолцоо байгаа эсэхийг шалгах, заавар, зөвлөмж өгөх ажлыг банкны салбартай хамтран зохион байгуулах

6. Нийтийн албанд болон нийгэмд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Энэ нь нийгмийн суурь асуудлыг шийдвэрлэх, хувь хүнийг бүрэлдэж бий болгоход нөлөөлөх, санхүүгийн боловсрол хүмүүжлээр дамжуулж нөлөөлөх үндсэн зорилготой байх бөгөөд үр дүн нь зөвхөн гэмт хэргээс сэргийлээд зогсохгүй нийгмийн хөгжилд дорвитой нөлөөлдөг. Тухайлбал, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2020 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан нийгэм, соёлын харилцааг хөгжүүлэх урт хугацааны зорилтот суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

--o0o---

³ UNODC, 'Handbook on the crime prevention guidelines. Making them work. 2010

ШҮҮГЧИЙН ТАНИН МЭДЭХ ҮЙЛ ЯВЦ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ХҮЧИН ЗҮЙЛС

Б.Батзориг

Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга,
доктор (Ph.D), дэд профессор

Товч агуулга. Шүүгчийн танин мэдэх үйл явц, түүнд нөлөөлөх хүчин зүйл, танин мэдэх үйл явцыг боловсронгуй болгох талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Шүүгч, мэдлэг, ур чадвар, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэдээлэл, байгууллага, соёл, ажлын ачаалал, сургалт, хүчин зүйл.

Хууль бол дур зоргын буюу нэг удирдагчийн санаа зоригийн бус харин төр нийгмийн хөгжлийн жам ёсыг тусган, тухайн улсын Үндсэн хуульд нийцэн бодит чанарыг олж эхэлсэн байна. Хуулийн ийм утга чанар нь түүнийг дээдлэх ёсыг нийтээрээ баримтлахад хүргэжээ. Энэ нь Баруун Европид дур зоргын хандлагыг хууль ёсоор халах оролдлого болсон билээ.⁴

Хууль дээдлэх ёс нь эгэл иргэд, эрх мэдэлтэн, төрд тэр дундаа галт зэвсэг барин зогсоо хууль сахиулагчдад ч ялгалгүй үйлчилдэг. Үүнийг төрийн эрх мэдлийн засаглалын тэнцвэрт байдал зохицуулж байдаг. Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах нь хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа болох, эрх мэдлийг хэрэгжүүлэгчид нь бие биэндээ хяналт тавьж, эрх мэдлийг хязгаарлан байж өөр хоорондоо үүссэн зөрчилдөөнөө шийдвэрлэж тэнцвэрт байдлаа хангадаг.⁵ Иймд хууль дээдлэх нь төрийн бүх шатанд жигд хэрэгжих ёстойг Монгол Улс Үндсэн хуулиараа баталгаажуулсан.⁶

Сүүлийн үед хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй субъектүүд төдийгүй олон нийтийн зүгээс шүүхийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, засаж сайжруулах талаар Монгол Улсын Ерөнхийлөгч⁷, Монгол Улсын Засгийн газар⁸ хуулийн төслүүд санаачлаад байгаа билээ.

Шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа олон хүчин зүйл байгаа нь мэдээж. Судлаачийн хувьд “Шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах замаар шүүх эрх мэдлийг бэхжүүлэх” асуудлыг хүрээнд энэ удаа онцлон авч, 5 аймаг, нийслэлийн анхан шатны Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн шүүхийн 11 шүүгчтэй биечилсэн ярилцлага хийсэн судалгааны дүнг та бүхэнтэй хуваалцаж.⁹

Шүүгч хэрэг маргааныг аль нэг талаас хамааралгүйгээр зөвхөн хуульд захирагдан, бие даасан байдлаар шийдвэрлэх нь хараат бус байдлын илэрхийлэл. Шүүгчийн шийдвэр гаргах үйл явцыг “Шүүгч бол ярьдаг хууль” гэснээр багцаалж хууль дээрээ байгаа зүйлийг А, Б-гүй уншаад аль нэг талд шийддэг гэж явцууруулан ойлгох, цаашилбал бизнес эрхлэгчид хууль хэрэглэх нь ном уншихтай адил гэж үзэн эрх зүйч, хуульчийн ажлыг ерөнхий нягтлан бодогч, ерөнхий инженерүүдэд хариуцуулж байна. Нэг талаас харахад тэд хуулийг маш сайн уншин ойлгож байгаа ч эрх зүйг ойлгох, хэрэглэхэд мэргэшлийн алдаа гаргахад хүргэдэг.

Шүүхийн шийдвэрийг харахад хүмүүсийн хэлсэн ярьсан, үзүүлсэн зүйл дээр үндэслээд жаахан бодож байгаад учрыг нь олж дурдаад, ойлгомжгүй, бөөрөнхийлсхийгээд хуулийн заалт бичдэг. Ямар ч хүн ийм зүйлийг хийж чадна.

Хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанийн хуулийн ажлыг давхар хариуцдаг инженертэй хийсэн ярилцлагаас

⁴ Б.Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал /нийтлэг асуудал/ УБ., 2004.170 дахь тал

⁵ Ш.Л.Монтескье “Избранные произведеие” 1959., стр 289.

⁶ “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

⁷ Цахим эх сурвалж: <https://president.mn/14373/>

⁸ Цахим эх сурвалж: <http://forum.parliament.mn/projects/10933>

⁹ Судалгааг шүүгчийн өөрт тулгарсан асуудлаас гадна, бусад шүүх, шүүгч нарын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх байдлаар явуулсан болно. Мэдээлэл цуглуулах ажил 2020 оны 3 сараас 10 сар хүртэл хугацаанд хийгдсэн. Зарим шүүгчтэй хэд хэдэн удаа холбогдож мэдээлэл цуглуулсан.

Шүүх шийдвэр гаргах явц нь бүхэлдээ хэрэг, маргаантай холбоотой асуудлыг бүх талаас нь танин мэдэх идэвхтэй үйл ажиллагаа. Зүгээр нэг танин мэдэх бус хууль зүйн мэдлэг, хандлагад тулгуурласан олон тал үйл ажиллагаа. Энэ талаар тухайлан дурдаас илүү шүүгчийн танин мэдэх үйл явцад нөлөөлж буй хүчин зүйл дээр тогтоё.

Судалгааны явцад шүүгчийн танин мэдэх процесст нөлөөлж буй хүчин зүйлийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- 1/Байгууллагын соёл
- 2/Ажлын ачаалал
- /Сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт
- 4/Бусад

Байгууллагын соёл

Шүүгч хараат бус, эний ч нөлөөнд орохгүй ажиллах ч байгууллагын дотор амьдрах, бодох, ажиллах, гишүүн байх тодорхой орчин бүхий соёлын нэг хэсэг болж байдаг. Энэ соёл нь тухайн байгууллагын түүхтэй салшгүй холбоотой. Шүүх дотроо Эрүү, Иргэн, Захиргааны шүүхийн соёлын ялгаа бий.

Эрүүгийн шүүх рүү ороход эвгүй, шүүгч нар нь ширүүн харцтай, Захиргааны шүүх рүү ороход хивс дэвссэн, цэцэгтэй байдаг.

Зөрчил шалган шийдвэр тухай хуулийн хэлэлцүүлэг дээр бизнес эрхлэгчийн яриа

Байгууллагын соёл нь урт хугацааны туршид бүрэлдэн бий болж сайн туршлага, уламжлал нь өвлөгдөн үнэт үйлс болон төлөвшиж байдаг. Шүүгч хянаж буй хэрэг маргаантай холбоотой асуудлаар хоорондоо зөвлөлдөх, ямар ч ахмад туршлагатай шүүгч нараас асууж лавладаг, туршлага судалдаг байсан нь саяхан. Энэ нь асуудлыг мэдэхгүй гэдэг утгаар бус “Шийдвэр гаргахдаа алдаа гаргахгүй байх юмсан, миний хараагүй зүйлийг харах болов уу”, “Залуу хүмүүс алдаа гаргах вий, хэлээд өгөх юмсан” гэсэн эерэг хандлагын илэрхийлэл байдаг. Гэвч “Би хараат бус ажилладаг, хэнээр ч заалгахгүй”, “Би л болж байвал”, “Энэ надад зааж хөндлөнгөөс нөлөөлөх гээд байна”, “Ахмад шүүгч нар асуухаар хэлдэггүй” гэх мэтийн хандлага нь бие биенээс суралцах, мэдээлэл солилцоход хүндрэл учруулж байхаар байна.

Хэдий ахмад болон залуу шүүгч нарын дунд ойлголтын зөрүү байдаг ч тэдний шүүх хуралдааныг даргалах, оролцогчтой харилцах, эрх зүйн процессыг удирдах олон жилийн туршлагыг шүүгчийн бие даасан, хараат бус байдалд нөлөөлөхөөргүйгээр бусдад хуваалцах ажлыг зохион байгуулах шаардлага бий.

Ээдрээ төвөгтэй хэрэг дээр олон жил ажилласан шүүгчтэй хамт бүрэлдэхүүнтэй шүүх хуралдаанд ороход үнэхээр их зүйл сурдаг.

Залуу шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Судалгааны явцад дан залуу шүүгч нартай шүүх, жендерийн харьцаанаас хамааралтай шүүхийн соёлыг нарийвчлан судалбал сонирхолтой дүн гарч болох юм гэх таамаглалаа та бүхэнд үлдээе.

Ажлын ачаалал

Олон нийтийн зүгээс шүүгчийн ажлыг шүүх хуралдаан хийж, шийдвэрээ гарган алх цохих явцаар хязгаарлан ойлгодогт нь тэднийг буруутгах нь зохимжгүй. Харин шүүхийн хэвийн үйл ажиллагааг ханган ачааллыг тэнцвэртэй хангах субъектүүд, хуульчдын хувьд бодит байдлыг илүү ойлгоно. Өмнө дурсанчлан шүүгчийн танин мэдэх үйл явц өргөн. Шүүхийн шийдвэрийг хэн ч уншаад ойлгох, үндэслэлтэй гаргахад маш их мэдээлэл цуглуулах, эрэл хайгуул хийдэг. Нэг хуралдаанаас дараагийн хуралдаан, нэг шийдвэр бичиж дуусаад дараагийн шийдвэр бичих гэсэн дараалалтай ачаалал ихтэй шүүгчийн мэдээлэл хайх, суралцах үйл явц алдагдахад хүрдэг. Эсрэгээр ачаалал багатай шүүгч нарын хувьд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах боломж өндөр байх боловч суралцах, өөрийгөө хөгжүүлэх тал дээр дутагдалтай байдаг, ялангуяа орон нутагт гэж судалгаанд хамрагдсан шүүгчид онцолж байв.

Ачаалал бага байдаг учир Англи хэл бие даан судалж байгаа. Тодорхой сэдвээр судалгааны ажил хиймээр байвч ашиглах материал, зааж чиглүүлэх хүн байхгүй.
Орон нутгийн шүүхийн шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт

Сурах үйл явц бол шүүгчийн үндсэн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулийн хүрээнд сургалтын зохион байгуулалт өөрчлөгдсөн. Сургалт нь ойлголтыг нэгтгэх, шүүгч аливаа асуудлыг танин мэдэх, мэдээлэл эрх хайх гарц, арга замыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Сургалтын чанар, үр дүнгийн талаар бус цаашид зохион байгуулах сургалтын талаар судалгаанд хамрагдсан хүмүүсийн саналыг нэгтгэн хүргэе. Үүнд:

- Аль болох байнга өмгөөлөл хийдэггүй багш нараар хичээл заалгах /ийм өмгөөлөгч багш хичээл заахад шүүгч нар сургалтанд идэвхтэй оролцдоггүй, ялангуяа тодорхой хэрэг маргаан шийдвэрлэх асуудлаар хичээл заасан тохиолдолд оролцогчийг татгалзах асуудал үүсэх эрсдэлтэй/
- Шүүгч нарын эрх зүйн ойлгох хэв маяг, хандлагыг нэг мөр болгох онол, сэтгэлгээний сургалтуудыг ихээр оруулах /Шүүгч нар эрх зүйг ойлгох хэв маяг гадаад, дотоодын төгссөн сургуулиас шалтгаалаад янз бүр байгааг аль болох жигдрүүлэх/
- Хуулийн заалтыг хэрхэн хэрэглэх, ойлгох сургалтаас илүү хуулийн үзэл баримтлал, тухай хуулийн заалт яг ямар агуулгаар хуульд тусгагдсан сургалт түлхүү оруулах
- Харьцангуй цөөн гардаг хэрэг маргаан, онцлог шийдвэрлэсэн, бага гарсан хэрэг маргааны талаар мэдээлэл өгөх
- Онлайн сургалтуудын арга барилыг бүтээлчээр нэвтрүүлэх /ШЕЗ-өөс гадаад орны шүүгчийг онлайнаар холбогдож хичээл заасан. Ийм сургалтуудыг өргөжүүлэх/

Сургалтын үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг нь ном гарын авлага. Эдгээр нь сургалтанд ашиглагдахаас гадна хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд чухал нөлөөтэй. ШЕЗ-өөс олон бүтээл гарч шүүгчид тараагддаг ч шинээр томилогдсон, номоо гээгдүүлсэн хүмүүс хүрэлцдэггүй, тэр цаг хугацаандаа тараагдаад дуусдаг. Хуулийн чиглэлээр гарч буй ном бүтээл орон нутагт хүрдэггүй.

Шүүх болгонд хуулийн номын сан байгуулах замаар энэ асуудлыг шийдвэрлэж болох юм.

Сургалтын зохион байгуулалтыг шүүхийн тамгын газар хариуцдаг. Гэвч шүүхийн ерөнхий шүүгчийн үүрэг оролцоо өндөр хэвээр байна. Зарим шүүхийн ерөнхий шүүгч манлайлан өөрөө сургалтанд сууж, бусад шүүгч нартаа зааж сургах нь илүү үр дүнтэй байдаг. Хэдий тийм ч энэ нь ерөнхий шүүгчийг элдэв хардлага өртүүлэх эрсдэлийг дагуулдаг тухай шүүгч нар хэлж байлаа.

Энэ нь шүүхийн сургалтын зохион байгуулалт хангалтгүй байгаагийн илэрхийлж гэж дүгнэж болох юм.

Мэдээлэл эрж, хайхад нөлөөлөх бусад хүчин зүйлс

Шүүгч хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл хомс, тэдгээрийг эрж хайхад ямагт бэрхшээлтэй тулдагтай санал нэгдэж байлаа. Шүүгч нар дараах байдлаар мэдээлэл эрж, цуглуулдаг ба тэдгээрийг хэрэглэхэд учирдаг бэрхшээлийг дурдвал. Үүнд:

1/цахим эх сурвалж /<https://www.legalinfo.mn/> төрийн байгууллагын албан ёсны цахим хаягаар нэвтэрч эрх зүйн актын талаар мэдээлэл авдаг. Олон улсын гэрээ, хэлэлцээр бүрэн олддоггүй, хуульд орсон нэмэлт, өөрчлөлт орохоос өмнөх заалтын талаар мэдээлэл авах боломжгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актууд олддоггүй.

Цахим эх сурвалжийн бусад мэдээллийг тодорхой ойлголт авна. Шүүхийн шийдвэрт ашиглах боломж хязгаарлагдмал байдаг. Зарим тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүгч нарт зориулж “бүүстэлсэн”, “тусгайлан бэлтгэсэн байх эрсдлийг тооцоолох хэрэгтэй болдог. <https://legalddata.mn/> цахим хуудаснаас онол, арга зүйн мэдээлэл авах боломжтой байдаг./

2/өмнө нь шийдвэрлэгдсэн хэргийн талаарх мэдээллийг <http://www.shuukh.mn/> цахим хуудаснаас авдаг. Системчлэгдээгүй учир хугацаа шаарддаг. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээг <https://www.forum.mn/>

3/өөрт байгаа ном, гарын авлага бусад материалууд /шийдвэрлэж байгаа хэрэг маргаантай холбоотой Монгол Улсад хийгдсэн судалгааны талаарх нэгдсэн мэдээлэл байдаггүй. Энэхүү материал нь асуудлыг гүнзгийрүүлэн судалж, олон талаас харах боломж олгодог/

4/оролцогч талуудаас албан ба албан бусаар /Шүүгч захирамж гаргаж шаардлагатай мэдээлэл авах боломжтой. Хэдий тийм асуудлыг албан бичгээр шийдвэрлэх нь ачааллыг нэмэгдүүлэх талтай.

5/бусад шүүгч нараас /Ойролцоо хэрэг маргаан шийдвэрлэж байсан шүүгчид тухайн асуудлаар судалж, цуглуулсан материал, хүндрэл бэрхшээл, даван туулсан туршлагын талаарх мэдээлэл байдаг. Үүнтэй холбоотой нэгдсэн мэдээллийн сан байхгүй учир танил талаараа холбогдож мэдээлэл авдаг. Тэтгэвэрт гараад өмгөөлөгчөөр ажиллаж байгаа шүүгч нартай холбогдоход сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй./

Дүгнэлт

Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх мэдлэг ур чадвараа дээшлүүлэх нь түүний үндсэн үүргийн нэг юм. Хэрэгжүүлэх үндсэн арга нь мэдээлэл идэвхтэй эрж, хайх ажиллагаа боловч энэ чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажил хангалтгүй, мэдээлэл эрж, хайх явцад сонирхлын зөрчилд холбогдох эрсдэлтэй байна.

Шүүгч нарын дунд мэдээлэл солилцох, эрж хайх, суралцах үйл явцад байгууллагын соёл, ажлын ачаалал, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

Санал

- Байгууллагын соёл, ажлын ачаалал, сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт шүүгчийн танин мэдэх үйл явцад хэрхэн нөлөөлж байгааг тусгайлах судлах;
- Шүүгч нарт хэрэг маргаан шийдвэрлэх замаар цугларсан баримт, мэдээллийг нэгтгэдэг, мэдээлэл солилцдог сүлжээ бий болгох /мэдээлэл солилцдог дотоод сүлжээнээс өөр/;
- Ээдрээ төвөгтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад Шүүхийн ерөнхий зөвлөл тодорхой асуудлаар мэдээлэл судалгаа захиалгаар хийх эсхүл тухайн ачаалал өндөртэй шүүх дээр судалгаа хариуцсан нэгж ажиллуулах;
- Шүүгч өөрөө болон туслах ажилтнаар дамжуулан бусадтай шууд холбогдон мэдээлэл цуглуулах бус шүүхийн захиргааны мэргэшсэн ажилтнаар дамжуулж авдаг “тогтолцоо”-г нэвтрүүлэх;
- Шүүх болгонд хуулийн номын сантай болох-зэрэг болно.

--oOo---

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ АВАХААР ЗАНАЛХИЙЛЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Жинжиймаа

Монголын Үндэсний их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал,
Дотоод хэргийн их сургуулийн докторант

Товч агуулга. Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Заналхийлэгч, бусдын эд хөрөнгө, гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт бүлэг, гэмт бүлэглэл, хохирогч.

Байгалийн жам ёсоор бүтээсэн баялаг болон хүний хөдөлмөрөөр буй болгосон материаллаг эд юмс, оюуны бүтээл ашиглах, эзэмших, захиран зарцуулахад чиглэсэн хүмүүсийн хоорондын харилцаа нь өмч гэдэг ойлголт буй болгодог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална¹⁰”, мөн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно¹¹” гэж иргэдийн өмчлөх эрхийг баталгаажуулсан байдаг. Иймд нийтийн болон хувийн өмчийн бүх хэлбэрийг гэмт халдлагаас хамгаалах нь эрүүгийн эрх зүйн нэг чухал чиг үүрэг юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх¹²” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заасан бөгөөд энэ гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан өмчлөх эрхийг эсрэг гэмт хэргийн нэг төрөл юм.

Сүүлийн жилүүдэд бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн гаралт нэмэгдэх хандлагатай байгаа төдийгүй үйлдлийн арга нь нарийсч, зохион байгуулалттай болж, нуугдмал хэлбэрт шилжиж байна.

Иймд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замын талаар дүгнэлт, санал дэвшүүлэхийг зорьлоо.

Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэргийн бүртгэгдсэн болон шийдвэрлэгдсэн байдлыг авч үзвэл:

Энэ төрлийн гэмт хэрэг 2010-2019 онд нийт 151 бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн 79 буюу 52.3 хувь нь хүнд, 72 буюу 47.7 хувь нь хүндэвтэр ангиллын гэмт хэрэг байна.¹³

График 1. Бүртгэгдсэн гэмт хэрэг, ангилал (2010-2019 он)



¹⁰ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992, 4 дэх тал (Төрийн мэдээлэл) №1

¹¹ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992, 8 дэх тал (Төрийн мэдээлэл) №1

¹² Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002, 57 дахь тал (Төрийн мэдээлэл) №5


¹³ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ (2010-2019 он). УБ., 2020

Гэмт хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл, нийт бүртгэгдсэн 151 хэргийн:

- 75 буюу 49.7 хувийг хэрэгсэхгүй болгож,

- 58 буюу 38.4 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлж, 9 буюу 6.0 хувийг нэгтгэж тус тус шийдвэрлэсэн бөгөөд 9 буюу 5.9 хувь нь ажиллагаанд байгаа мэдээлэл байна. Эндээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн ихэнхийг ЭБШХ-ийн 24.1.1, ЭХХШТХ-ийн 1.5.1.1 гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж ирсэн байна.

График 2. Гэмт хэргийн шийдвэрлэлт¹⁴



Хэрэгсэхгүй болсон хэргийн оноор нь авч үзвэл, 2017 онд 17 буюу 22.7 хувь, 2018 онд 14 буюу 18.7 хувь, 2019 онд 13 буюу 17.3 хувь нь тус тус бүртгэгдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлж шийдвэрлэсэн хэргийг хугацаагаар нь авч үзвэл, 2017 онд 10 буюу 17.2 хувь, 2016 онд 9 буюу 15.5 хувь, 2015 онд 8 буюу 13.8 хувь нь тус тус эзэлж байна.

Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгтэй тэмцэж буй талаар мөрдөгч, прокурор нараас авсан судалгааны үр дүн:

Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэргийг мөрдөн шалгах болон шүүхийн практик, гэмт хэргийн тохиолдлууд, түүний үр дагавар зэргийг судлан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр уг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор СХД, БГД, БЗД, СБД, Налайх дүүрэг, Төв аймгийн цагдаагийн газар, хэлтэс, прокурорын газрын 245 прокурор, мөрдөгч нараас санал асуулгын аргаар судалгаа авсан юм. Судалгааны үр дүнг товч танилцуулбал,


График 3. Судалгаанд оролцогчдын хүйс



Судалгаанд оролцогчдын 5% хувь нь эмэгтэйчүүд байгаа бол эрэгтэйчүүд үнэмлэхүй дийлэнх болох - 95% хувийг бүрдүүлж байна.


График 4. Судалгаанд оролцогчдын нас

¹⁴ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ (2010-2019 он). УБ., 2020.




Судалгаанд оролцогчдын 25-30 насных нь 50%, 31-40 насныхан мөн адил 50% хувийг нь эзэлж байв. 51-аас дээш насны хүн судалгаанд хамрагдаагүй.

График 5. Судалгаанд оролцогчдын мэргэжлээрээ ажилласан жил



Эндээс үзэхэд, судалгаанд оролцогчдын 4% хувь нь 11-20 жил ажилласан, 40% хувь нь 5 хүртэл жил ажилласан, 56% хувь нь 6-10 жил ажилласан туршлагатай прокурор, мөрдөгч нар байна.

График 7. Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэрэгт шалгаж, хяналт тавьж байсан эсэх



Судалгаанд оролцогчдын 26% бусдын эд хөрөнгө авахаар заналхийлсэн гэмт хэрэг шалгаж, прокурорын хяналт тавьж байсан, 74% хувь нь энэ төрлийн гэмт хэрэг шалгаж байгаагүй, хяналт тавьж байгаагүй байна.


Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг илрүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг судалгаанд оролцогчдын 20.0% нь хууль сахиулах байгууллагад мэдээлдэггүй, 32.5% нь нотлоход хүндрэлтэй, 47.5% нь ихэвчлэн нуугдмал байдлаар үйлдэгддэг гэжээ.

Энэ төрлийн гэмт хэргийн 65 хувийг бүлэглэн, 18 хувийг ганцаарчилан, 17 хувийг зохион байгуулалттай гэмт бүлэг, үйлдсэн байна.

Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг үйлдэгдэх үеийн заналхийлэл болон халдлагын зүйлийн шинжийн тухайд:

Энэ гэмт хэргийн 35% хувь нь утсаар, 52% хувь нь нийгмийн цахим сүлжээ /facebook/ ашиглан, 4% нь захидлаар, 9% хувь нь биечлэн заналхийлдэг гэсэн хариулт өгсөн байна.

Зураг.2 Гэмт хэрэг үйлдэх үеийн заналхийлэл



Иргэдийн гар утас болон интернет, цахим хэрэглээ нэмэгдсэн тул утас, цахим сүлжээгээр заналхийлэх тохиолдол нэмэгдэж байна.

“Энэ гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл гардаг уу?” гэсэн асуултад тийм гэж 30% нь, үгүй гэж 21% нь, дийлэнх буюу 49% нь төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэлтэй гэж хариулсан байна.

Зураг.4 Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг хэрхэн дүгнэж буй үзүүлэлт

Сайн - 22%, муу - 14%, дунд - 64% нь хариулсан байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг үнэлүүлэхэд ердөө 20 хувь нь сайн, 80 хувь нь дунд, түүнээс доогуур үнэлгээ өгчээ. Үүнээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж буй үйл ажиллагаа, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэл, мөрдөн шалгах арга тактик, илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах шаардлага байгаа нь харагдаж байна.

Судалгаагаар дараах асуудал тогтоогдсон. Үүнд:

1.Энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байна. Иймд нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын хүч, арга, хэрэгслийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Учир нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийг эрүүгийн хэрэг үүсгэх тогтоолд хэрхэн тусгасныг авч үзвэл, иргэдийн гомдол, мэдээллээр 73.2 хувь, гүйцэтгэх ажлын шугамаар 17.5 хувь, мөрдөгч, прокурор 9.3 хувийг тус тус илрүүлсэн нь гол төлөв иргэдийн гомдол, мэдээллийн үр дүн байна. Үүнээс үзэхэд, гүйцэтгэх ажлын шугамаар илэрч байгаа хэрэг тун цөөхөн байгаад зогсохгүй илэрч мэдэгдээгүй байгаа зохион байгуулалттайгаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаа учир гүйцэтгэх ажлыг мөрдөн шалгах ажиллагаатай нягт уялдуулан явуулах шаардлагатай байна.

2.Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгддэг боловч шүүхээс гэмт хэргийн зүйчлэлийг өөрчилж, дээрэмдэх гэмт хэргээр ял оногдуулж байна. Эндээс үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн төсөөтэй зарим гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудал тулгамдаж байна. Иймд бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг дээрэмдэх гэмт хэргээс ялган зүйлчлэх талаар албан ёсны болон эрдэм шинжилгээний тайлбар хийх нь зүйтэй.

3.Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ иргэдийг ихэвчлэн утсаар болон цахим сүлжээгээр дамжуулан заналхийлжээ. Мэдээллийн технологийн хэрэглээнд сургадаг ч аюулгүй, зүй зохистой хэрэглээнд сургах, цахим орчинд учирч болох төрөл бүрийн аюул, заналхийллээс сэргийлэх мэдлэг, ойлголт, хангалттай хэмжээнд өгөгддөггүй улмаас тухайн гэмт хэргийн хохирогч болох магадлалыг нэмэгдүүлсээр байна. Иймд иргэдэд аюулгүй, зохистой хэрэглээний туршлага, ойлголтыг төлөвшүүлэх шаардлагатай.

4.Энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, зохион байгуулалт нь улам нарийсч байна. Заналхийлсэн үйлдэл, хэлбэрийг сайтар нотлох баримтаар нотолж, богино хугацаанд нотлох баримтыг цуглуулан мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулахгүй бол нотлох баримт устгах аюултай байдаг. Мөн энэ төрлийн гэмт хэрэгт бизнес эрхэлдэг, мөнгөтэй иргэд хохирох нь түгээмэл байна.

2010-2019 онд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 14 тэрбум 307.4 сая төгрөгийн хохирол учирсан байна. 2017 онд бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компанийн хувьцааг далайлган авсан гэмт хэрэгт хамгийн их буюу 10 тэрбум төгрөгийн хохирол, 2018 онд бүртгэгдсэн бусдыг айлган сүрдүүлэн, заналхийлсэн гэмт хэрэгт 918.5 сая

төгрөгийн хохирол учирсан. Учирсан хохирлын 3.2 тэрбум буюу 22.9 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 77.1 хувийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангах зорилгоор гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эд хөрөнгийг олж тогтоох, хөрөнгө хамгаалах ажиллагаа шаардлагын түвшинд хийгдэхгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлд заасан “Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй” заалтын дагуу гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хохирол нөхөн төлөх талаар шаардаж болохгүйгээс гадна гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогын эх үүсвэргүй байдагтай холбоотой.

Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг үйлдсэн хэлбэрээр нь авч үзвэл, 26 буюу 17.2 хувь нь бүлэглэн, 4 буюу 2.5 хувийг гадаадын иргэн оролцож, 16 буюу 10.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 6 буюу 4.0 хувь нь согтуугаар, 1 буюу 0.7 хувь нь хүүхэд оролцож үйлдсэн байна. Энэ нь уг гэмт хэргийн зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэн гүйцэтгэх болсонтой холбоотой. Зохион байгуулалттай гэмт бүлэг¹⁵, бүлэглэн гүйцэтгэх¹⁶ нь сүүлийн үед энэ гэмт үйл ажиллагааг байнга эрхлэх болсон ба эдгээр хоёр бүлгийн нарийн шаталсан байгуулалт нь тэдгээрийн толгойлогчийг маш цөөн тооны хүн мэдэж байхаар далдалж байдаг. Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэргийг нотлоход туйлын төвөгтэй.

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ янз бүрийн байдлаар заналхийлж, эд хөрөнгө болон түүний өмчлөх эрхийг шилжүүлэн өгөх, эсвэл эд хөрөнгийн шинжтэй үйлдэл (заналхийлж буй этгээдийн шаардлагаар хийх ажил үйлчилгээ) хийлгэхээр шаарддаг бөгөөд бидний судалсан хэргийн 35% хувьд нь заналхийлж буй этгээд тогтоогдоогүй байна. Энэ тохиолдолд мөрдөгчөөс анхны материалыг үндэслэн гэмт этгээдийг олж тогтоох бүхий л бололцоотой ажиллагаануудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Заналхийлэгчээс үзүүлж буй сүрдүүлэг, заналхийлэл нь нотлогдоогүй үед тэдгээрийг нотлохын тулд мөрдөгчөөс ихээхэн ур чадвар, мэдлэг шаардах бөгөөд гэмт этгээдээс үзүүлсэн сүрдүүлэг, заналхийлэл биелэгдэх үндэстэй эсэх, ямар сүрдүүлэг, заналхийлэл үзүүлсэн, хохирогч этгээдийн ахуй амьдрал, ажил болоод хувийн нууц, бусад нөхцөл байдлуудтай /эд хөрөнгийн хэр хэмжээ болон байршил, хохирогчийн хууль бус үйлдэл гэх мэт/ тохирч байгаа эсэхийг нарийвчлан шалгаж тогтоох нь чухал юм.

Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэгт хохирогч завсрын шинжтэй нөхцөл байдал болох өөрийн хууль бус үйлдэл болон хувийн ямар нэгэн алдаагаар гэмт этгээдэд олзлогддог тул түүнийг мөрдөгч, мөрдөн шалгах ажиллагааны явцад нотолбол зохино. Энэ нь уг гэмт хэргийн нэг гол онцлог бөгөөд гэмт этгээд хохирогчийн хууль бус үйлдлийг мэддэг учраас түүнийг нь илчилнэ хэмээн сүрдүүлж, эд хөрөнгө болон түүний өмчлөх эрхийг шилжүүлэн өгөхийг шаарддаг. Ийнхүү олзлогдсон хохирогч зарим тохиолдолд хэргийн талаар бодитой мэдээлэл өгөхөөс татгалзах явдал бий. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийн хууль бус үйлдлийг нарийн шалгаж, сүрдүүлэг, заналхийлэлд өртөх шалтгаан нь болсон эсэхийг магадлах нь зүйтэй.

Заналхийлэгчийн гэмт үйлдлийг таслан зогсоохын тулд үйлдэл дээр нь баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх явдал элбэг тохиолддог. Заналхийлж буй этгээд нь ямар нэгэн болзол шаардлага тавьж, хохирогчоос эд хөрөнгө, мөнгө шаардаж, уг халдлагын зүйлээ тодорхой газар, цаг хугацаанд авахаар тохирдог ба энэ тохирсон үед нь хохирогчийг гэмт этгээдтэй уулзуулах, шаардсан зүйлийг нь өгүүлэх замаар сүрдүүлэгч этгээдийг тогтоон, яг тэр цаг мөчид баривчлах ажиллагааг явуулдаг болох нь хавтаст хэрэг судалсан судалгааны үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал, “Одоогоос 10 гаран хоногийн өмнө Б (.....) надтай яриад О гэгч хүн яриад Э гэдэг хүнээс 50 сая төгрөгийн авлагатай энэ мөнгийг жил тойрон авч чадахгүй байна. Энэ мөнгийг аваад өгвөл 20 сая төгрөгийг танайхөдөлгөөн төрийн бус байгууллагад өгье гэсэн. 2016 оны ... дугаар сарын.....-ны өдөр 10 цагийн орчим санагдаж байна яг тодорхой санахгүй байна. Б бид хоёр миний эзэмшлийн.....улсын дугаартай Н-2 маркийн авто машинтай модны хоёрт ...бус байгууллагын гишүүн Э буюу С, Л нартай очиж уулзсан. Тухайн үед ... цагаан өнгийн Тоёота Спасио маркийн авто машинтай явж байсан. Б бид хоёр уулзаад О гэж хүний өрийг Э-ээс аваад өгчихвөл хэдэн төгрөгтэй болоод энэ өвөл нэн ядуу хүмүүст

¹⁵ Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

¹⁶ Эрүүгийн хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

өгдөг түлээ нүүрс, хоол хүнс, эм тариа авах мөнгөтэй болчих юм байна гэж ярилцаад С, Э утас руу залгаад зарах гэж байгаа барааг чинь үзье гэхэд Э ... хүрээд ир гэж дуудахаар нь Б бид хоёр миний машинтай яваад Б бид хоёр О ... хорооны урд талын дээр хүлээгээд зогсож байсан. Харин С, Л хоёр ... улсын дугаартай цагаан өнгийн Тоёота Спасио маркийн авто машинтайгаа ... цогцолбор руу орсон. Удалгүй С, Л нар Э-г машиндаа суулгаад ... цогцолбороос аваад гарч ирсэн. Э машиндаа хэрхэн яаж суулгасан талаар мэдэхгүй. Б бид хоёр Х.Э тухтай уулзаад зогсооё гэж бодоод явсан боловч М гүүр хүртэл замын хажууд зогсчих зогсоол байдаггүй юм байна. Тэгээд явсаар байгаад Баянзүрхийн товчооны ертөнцийн зүгээр бол хойд талд нь буюу Туулын голын эрэг дээр зогссон...гэх мэдүүлэг”.

Б, Н, Г, нарын захиалсны дагуу Б, Л, С нар урьдчилан үгсэж тохиролцон бүлэглэн хохирогч Э-рүү зарын дагуу ярьж байна гэж хуурч мэхлэн Туул голын бургасанд аваачиж хүч хэрэглэн заналхийлж, онц их хэмжээний мөнгө өгөхийг шаардаж, улмаар түүнээс биед нь явсан 2 сая төгрөгийг далайлган сүрдүүлж авсан, үлдсэн мөнгөө тодорхой цаг хугацаанд авчирч өгөхөөр тохирсон байсныг нь цагдаагийн ажилтнууд болзсон цагт нь хохирогчийг гэмт этгээдүүдтэй уулзуулах замаар баривчлан авсан байна.¹⁷

Анхаарах гол зүйл бол баривчлах ажиллагааг урьдаас сайтар бэлтгэлтэй, эрсдэл багатай, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор түүнд саад учруулах объектив болон субъектив хүчин зүйлийг иж бүрэн харгалзан үзэх явдал юм.¹⁸ Мөн заналхийлсэн үйлдэл, хэлбэрийг нотлох баримтаар сайтар нотолж тогтоон, нотлох баримтыг богино хугацаанд цуглуулан, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулахгүй бол нотлох баримт устах эрсдэл өндөр байдаг.

Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн нотлох баримтыг үнэлэхдээ хохирогчийн мэдүүлэг, заналхийлэгчээс үзүүлсэн заналхийлэл хүч, эд хөрөнгө устгасан, эсхүл устгах боломжтой байсан эсэх, шаардлага тавьсан эсэхэд онцгой анхаарал хандуулбал зохино.

Энэ гэмт хэргийн хохирогч хууль бус үйлдэл болон өөрийн гаргасан хувийн алдаанаасаа болж бусдад олзлогддог учир хохирогч хэргийн талаар мэдээлэл өгөх нь ховор байдаг нь гэмт хэрэг илрүүлэх явцад хүндрэл учруулдаг.

Бусдын эд хөрөнгө авахаар заналхийлэх гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар, нуугдмал шинжтэй үйлдэгддэг, ул мөр үлдээх нь ховор учир энэ төрлийн гэмт нотлоход туйлын төвөгтэй.

Энэ төрлийн гэмт хэргийг тухайн хэрэгт хамтран оролцохын хамгийн аюултай хэлбэр болох зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдэх хандлага ихэсч байгаа нь эрүүгийн хавтас хэрэг болон анкетын асуулгаар авсан бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Дүгнэлт, санал

Монгол Улс дахь нийгэм, эдийн засгийн байдал, өөрчлөлтөөс хамаарч, сүүлийн жилүүдэд бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийн гаралт нэмэгдсэн, нуугдмал хэлбэрт шилжсэн, үйлдлийн арга, хэлбэр нь өөрчлөгдөж, энэ гэмт хэргийг бүлэглэж, зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэл үйлдэх болсон, хуулийн байгууллагуудын үйл ажиллагаа төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байна.

Иймд энэ төрлийн нуугдмал гэмт хэргийг илрүүлэхэд гүйцэтгэх ажлын арга, хэрэгслийг ашиглах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдэд тавих хяналтыг сайжруулах, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах арга, тактикийг сайжруулах, мөрдөгчдийг сургалтад хамруулах мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж

- Эрүүгийн хууль. УБ., 2015. (Төрийн мэдээлэл) №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2016 (төрийн мэдээлэл) №23

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

- Д. Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2014

¹⁷ Нийслэлийн Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 0648 дугаартай шийтгэх тогтоол. 2017.10.26. 201601000205 дугаартай эрүүгийн хэрэг.

¹⁸ С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ. 2001. 350 дахь тал.

- Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018
 - С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүйн тусгай анги (сурах бичиг). УБ., 2018
 - С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ., 2001
- Гурав. Эрүүгийн хэрэг
- Нийслэлийн Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 0648 дугаартай шийтгэх тогтоол. 2017.10.26. 201601000205 дугаартай эрүүгийн хэрэг
- Дөрөв. Эмхэтгэл
- ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба. Гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ (2010-2019 он). УБ., 2020

--oOo---

ШИНЭ ҮЕИЙН ТЕРРОРИЗМЫН НӨЛӨӨ, ТЕРРОРИЗМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМААРАЛ

*Э.Дашгаадан
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Терроризмтой холбоотой эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалд тулгуурлан улс орон, бүс нутаг, олон улсад аюул заналхийлэл учруулдаг терроризмын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, түүнчлэн, шинэ үеийн террорист хандлагын шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар авч үзсэн.

Түлхүүр үг: Терроризм, Фето бүлэглэл, эдийн засгийн нөлөө, шалтгаан, нөхцөл.

Удиртгал

Терроризм нь тухайн улс, бүс нутаг, олон улсын хэмжээнд сөрөг нөлөө ихээр үзүүлж байна. Ялангуяа, улс орнуудыг хөгжин цэцэглэх, хүчирхэгжих, төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд байнга саад учруулж байна.

Латинаар 'terre' гэсэн үгнээс гаралтай террор гэдэг үг "айдас төрүүлэх, айдас түгшээх" гэсэн утгаар хэрэглэгддэг ажээ. Террор гэх үг анх 1789 онд "Dictionnaire de l'Academie Française" гэх тайлбар тольд хэвлэгдсэн байна.¹⁹ Терроризм гэж үндсэн үзэл суртлынхаа зорилгод хүрэхийн тулд түүн рүү чиглэсэн улс орны гадаад болон дотоод аюулгүй байдал, нийтийн хэв журам, амар тайван байдлыг алдагдуулах үйл ажиллагааг бүлэглэлийн зохион байгуулалтаар гүйцэлдүүлэхийг хэлнэ.

2019 онд баталсан Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд энэхүү хуулийн зорилтыг "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино." Гэж тодорхойлсон.

Үндсэн хэсэг

"Терроризм" гэх ойлголт нь хүч хэрэглэх, аюул занал учруулах гэсэн Латин гаралтай үг бөгөөд энэ ч утгаараа төрийн үйл ажиллагааг эсэргүүцэх, үгүй хийхийг гол зорилгоо болгодог онцлогтой. Гэвч эрдэмтэн, судлаачдын санал нэгтгэйгээр тодорхойлсон тодорхойлолт одоог хүртэл байхгүй байна. Учир нь улс орон, үндэстнүүд харилцан адилгүй зан заншил, үнэт зүйлтэй бөгөөд нэгдсэн нэг тодорхойлолтыг бүх улс оронд хэвшүүлэх боломж бага юм. Терроризмыг ерөнхийдөө заналхийлэл дэлгэрүүлэх замаар улс төрийн өрсөлдөөнийг үгүй хийх үйл ажиллагаа гэж ойлгодог. Дэлхийн аль хэсэгт байгаагаас үл хамааран бүх улс орон энэ төрлийн халдлагын бай болж байдаг. Арга барилын хувьд техник, технологийн хөгжлийн үр дүнд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тул терроризмтой тэмцэх нь орчин үед улс орнууд дангаараа бие даан хэрэгжүүлэх хэм хэмжээнээс хэтрээд байна.²⁰

Терроризмтой тэмцэх үйл ажиллагаа нь даяаршихаас өөр аргагүй болж байна гэсэн үг юм. Энэ нь террорист бүлэглэлүүд олон улс руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг болсонтой салшгүй холбоотой.

Аливаа террорист халдлагаас сэргийлэхийн тулд улс орнууд өөрсдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалахад, террорист халдлагын эрсдэлийг бууруулах алхмуудад, мөн террорист үйл ажиллагааны золиос болж хохирсон иргэдэд тусламж үзүүлэх зэрэгт их хэмжээний төсвийг зарцуулж байна. Терроризмтой тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай болохын зэрэгцээ ерөнхий нэг ойлголт, ерөнхий нэг стратеги одоог хүртэл хөгжүүлээгүй байгаа нь сул тал болж байна.²¹

Өнөөгийн нийгмийн гол асуудлуудын нэг нь ядуурал юм. Терроризм ба ядуурал нь шууд хамааралтай гэх дүгнэлт нь хэдий маргаан дагуулдаг ч энэ хоёр үзэгдэл нь бие биедээ харилцан нөлөөлөл үзүүлдэг гэдэгт эрдэмтэн, судлаачид санал нийлдэг. Өөрөөр хэлбэл,

¹⁹ Walter Laquer, Terrorism, Little Brown and Company, Boston, 1977

²⁰ Mehmet Koca, "Küresel ve Bölgesel Örgütlerin Terörizmle Mücadele Stratejileri", AREM

²¹ Abdülkadir Baharçipek ve Gökhan Tuncel, Terörle Mücadelenin Zorlukları ve Bu Zorlukları Aşmada Farklı Bir Yaklaşım: Demokratik Mücadele Yöntemi, Ankara, Uluslararası Güvenlik ve Terörizm Dergisi, 2011

терроризмын нөлөө өсөн нэмэгдэх нь ядуурлын нэг шалтгаан болох ба ядуурал ч гэсэн терроризмын нөлөө нэмэгдэх шалтгаан болдог.

Аливаа улс орон терроризмыг өөрсдийн үнэт зүйлс аюулд өртөх эрсдэл, терроризмтой тэмцэх нь тухайн улсын дотоод асуудал гэж үзсээр иржээ. Голцуу зэвсэгт тэмцлийн аргыг хэрэглэдэг хэдий ч маш олон төрлийн шинэ стратеги хэрэгжүүлсээр байна. Терроризмын аюул занал, хор хөнөөл олон улсыг хамарсан түвшинд нөлөөлж эхэлсэнтэй зэрэгцэн терроризмтой тэмцэх асуудал нь олон улсын, бүс нутгийн байгууллагууд проактив арга хэмжээ хэрэгжүүлж, нэгдмэл хамтын ажиллагааг эрхэмлэн олон төрлийн шинэлэг стратеги боловсруулах хандлагатай болжээ.²²

Терроризмыг ялгах гурван шинж байдаг. Эхнийх нь терроризм улс төрийн зорилгыг агуулдаг. Өөрөөр хэлбэл, террорист халдлагууд нь улс төрийн бодлогод нөлөөлөхийг зорьдог. Хоёр дахь хэмжүүр бол террорист халдлага нь энгийн иргэд рүү ихэвчлэн чиглэдэг. Энгийн иргэд гэдэгт зэвсэгт хүчний алба хаагчдаас бусад хүмүүсийг хамааруулан ойлгоно. Гурав дахь шинж нь этник соёл, нууцлал бүхий тагнах бүлэг террорист аливаа үйл ажиллагааг удирддаг.²³ Үүнээс үзвэл, терроризм гэх ойлголтыг бүрдүүлэх гурван хүчин зүйл гарч ирдэг. Эдгээр нь үзэл баримтлал, бүлэглэл, хүчирхийлэл юм. Террорист бүлэглэл нь өөрсдийн гэсэн үзэл баримтлалд тулгуурлан стратеги, арга барилаа тодорхойлдог. Тухайлбал, шашин, улс төрийн сөрөг үзлийг дэвэргэж, гишүүн элсүүлэх, бусдыг итгүүлэх зэрэгт энэ нь чухал ач холбогдолтой.²⁴ Терроризм гэх ангилалд багтахын тулд бүлгийн шинжийг агуулах хэрэгтэй. Террорист бүлэглэл нь хууль бус олонлог бөгөөд удирдлага нь ихэвчлэн нууцлалтай байдаг. Террорист бүлэглэл улс төрийн аливаа зорилгодоо хүрэхийн тулд хүчирхийлэл үйлддэг. Энэ нь нийгэмд айдас төрүүлэх, аюулгүй байдлыг тогтворгүйжүүлэх зэргээр каос орчинг бүрдүүлдэг.

Үүний зэрэгцээ терроризм, түүнд нөлөөлдөг эдийн засаг, этник, нийгэм, соёлын болон улс төрийн нөхцөл байдлыг дүгнэн бүхий л давхарга, салбарт дорвитой арга хэмжээ авахгүйгээр бодитой үр дүнд хүрэхгүйг ойлгох хэрэгтэй. Улс орон терроризмтой дангаараа тэмцэж чадахгүй гэх үзэл нэмэгдсээр байгаа ч 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн халдлага хүртэл Европын холбооны зарим үйл ажиллагааг эс тооцвол бусад олон улсын байгууллага, АНУ, Англи зэрэг улс орнууд ч олон улсын шинжтэй үйл ажиллагаанд санаачлага гаргаагүй байсан юм.

Терроризмыг зөвхөн алан хядагчид, зэвсэгт халдлага, том гүрнүүдийн нууцаар удирддаг үйл ажиллагаа зэрэг ойлголт иргэдийн дунд байдаг бол орчин үед шинэ үеийн терроризм бий болон улам нарийн тогтолцоотой болж байгаа бөгөөд улс орны төр, удирдлагын тогтолцоонд ил болон далд байдлаар нөлөөлж байгаа нь сүүлийн жилүүдэд маш олон жишээгээр тодорхой болж байна. Тухайлбал, соёл уламжлал, түүх, газар зүй, эдийн засаг, геополитикийн өвөрмөц тогтолцоот орон болох Бүгд Найрамдах Турк улсад сүүлийн 10 жил анхаарлыг маш их татаад буй Фето гэх террорист бүлэглэлийн үйл ажиллагаа юм. Тус бүлэглэл нь сүүлийн 50 жилийн хугацаанд зөвхөн хүний нөөцийг бэлтгэхэд анхаарч ажилласан бөгөөд гол нь тэдгээр гишүүдээ аль болох нууцлан төрийн албанд элсүүлэх, тухайлбал, шүүх, прокурор, цагдаа, цэргийн салбарт элсүүлж, тэдний ажилдаа амжилт гаргах, дэвших, эрх зүйн байдлыг нь дэмжих зэргээр далдуур хүчээ зузаатгаж байсан болох нь тогтоогддог.

Энэ нь аливаа нэг улс төрийг эсэргүүцсэн үйл ажиллагааг зохион байгуулах, түүнийг дэмжих, хаацайлахад тохиромжтой орчинг олон жилийн хугацаанд бага багаар бэлтгэсэн гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, улс оронд онц ноцтой байдал илрэхэд хууль ёсны удирдлагын үүрэг даалгаврыг үл ойшоож, шууд террорист бүлэглэлээс авсан үүргээ биелүүлэх эрх бүхий олон алба хаагч бий болж, параллель төрийг бий болгоно гэсэн үг. Энэ нь маш олон нотлох баримтаар тогтоогдсон бөгөөд олон улсад Фето бүлэглэлийг хүчирхийлэл, халдлага үйлдээгүй гэх шалтгаанаар террорист бүлэг гэх ангилалд хамруулаагүй юм.

Ингэснээр төрийн эрхийг булаан авах, улмаар аливаа нэг улс орны цэргийн хүч өөрсдийн иргэд рүүгээ, өөрийн бусад албад руугаа ямар ч эргэлзээгүй гал нээх зэрэг үзэгдлийг

²² Koca, Küresel ve Bölgesel Örgütlerin Terörizmle Mücadele Stratejileri

²³ Özçelik, Ö. & Önder, H. (2016). Savunma Harcamalarına Terör Riskinin Etkisi: Ampirik Bir Uygulama. Dumlupınar Üniversitesi Sosyal Bilimler Dergisi, 1(1); 36-45.

²⁴ Gürel, M. M. (2008). Küreselleşen Dünya Ve Terörizm. Yayınlanmamış Yüksek Lisans Tezi. Kadir Has Üniversitesi, SBE, Uluslararası İlişkiler ve Küreselleşme Anabilim Dalı, İstanbul. Güvenek

Турк улсын 2016 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн халдлагын жишээнээс харж болох юм. Энэхүү бүлэглэл нь дэлхий дахинд тархсан сүлжээтэй байх бөгөөд санхүүгийн эх үүсвэрийг маш олон байдлаар бүрдүүлдэг байна. Тухайлбал, арилжаа, наймаа, тусламж, тэтгэлэг, сургалт, соён гэгээрүүлэх зэрэг халхавчийг ашиглан мөнгө угаадаг. Тухайлбал, дэлхийн олон оронд Турк сургууль үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тухайн сургуулийн төлбөр нь шууд ба шууд бус замаар фето террорист бүлэглэлийг санхүүжүүлдэг нь тогтоогддог.²⁵

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг хянах, зогсоох журам”-ын дагуу Монгол Улсад буй хүн бүр санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

НҮБ-ын дүрмийн 41 дүгээр зүйлд “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс зэвсэг, хүч хэрэглэхгүйгээр хориг арга хэмжээ болон бусад арга хэмжээ авч хэрэгжүүлж болно” гэж заасан. Терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоол нь гишүүн улс орнуудыг санхүүгийн зорилт хориг арга хэмжээ хэрэгжүүлэхийг шаарддаг.

Улсын хэмжээний гэмт хэргийн статистик мэдээнээс авч үзвэл, Монгол Улсын хэмжээнд 2018 онд хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн байна.²⁶ Гэвч терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэлт бага байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ нь дараах хоёр төрөлтэй байна. Үүнд: 1.Террорист этгээд, террорист байгууллагын жагсаалтад орсон этгээдийн хөрөнгөтэй холбоотой эсхүл тэдгээрт санхүүгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой асуудлаар санхүүгийн зорилт хориг арга хэмжээ. 2.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд чиглэсэн санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Wells Fargo, HSBC, Citibank, Mashreq Bank PSC, Deutsche Bank AG, Commerzbank, Barclays Bank PLS, Standard Chartered зэрэг АНУ болон Европын холбооны банкууд манай арилжааны банкуудын ам.долларын дансыг хаасан байна. Хаах болсон шалтгааныг авч үзвэл, дараах 2 шалтгаанаар хаажээ. Үүнд: 1.Комплаенсийн зардлаа танах шийдвэрт хүрсэн тул бага гүйлгээ хийгддэг дансуудыг хаахаар шийдвэрлэсэн. 2.Тухайн банкны бизнес төлөвлөгөөний дагуу зарим бизнесээс гарах, цар хүрээг хумих шийдвэрт хүрсэн эдгээр болно. Энэ хоёр шалтгаан нь үндсэндээ нэг шалтгаан болох нь ажиглагдаж байна. АНУ болон Европын холбооны улсуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалт, торгуулийн арга хэмжээ ихээхэн чанга байгаа нь дээр дурдсан томоохон банкуудын хувьд ашиг багатай, эрсдэл өндөртэй корреспондент харилцаанаас татгалзахад хүргэж байна. Тухайлбал, Deutsche Bank AG 2017 оны 1 дүгээр сард 630 сая ам.доллар, 5 дугаар сард 41 сая ам.долларын торгууль хүлээсэн. HSBC банк 1,92 тэрбум, Citibank 97,44 сая ам.долларын торгууль хүлээсэн нь олон нийтэд ил болсон.²⁷ График №1 Террорист халдлагын улмаас нас барсан иргэдийн судалгаа /тивээр/


²⁵ <http://www.arслан.mn/social/news/605198.shtml>

²⁶ Гэмт хэргийн статистик мэдээ. 2019 он

²⁷ Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдлийн үнэлгээ. 2018 он

Deaths from terrorism, 2017

Confirmed deaths, including all victims and attackers who died as a result of the incident.



Source: Global Terrorism Database (2018)

OurWorldInData.org/terrorism/ • CC BY

Note: The Global Terrorism Database is the most comprehensive dataset on terrorist attacks available and recent data is complete. However, we expect, based on our analysis, that longer-term data is incomplete (with the exception of the US and Europe). We therefore do not recommend this dataset for the inference of long-term trends in the prevalence of terrorism globally.

Террорист халдлагаас улмаас нас барсан иргэдийн 2017 оны судалгааг авч үзвэл, Ойрхи Дорнод 10819, Өмнөд Ази 7664, Африк 6712, Зүүн өмнөд Азид 811 иргэн хохирсон гэж бүртгэгджээ. Энэ нь зөвхөн нэг жилийн дүн гэхэд маш өндөр үзүүлэлт бөгөөд улс орны онцлогийг авч үзвэл, ихэвчлэн хөгжиж буй орнууд байгаа нь терроризм ба эдийн засгийн нөхцөл байдал шууд хамааралтай гэдэг нь харагдаж байна.²⁸


Терроризмын эдийн засагт учруулах хор нөлөө, үр дүнг нарийвчлан гаргах нь хүндрэлтэй. Сүүлийн жилүүдэд терроризмтой тэмцэхэд зарцуулах зардал болон зарим санхүүгийн төсөвтэй холбоотой олон судалгаа хийгдсэн байна. Террорист халдлага нь онцгой нөхцөл байдал тул эдийн засгийн нөлөөг хэмжих нь маш хүндрэлтэй. Үүнээс гадна терроризмын эдийн засагт нөлөөлөх нөлөө нь тухайн улс орны хөгжлийн түвшин, террорист халдлагын дараа авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон хэд хэдэн хүчин зүйлтэй хамааралтай. Тухайлбал, террорист халдлага нь аль нэг улсын үнэт бахархал, чухал объект руу халддаг. Терроризм нь нийгэмд тогтворгүй байдлыг бий болгодог ба үүнээс шалтгаалан хадгаламж, хувьцаа зэрэг санхүүгийн эх сурвалжуудад огцом нөлөөлдөг. Террорист халдлага нь аль нэг улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөхөд өөр нэг улсад энэ нь ашигтай тусдаг. Терроризмоос шалтгаалж улс орны аюулгүй байдлыг хангах салбарт төсөв ихээр тусган баталж, зардал их гаргах нь бусад ач холбогдолтой салбар луу тусгах төсөвт саад болдог. Эцэст нь хөгжиж буй орны эдийн засгийн гол хөшүүрэг болдог аялал жуулчлалын салбарт сөрөг нөлөө үзүүлдэг.²⁹

Аюулгүй байдлын эдийн засаг гэдэг нь аюулгүй байдалд нөлөөлөх, урьдчилан сэргийлэх, тэмцэх, бууруулах үйл ажиллагааг хамааруулан ойлгодог.

²⁸ Global Terrorism Database. 2018

²⁹ Ağır, H. & Kar, M. (2010). Terörizmin Makroekonomik Sonuçları Üzerine Bir Değerlendirme. Finans Politika ve Ekonomik Yorumlar Dergisi, Sayı.539, 13-32.

График №2 Терроризмтой тэмцэхэд зарцуулж буй зардал



Судалгаанаас авч үзвэл, дэлхийн терроризмтой тэмцэхэд зарцуулж буй зардал нь террорист халдлага их гарсан жилүүдэд болон түүний дараагийн жилүүдэд огцом өсөх бөгөөд удалгүй багасдаг. Тухайлбал, 2001 онд 79 тэрбум долларыг терроризмтой тэмцэхэд зарцуулсан нь АНУ-ын 9 дүгээр сарын 11-ний өдрийн халдлагатай холбоотой бол 2012-2016 онд тогтмол их төсөв гаргасан нь 2012 оноос хойш Европын улсууд, Австрали, Шинэ Зеландад гарсан террорист халдлагатай шууд холбоотой байна.³⁰

Терроризмтой тэмцэх стратеги олон улсын хамтын ажил гэх ойлголт 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр АНУ-д болсон террорист халдлагын дараа анхлан анхаарал татсан юм. Түүнээс өмнө НҮБ терроризмтой тэмцэхээс гадна улс орнуудын хооронд үүссэн маргаан болон бусад асуудлыг гэрээ хийх буюу энхийн замаар шийдвэрлэх арга зам, стратегийг баримталж ирсэн.

Үүнээс гадна 2005 онд терроризмын эсрэг олон улсын түвшинд стратеги боловсруулахаар зохион байгуулагдсан Мадридын уулзалтанд Кофи Аннан таван чиглэл бүхий стратеги танилцуулжээ. Үүнийг 5D стратеги гэж нэрлэсэн бөгөөд дараах зорилтыг тусгажээ.

- Ямар нэгэн бүлэглэл зорилгоо хэрэгжүүлэхийн тулд терроризмыг тактик болгон ашиглахаас татгалзах;
- Террорист үйл ажиллагааны үед хэрэглэж байгаа зэвсэг техникийн хангалтыг саатуулах;
- Улс орнууд терроризмд тусламж дэмжлэг үзүүлэхээс татгалзах;
- Улс орнуудын терроризмоос урьдчилан сэргийлэх чадамжийг нэмэгдүүлэх;
- Терроризмтой тэмцэхэд хүний эрхийг дээдлэх³¹

Терроризмтой тэмцэхэд юуны түрүүнд судлах ёстой үндсэн асуудал бол терроризмын үүсэх шалтгаан юм. Энэ нь ихэвчлэн нийгэм, эдийн засаг, улс төрийн шалтгаанаар бий болдог.³² Террорист арга замыг сонгогчид өөрсдийнх нь улс оронд эдийн засгийн хямрал, дарангуйллын засаглал, ашгийн тэгш бус хуваарилалт, шударга бус байдал зэрэг нөхцөл байдлыг шүүмжилдэг. Энэ нөхцөл байдалд ихэнхи террорист бүлэглэлүүдийн хэрэгжүүлдэг арга нь салан тусгаарлах терроризм юм. Энэ төрлийн терроризмын зорилго нь террорист бүлгийн дуу хоолойг нэмэгдүүлэх, олны анхаарлыг татах явдал юм. Энэ үед терроризмтой тэмцэх хамгийн сайн аргуудын нэг бол терроризмыг өдөөж буй нийгэм, эдийн засгийн асуудлыг шинэчлэлээр шийдвэрлэх, улс орны хөгжил, тэнцвэртэй орлогыг хангах явдал юм.

Өөр нэг үр дүнтэй арга бол үзэл бодлын талбарт терроризмтой тэмцэх явдал юм.³³ Үнэн хэрэгтээ энэ бол бүх төрлийн терроризмтой тэмцэх арга юм. Тэмцлийн хэлбэр нь хүчирхийлэл биш үзэл суртлын дайн болж хувирах ёстой. Түүнчлэн, терроризм бол шийдэл

³⁰ <https://www.statista.com/statistics/489649/global-economic-costs-of-terrorism/>

³¹ Ömer Yılmaz, "İspanya Terörle Mücadelede Medeniyetler İttifakı Olabilir mi?", Terörizm; Terör, Terörizm ve Küresel Terörle Mücadelede Ulusal ve Bölgesel Deneyimler, (Ed.İhsan Bal), Ankara, 2006

³² Bülent Daver, "Demokrasinin Temel Prensipleri ve Terörizmle Mücadelede Bu Prensiplerin Önemi", Ankara, 1986

³³ BarnettRubin, TheFragmentation of Afghanistan, New Haven, 2002

биш бөгөөд энэ замыг сонгох ёсгүй гэж залуучууд, хойч үеийнхэнд итгүүлэх нь чухал юм. Үүнийг хэрэгжүүлэхэд хүмүүсийн үнэт зүйлд төвлөрсөн тогтолцоотой уялдуулан боловсролын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна. Улс орнуудын ардчиллын түвшин дээшлэх нь терроризмтой тэмцэх өөр нэг гарц юм.

Дүгнэлт

Терроризм нь илрэх хэлбэр, хор хөнөөлийн хувьд дэлхий нийтээр анхаарах асуудлын нэг болжээ. Даяаршлын эрин зуунд терроризм ч даяарших хандлагатай байгаа бөгөөд улс орны дотоод аюулгүй байдлаас хэтрээд байна. Террорист халдлага нь тухайн улс орнуудад эерэг, сөрөг аль нэг байдлаар нөлөөлдөг. Ялангуяа, сүүлийн жилүүдэд буурай, хөгжиж буй орнуудад терроризмын заналхийлэл их байгаа дүр төрх судалгаанаас харагдаж байна. Террорист халдлагаас шалтгаалан нас барсан иргэдийн тоо нь улс орны хөгжилтэй шууд хамааралтай, терроризмын индекс хүний хөгжилтэй мөн шууд хамааралтай байна. Аливаа нэг улсад эдийн засгийн нөхцөл байдал сайжрах нь явцуу утгаараа террорист үйл ажиллагаанд оролцох хүний тоог багасгах нөлөөтэй гэж хэлж болох юм. Баялгийн тэгш хуваарилалт, хувь хүний орлогыг нэмэгдүүлэх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг сайжруулахад чухал нөлөөтэй хэдий ч нийгмийн болон улс төрийн хүчин зүйл дэх нөлөөлөл харилцан дэмжихгүй бол ямар ч ач холбогдолгүй.

Терроризмтой тэмцэх нь шууд зэвсэгт халдлагатай, эсвэл алан хядагчидтай тэмцэх биш бөгөөд терроризм жил ирэх тусам агуулга, хэлбэрээ өөрчилж байна. Хууль ёсны мэт, бүлэглэлийн шинжгүй, эсвэл хүчирхийлэл огт хэрэглэхгүйгээр далд байдлаар улс төрийн эрх мэдлийг унагаах зэрэг байдлаар илрэх хандлагатай болсон нь түүний шалтгаан, нөхцлийг сайтар судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатайг илтгэж байна. Мөн терроризм нь зөвхөн тухайн улсын аюулгүй байдал биш бүс нутаг, хэд хэдэн улс, цаашлаад олон улсад нөлөөлдөг бөгөөд олон улс, хамгийн багадаа хөрш улсууд хамтран арга хэмжээ зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Санал

1. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ, дүгнэлтийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлд тус тус танилцуулж, эрсдэл өндөр гарсан салбаруудад чиглэсэн эрсдэлийг бууруулах, арилгах зөвлөмж боловсруулж үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;
2. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх төрийн зохицуулагч байгууллага хоорондын уялдаа холбоо болон хяналт тавих эрх бүхий байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох замаар терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэх, сайжруулах;
3. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авахтай холбоотой эрх зүйн орчин зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны давхцал, хуулийн цоорхой, дэглэмийн давхардлыг арилгах шаардлагатай байна.
4. Терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт тавих эрх бүхий байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, санхүүгийн мөрдөн шалгах үйл ажиллагааг олон улсын түвшинд нийцүүлэн хэрэгжүүлэх ажлуудыг шат дараалан авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль. 2019 он
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015 он

Хоёр. Ном, сурах бичиг гарын авлага

- Walter Laquer, Terrorism, Little Brown and Company, Boston, 1977

- Mehmet Koca, “Küresel ve Bölgesel Örgütlerin Terörizmle Mücadele Stratejileri”, AREM
 - Abdülkadir Baharççek ve Gökhan Tuncel, Terörle Mücadelenin Zorlukları ve Bu Zorlukları Aşmada Farklı Bir Yaklaşım: Demokratik Mücadele Yöntemi, Ankara, Uluslararası Güvenlik ve Terörizm Dergisi, 2011
 - Koca, Küresel ve Bölgesel Örgütlerin Terörizmle Mücadele Stratejileri
 - Özçelik, Ö. & Önder, H. (2016). Savunma Harcamalarına Terör Riskinin Etkisi: Ampirik Bir Uygulama. Dumlupınar Üniversitesi Sosyal Bilimler Dergisi, 1(1); 36-45.
 - Gürel, M. M. (2008). Küreselleşen Dünya Ve Terörizm. Yayınlanmamış Yüksek Lisans Tezi. Kadir Has Üniversitesi, SBE, Uluslararası İlişkiler ve Küreselleşme Anabilim Dalı, İstanbul. Güvenek
 - Ağır, H. & Kar, M. (2010). Terörizmin Makroekonomik Sonuçları Üzerine Bir Değerlendirme. Finans Politika ve Ekonomik Yorumlar Dergisi, Sayı.539, 13-32.
 - <https://www.statista.com/statistics/489649/global-economic-costs-of-terrorism/>
 - Ömer Yılmaz, “İspanya Terörle Mücadelede Medeniyetler İttifakı Olabilir mi?”, Terörizm; Terör, Terörizm ve Küresel Terörle Mücadelede Ulusal ve Bölgesel Deneyimler,(Ed.İhsan Bal), Ankara, 2006
 - Bülent Daver, “Demokrasinin Temel Prensipleri ve Terörizmle Mücadelede Bu Prensiplerin Önemi”, Ankara, 1986
 - BarnettRubin, TheFragmentation of Afghanistan, New Haven, 2002
- Гурав. Судалгааны тайлан, эмхэтгэл
- Монгол Улсын терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ. 2018
 - Гэмт хэргийн статистик мэдээ. 2019
 - Global Terrorism Database. 2018

--o0o--

ГЭР БҮЛИЙН ОРЧИН ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ БОЛОХ НЬ

*Д.Цэрэнлхам
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч*

Товч агуулга: Өсвөр насныхны үйлдэж буй гэмт хэргийн талаар дэлхий нийт анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хүчирхийлэлд хүргэх түрэмгий зан үйл нь голдуу өсвөр насныханд илэрдэг нийгэмд ноцтой сөрөг үр дагавартай, орлого багатай болон нийгэм, эдийн засгийн хувьд тогтворгүй, хөгжиж байгаа улсуудад өндөр үзүүлэлттэй байгааг ДЭМБ анхааруулж байна.

Өсвөр насныхан гэмт хэрэг үйлдэхэд гэр бүлийн хүмүүжил, эцэг, эхийн үүрэг оролцоо хэрхэн нөлөөлж байгаа талаар Америкийн Нэгдсэн Улс болон манай улсын жишээн дээр судалж, дүгнэлт, санал боловсруулсан.

Түлхүүр үг: Гэр бүл, хүүхэд, өсвөр насны хүн, гэмт хэрэг, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн эрхийн тухай конвенцид “18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ.³⁴” гэж тодорхойлсон байдаг. Хүний танин мэдэхүйн үйл явц болон сэтгэл зүйн онцлог нь наслалттай хамт өөрчлөгдөж байдаг. Өсвөр насны хүнд хэдээс хэдэн насны хүн хамаарах талаар улс бүр хууль тогтоомждоо ялгаатай байдлаар хуульчилсан байдаг.

Монголчууд өсвөр насыг өөлэй нас буюу өсгөл нас, орь залуу насны суурь 12-16 нас, адуучин нас буюу өглөөний нарнаас өрсөн адуу хураах, өвлийн шөнө адуу манах цээнд хүрэх үе болох 17, түүнээс дээш хэмээн ойлгож байжээ.³⁵

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ДЭМБ-ын тодорхойлолтоор өсвөр нас гэдэг нь хүүхэд ахуй нас ба орь залуу насны хооронд орших үе шат бөгөөд 10-19 насныхан юм. Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүүхэд хамгааллын тухай хуульд 9-24 нас хүртэлх хүмүүсийг багтаан хуульчилсан байдаг бол Horlock хүний хөгжил сэтгэл зүйн талаас нь 12-21 насныхан, E.L.Thorndike боловсролын талаас нь 14-18 насныхан нь өсвөр насны өмнөх үе, 18-25- насныхан нь өсвөр насны дараах үе, Kohl-н ангилалаар бол анагаахын шинжлэх ухааны талаас нь 15-18 нас өсвөр насны өмнөх үе, 18-24 нас нь өсвөр насны дараагийн үе болно гэж тус тус тодорхойлсон байдаг.

D.Bromley хүний хөгжлийг үндсэн 5 мөчлөгт буюу үр хөврөлийн үе, хүүхэд нас, залуу нас, насанд хүрсэн үе, өтөл нас гэж хуваадаг. G.Graig “Хөгжил бол хүний бие махбодид явагдаж байгаа биологийн процессууд болон орчны нөлөөллийн үр дүнд хүний бие организм, сэтгэхүй, зан үйлд гарч буй өөрчлөлт мөн” хэмээн үзэж, 12-19 насыг өсвөр болон залуу нас, 20-40 насыг идэр насанд багтаажээ.

Дэлхийн олон улс орнуудад өсвөр үе, залуучууд хүн амын дотор томоохон бүлгийг эзэлдэг. Дэлхийд 10-24 насны 2 тэрбум орчим хүн амьдарч байгаа бөгөөд манай улсын хэмжээнд энэ насныхан 2020 оны байдлаар нийт хүн амын 22.3%-ийг³⁶ эзэлж байна.

Сүүлийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр, цагдаа, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудаас тодорхой ажлыг санаачлан хийж байгаа боловч өсвөр насныхны гэмт хэрэг үйлдэх явдал төдийлөн буурахгүй байна.

Монгол Улсад ерөнхий боловсролын 800 орчим сургуульд 1.2 сая хүүхэд суралцдаг ба улсын хэмжээнд хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд, 2015-2019 он буюу сүүлийн 5 жилийн хугацаанд 18 хүртэлх насны 5945 хүүхэд 13 төрлийн гэмт хэрэг үйлдсэн байна.³⁷ Тодруулбал, 14-16 насны хүн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэмт хэрэг болох “Хүнийг алах”, “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай

³⁴ Хүүхдийн эрхийн тухай конвенци., 1989 он.

³⁵ Т.Галсан “Мэдэхгүй хангал үг, мэдүүштэй монгол үг” УБ., 2004.

³⁶ <https://www.1212.mn/>

³⁷ Police.gov.mn. ЦЕГ-ын Гэмт хэрэг, зөрчлийн 2015-2019 оны статистик, тоон мэдээ

учруулах, “Хүчиндэх”, “Хулгайлах”, “Дээрэмдэх”, “Эд хөрөнгө устгах, гэмтээх”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах”, “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах”, “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах”, “Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах”, “Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах”, “Террор үйлдэх” гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Улсын хэмжээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 53 алба хаагч ажиллаж байгаа бөгөөд нэг хүүхдийн байцаагчид 12-15 сургууль, 20-25 мянган хүүхэд ногддог. Жилийн хугацаанд тухайн хүн 40 орчим хувьд нь л хүрч ажиллах боломжтой байдаг аж.

Улс, орнуудад насны хязгаарыг янз бүрээр хуульчилсан ч олонхийн наснаас доогуур байгаа учраас “Насанд хүрээгүй хүн” гэсэн үг хэллэгийг хэрэглэж, хуулийн дагуу хүүхэд буюу нийгмийн цөөнх гэсэн бүлэгт хамааруулна. Гэхдээ “хүүхэд” эсвэл “насанд хүрээгүй хүн” гэх хууль, эрх зүйн тогтолцоонд хэрэглэж буй үг хэллэгийг хүний биологийн болон сэтгэл зүйтэй холбоотой өсөлт хөгжилт, биеийн ерөнхий бойжилт бүрэн явагдах, эсвэл нийгэмд эзлэх байр суурь нь төлөвшсөн зэрэгтэй шууд холбон авч үзэж болохгүй юм.

Хүүхэд согтууруулах ундаа уух, тамхи татах зуршил, өсвөр насны хүүхдүүдийн бүлэглэл, тэдний үйлдсэн хүчирхийлэл, өсвөр насны хүүхдийн үйлдсэн бусад олон төрлийн гэмт хэрэг, зөрчил одоог хүртэл нийгмийн анхаарлыг татсан хэвээр байна. Тодруулбал, жилд дунджаар 1000-1200 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагддаг. Нийт гэмт хэргийн 78%-ийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хулгайлах, залилах, дээрэмдэх гэмт хэрэг эзэлдэг.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, холбогдсон хүүхдийн хувийн байдлыг судлахад дийлэнх нь урьд өмнө нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа бөгөөд нийтлэг байдлаар нь авч үзвэл, эцэг, эхийн хайр халамж дутах, ядуурал, ажилгүйдэл, тэнүүчлэл, бусдын сөрөг нөлөө, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн үндсэн шалтгаан, нөхцөл болдог. Энэ дундаас эцэг, эхийн үүрэг оролцоо, гэр бүлийн орчин энэ төрлийн гэмт хэргийн гол шалтгаан болж байна гэж тодорхойлж болно.

Ихэнх тохиолдолд хувь хүний зүй зохистой бус зан чанар, чадвар, чадамж, санхүүгийн хямрал, ханийн итгэл эвдсэн үйлдэл болон бусад шалтгааны улмаас буюу дараалж хуримтлагдсан хэд, хэдэн үйл явдал, нөхцөл байдлын үр дүнд гэр бүл салах шийдвэр гардаг. Тэдгээр учрал, зөрчилдөөн өрнөх бүрт эцэг, эхийн хооронд маргаан, хэрүүл, дайсагнал давтан гарч, гэр орондоо байгаа хүүхдүүд бүхнийг харж, сонсч, сэтгэл нь сэвтэж байдаг. Ийм орчинд байгаа хүүхдийн зан авир, төлөвшилд өөрчлөлт орж улмаар гэмт хэрэгтэн болох нөхцөл бүрдэж байдаг.

Цаашлаад ийм зөрчилдөөний улмаас нийгмийн харилцааны сөрөг бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг нийгмээс хөндийрөх уур амьсгал гэр бүлийн гишүүдийн дунд бий болохыг үгүйсгэхгүй.

Хүүхэд хүмүүжлийн эхний “хичээлээ” гэр бүлээсээ авдаг. Гэр бүлийнх нь амьдрал, хүмүүсийн зан байдал, хоорондын харилцаа нь хүүхдэд ямар нэгэн эргэлзээгүйгээр шууд дагах мөрдлөг, амьдралын суурь зарчим болдог.³⁸

Гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаа хүүхдийн шалтгааныг гэр бүлийн орчноос тодруулбал:

Эцэг, эх, асран хамгаалагчаас шалтгаалах:	Хүүхдээс шалтгаалах:
✚ Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл; ✚ Эцэг, эхчүүдийн хэрүүл маргаан, таагүй харилцаа; ✚ Гэр бүл салалт; ✚ Эцэг, эхийн хараа хяналт сул, халамж анхаарал төдийлөн тавьдаггүй байдал; ✚ Гэр бүлийн орчин дахь эцэг, эхийн	✚ Хүүхдийн ухамсар, хүмүүжлийн доголдолтой байдал; ✚ Амар хялбар аргаар мөнгө олох сэтгэлгээтэй болсон; ✚ Амьдралын үнэ цэнийг мөнгөтэй холбон үзэх үзэл бодол бий болсон ✚ Сэтгэл зүйн хатуужил, эр зоригийн хүмүүжил, бие даасан байдал төлөвшөөгүй;

³⁸ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага., 2017 он.

архидалт;  Хүүхдийн нас, бие бялдар, хөгжлийн онцлогийг мэддэггүй, анзаардаггүй;  Хүүхэдтэй зөв харьцах, тэднийг хүмүүжүүлэх арга барил дутмаг.	 Хүүхдийн өөрийнх нь эмзэг байдал, ганцаардал;  Найз нөхдийн сөрөг нөлөө, бусдыгаа уруу татах;  Хүүхдийн сониуч гэнэн зан, дэмүү сэлгүүцэх, атаман байхыг хүсдэг байдал;  Насанд хүрэгчдийн гар, хөл болох, гэмт хэрэг үйлдэхэд нь оролцох, хамтрах.
--	--

Сүүлийн үед гэрлэгсдийн хагас нь салж, гэр бүлийн бүтэц хойд эцэг, эх эсвэл ганц бие эцэг, эх болж өөрчлөгдөж байгаа нь харамсалтай. Холилдсон гэр бүлүүд хоёр хүүхэд эсвэл олон эцэг, эхчүүдийн нэгдлээс бүрдэх боллоо. Түүнчлэн, маш олон хүүхэд хэт залуу эсвэл гэрлээгүй эцэг, эхчүүдийн гэрт мэндэлж байгааг та бид өдөр тутамдаа мэдээ, мэдээллээс харж байна.

Мөн аз жаргалгүй уур амьсгал давамгайлсан гэр оронд эцэг, эх ба хүүхдийн хооронд хүндрэлтэй нөхцөл байдал үүснэ. Энэ нь ёс суртахууны доголдлын ерөнхий онол ба нийгмийн барилдлагын онолтой холбогдож байгаа юм. Өөрөөр хэлбэл, хүүхдийг хэт их албадсанаар хүүхэд хэдэр, дайсагнасан, цадиггүй араншинтай болж эцэстээ гэмт хэргийн замд ороход хүргэдэг.³⁹

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэдэг гэр бүл доторх харилцааны гол онцлог бол гэр бүлийн гишүүдийн харилцан бие биедээ үзүүлж буй нөлөөлөл гэж зарим судлаачид үздэг. Магадгүй эцэг, эхчүүдийн зүгээс хүүхдээ хянахдаа-маргаантай, мөн үр нөлөө муу сахилга батын аргуудыг хэрэглэж болно. Заримдаа, магадгүй ихэнх тохиолдолд эцэг буюу эх, эсвэл эцэг эх хоёулаа хүүхдийн хүсэл сонирхол, шаардлагыг биелүүлдэг, энэ нь хүүхэд эсэргүүцэх, сөрөх байдлаар хандах зуршил, дадалтай болоход сургаж байгаагаас өөрцгүй, цаашлаад хязгаарлах, хориглох хэв шинжтэй аливаа шаардлага тавихад хүүхэд эсэргүүцлээ хадгалах сэтгэхүйг зан араншиндаа шингээдэг.

Ингээд хүүхэд зан байдлын олдмол араншингаа гэр орноос гадуур орчинд гаргаж, муу үр дагавартай үйлдэл хийж болно. Түүний зан байдлыг хүлээж авахгүй үе тэнгийн хүүхдүүдэд дургүй болж эхлэх агаад улмаар өөрийн зан байдалд тохирсон нэгнийг сонгодог. Харин сонгогдсон тэр хүүхэд өөртэй нь адилхан сахилга батгүй, дайсагнасан, сөрсөн хандлагатай нэгэн байдаг.

Эцэг, эх хүүхдийнхээ харилцааны хүндрэлд буруугаар оролцох нь хүүхэд, залуусын зан чанарт эсэргүүцэж, сөргөлдсөн шинжийг суулгаж; юу хийхийг нь зааж, зааварласан тохиолдолд шууд дайсагнах, тэмцэлдэх, үл ойшоох хандлагатай болдог. Эцэг, эхийн үр нөлөөгүй, зүй зохисгүй харилцаа бол нөхцөл байдлыг улам дордуулах төдийгүй хүүхдийг эсэргүүцсэн, зөрчилдсөн хариу үйлдэл хийхэд сургадаг. Үүнээс гадна үр нөлөө муутай эцэг, эхийн үйлдэл ямар ч хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөмхий болоход хүргэнэ. Цаг хугацааны талаас авч үзвэл хүүхдийг бага балчир байсан ч, өсвөр насанд байлаа ч, мөн бага залуу насанд ч эцэг, эхийн буруу хандлага муу нөлөө үзүүлдэг юм. Эцэг, эхийн зааварчилгаа, шаардлагыг биелүүлдэг, хууль ёс, дүрэм, журмаа дагадаг хүүхдүүд хүртэл эцэг, эхийн хараа, хяналт сулрах, хэт ширүүн харьцах, бусад хэв маягаар үр нөлөө муутай хандах явдалд эмгэгшиж, зан чанарын өөрчлөлттэй болох магадлал их. Гэр бүлийн хүчин зүйлсийг урт хугацааны туршид судлахад эцэг, эхийн хараа, хяналт ба сахилга батын үр нөлөө муутай харьцаа зэрэг хувьсамтгай олон нөлөөллийн улмаас өсвөр насны хүүхдийн ёс суртахуун доголдож, цаашдаа гэмт хэрэг, зөрчил үйлдэх замд ордог болох нь тогтоогдсоор байгаа юм.

Харин Америкийн Нэгдсэн Улсад Гэр бүлийн доторх харилцаа, холбоо ба гэмт хэрэг, зөрчлийн талаарх анхны судалгааг 1950 онд судлаач Глук хийжээ. Тэрээр гэр бүлийн 5 харилцаа байдаг⁴⁰ гэж үзсэн бөгөөд Үүнд:

1. Эцгийн сахилга бат;
2. Эхийн хараа хяналт;
3. Хүүхэддээ санаа тавьдаг эцгийн сэтгэл;
4. Хүүхэддээ санаа тавьдаг эхийн сэтгэл;

³⁹ Орегоны Нийгмийн Судлалын Төв буюу OSLC-ийн эрдэмтдийн судалгаанаас.

⁴⁰ Судлаач Саймонс 2004., 51.

5. Гэр бүлийн эв нэгдэл.

Сахилга бат нь тууштай, зохистой шинжтэй, тийм ч хатуу, чанга биш (бие махбодын шийтгэл шаардлагагүй, гэхдээ хараалын үг хэллэг, зүй бус харьцаагаар илэрнэ); харин хараа хяналт бол “хэр хэмжээндээ тохирсон” ба “голч, шударга”, ойр дотно, халуун дулаан, сэтгэл татмаар байх шинжтэй бол гэр бүлийн эв нэгдэл нь гэмт хэрэг, зөрчилтэй шалтгаант холбоо бараг байхгүй болгох нөхцөл байдалд тооцогддог.

Судлаач Найе-ийн судалгаанд гэр бүлийн биет бүтэц гэхээс илүүтэй гэр бүл доторх харилцаа, холбоо нь гэмт хэрэг, зөрчлийг тайлбарлахад илүү чухал хэмээн дүгнэжээ. Эцэг, эх ба хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдийн дундах сэтгэл санааны таатай холбоо, баяр баясгалантай харилцаа, ойр дотно байдал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шууд нөлөөлнө. Харин эцэг эсвэл эх үгүй гэр бүлийн тухайд ийм холбогдол бараг үгүй гэхэд болно.

Орон гэрт үүссэн асуудал цаашлаад олон нийтийн хүрээнд ороход сургуульд сурах, ангийн орчинд байхад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэнэ. Учир нь багш нар болон үе тэнгийн бусад сурагчид зүй зохистой харьцаа, харилцаа, хариуцлагатай байдлыг зайлшгүй шаардах нь гарцаагүй. Одоо хүүхэд багш нар болон үе тэнгийн хүүхдүүдтэй муу харилцаатай болсноор сургууль дээрээ нилээд хэцүү асуудалтай нүүр тулж, сурлагад нь ч муугаар нөлөөлнө. Ингээд асуудал овоорох тусам хүүхдийн хувьд нөхцөл байдал дордож, сургууль, гэр орондоо тогтох боломжгүй болсноор гэмт хэрэг, зөрчлийн замд өөрийн эрхгүй орно.

АНУ-д хүүхэд гэмт хэрэгт холбогдож байгаагийн шалтгаан, нөхцлийг тодруулах судалгаа⁴¹-г гэмт хэрэгт холбогдсон 40 хүүхэд, тэдний ар гэр, асран хамгаалагчид болох 40 хүн, нийт 80 хүмүүст хийсэн. Судалгааны дүнгээс харахад, гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдийн дийлэнх хувь нь 16-18 насны хүүхдүүд байсан байна.

Судалгаанд хүүхдүүдийн асран хамгаалагчдаас аав нарыг хамруулахыг зорьсон боловч судалгаанд оролцсон хүмүүсийн 72.5% нь эмэгтэйчүүд байсан бөгөөд үүний 57.5% нь төрсөн ээж нь байв. Үүнээс харахад, өрх толгойлсон эхчүүдийн хүүхдүүд гэмт хэрэгт холбогдож байгаа нь илүү их харагдаж байна.

Мөн хүүхдүүдийн зүгээс эцэг, эхийнхээ ойр дотно харилцааны байдлыг үнэлсэн үнэлгээнээс харахад, эцэг, эхчүүд хүүхдээ хэт хамгаалдаг буюу дээд түвшин нь 85% байна. Тухайлбал, “Танай хүүхэд энэ хэргийг санаачилсан уу?” гэсэн асуултад 77% нь үгүй гэж хариулт өгсөн.

Харин асрамж, халамжийн түвшин нь дунд буюу дундаас доош байгаа нь эцэг, эхийн халамж муу байгаагаас хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох нэг шалтгаан гэж үзэж болохоор юм.

Бие махбодын шийтгэл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчил: Эцэг, эх ба хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдийн дундах сэтгэл санааны таатай байдал, баяр баясгалантай харилцаа, ойр дотно байдал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд шууд нөлөөлдөг.

Манай ард түмний хувьд “Таван салаа боов”-ны амтыг үзээгүй, мэдрээгүй хүн тун ховор. Ямартаа л Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр хүүхэддээ гар хүрэх нь битгий хэл чангахан дуугарч болохгүй боллоо хэмээн шүүмжлэх хүн олон байсан. Энэ байдал зөвхөн манай улсад төдийгүй өөр улс, оронд байдаг нэгэн хүмүүжлийн арга юм. Тухайлбал, хүүхдээ таван настай байхад нь бөгсөн дээр нь алгадах зэргээр биед нь гар хүрсэн гэж АНУ-ын эцэг, эхчүүдийн 90 хувь нь хариулсан байдаг.⁴²

“Бие махбодид нь мэдрүүлж шийтгэх нь зөрүүд, сөрөг чиг хандлагатай хүүхдийг хянах үр нөлөөтэй арга мөн үү?” гэх асуултыг та хаа сайгүй сонссон биз. Энэ сэдвээр ярилцах үед хүүхэд хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх эсвэл гэмт хэрэгт холбогдох үйлдэл хийх том эрсдэл зэргийг хамруулан авч үзвэл сөрөг үр дагавартай гэхээс илүү бие махбодийн шийтгэлийн эерэг нөлөөг сайшаасан яриаг (саваагаа гамнавал хүүхдээ баллана) голдуу сонсоно. Гэвч түр ба байнгын алин боловч анхаарал халамж тавьдаг асран хамгаалагч, эцэг, эхчүүдийн зүгээс эерэг болон сөрөг талыг шууд хэлж, сонгон хэрэглэж чадахгүй.

Зарим нэг нь уурлаж, догширсон байдлаар хүүхдийн биед гар хүрэхгүй байхыг зөвлөдөг. Бие махбодид нь өвдөлт амсуулж шийтгэх, эсвэл бөгсөн дээр нь алгадах нь ерөнхийдөө хүчирхийллийн замаар сэтгэлийн дарамт эсвэл уйтгар, гунигаа давж гарахыг

⁴¹ Судлаач Д.Эрдэнэбаатар., 2018 он.

⁴² Juvenile delinquency 2016 он., 94 дэхь тал.

хүүхдэд зааж, сургадаг бөгөөд ач холбогдол байдаг эсэх талаар судлаачид нилээд маргалддаг.

Австри, Кипр, Дани, Финланд, Герман, Итали, Норвеги, ялангуяа Швед зэрэг улсад бие махбодид нь өвдөлт мэдрүүлэх замаар сахилга баттай байхад сургах хууль бус аргыг хэрэглэсээр иржээ⁴³. Хэдийгээр хүүхдийн зүй бус зан чанарыг богино хугацаанд хянахад тустай ч хүүхдийн биед гар хүрч шийтгэх нь хүч хэрэглэх хандлагатай болон гэмт хэрэг, зөрчилд өртөмтгий зан араншинтай болгох зэрэг урт хугацааны туршид сөрөг үр дагаварт хүргэдэг гэсэн нотолгоог Мюррей Страус болон түүний хамтрагчид гаргаж тавьсан.

Хүүхдийг гар эсвэл өгзөг дээр алгадах зэргээр зөөлөн гар хүрэх нь гараа атгаж, нударглан цохих, эсвэл эд зүйлээр цохихоос илүү эерэг үр нөлөөтэй төдийгүй ирээдүйд гэмт хэрэг үйлдэх, хүч хэрэглэх дадал, зуршилтай болохоос урьдчилан сэргийлээд зогсохгүй зохисгүй зан авираа татахад тустай. Хүүхдийг хөнгөн зодож шийтгэхийн хажуугаар халуун дулаан харьцаа, эцэг, эхийн хайр энэрэлийг мэдрүүлэх замаар хүмүүжүүлэх нь хүүхдийг сайн хүн болгох нэг хүчин зүйлс юм.

Гэр бүл дотор хүүхдэд зааж, сургах, хянаж залруулах үйл ажиллагааг бие махбодид нь хөнгөн өвдөлт мэдрүүлж сахилгажуулах үйл явцтай хослуулах нь ач холбогдолтой мэт санагдана. Ерөнхийдөө шийтгэлийн цаана хайр, халамжаа илэрхийлэх зорилго орших нь юу л бол, тиймээс зодож, бэртээхгүй, биеийг нь өвтгөхөөс зайлсхийж хүмүүжүүлэх нь зүйтэй. Сахилга баттай байлгахыг хүсэх хүлээлт, хандлагын цаана эцэг, эхийн жинхэнэ хайр, халамж, энэрэнгүй сэтгэл орших аваас хүүхдийн зан чанар, араншин эерэг хандлагатай байх, сэтгэцийн ямар нэгэн хүндрэл үүсэхгүй нөхцлийг бүрдүүлэхэд тустай.

Өсвөр насны хүүхдүүд амьдралдаа учирсан зовлон, зүдгүүрийг давж туулах арга замыг мэдэхгүйн улмаас зүгээр л эсэргүүцэх, дайсагнах, түрэмгий байдлаар хариу барих зэргээр аашилдаг, цаашлаад ийм хандлага зан авирт нь төлөвшиж, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд эмзэглэх сэтгэлгээ нь алдагдана. Мөн хүчирхийлэл, доромжлол үргэлжилсэн, байнгын шинжтэй гэр бүлд өссөн хүүхдүүд гэр бүлийн ядуурал, сэтгэцийн өвчинд нэрвэгдэх магадлал өндөр юм. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байдал нь тэдний хүчирхийлэлд өртсөн зовлонг хаацайлах шалтаг болдог. Гэтэл тэднийг хохирогч гэхээс илүү өөрийн үйл хөдлөл, зан чанарын өмнөөс хариуцлага хүлээх ёстой хүн гэж хардаг нь нөгөө талаас өрөөсгөл ойлголт байхаар харагддаг.

Гэр бүл ба гэмт хэрэг, зөрчлийн шалтгаант холбооны өөр нэгэн хэсэг бол айл хөрш, зэргэлдээх орчны тухай ухагдахуун юм. Гэр бүл хаана оршиж, амьдарч байгаагаас шалтгаалан өсвөр насны хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл бий болно.

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх эрсдэл ихтэй нутаг, дэвсгэрт амьдарч буй хүүхэд, залуус эрсдэл багатай орчинд амьдардаг хүүхдүүдийг бодвол гэмт хэрэг, зөрчилд холбогдох магадлал өндөр байдаг. Үүний шалтгаан нь мөн л өрхийн амьжиргааны түвшин, цаашлаад орчны нөлөөлөл, гэр бүлийн гишүүдийн боловсрол, соёл, хандлага зэрэг олон хүчин зүйлээр илэрч байдаг. Цаашид айл хөрш, зэргэлдээх орчны талаарх судалгааг хийх шаардлагатай.

Дүгнэлт

Ёс суртахууны хүмүүжил, зан байдал төлөвших гол орчин нь гэр бүл юм. Хүүхэд аз жаргалтай, бат бэх, эрүүл уур амьсгалтай гэр бүлд нийгэмшсэнээр өөртөө болон орчин тойрондоо итгэлтэй, ёс суртахууны ухамсартай, шударга хүн болон хүмүүжих болно. Хэрэв гэр бүлийн уур амьсгал дээрхийн эсрэг байвал хүүхэд ч мөн эсрэг байдлаар төлөвших төдийгүй гэмт хэрэг, зөрчилд ч татагдан орох нөхцөл бүрддэг.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, холбогдсон хүүхдийн хувийн байдлыг судалж үзэхэд, дийлэнх нь урьд өмнө нь өөрөө гэмт хэргийн улмаас хохирч байсан нь ихээхэн сонирхол татаж байгаа төдийгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөвхөн нийгмийн салбарын үйл ажиллагаатай хослуулах төдийгүй гэр бүлийн гишүүдийг хамруулах хэрэгцээ байгааг харуулж байна. Түүнчлэн, өсвөр насны хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг хам сэдвийн хүрээнд судлах, энэ төрлийн гэмт хэргийн өсөлт, бууралтад гэр бүл чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гэр бүл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчлийг холбон авч үзэх чухал зүйл бол эцэг, эх ба хүүхдүүдийн харилцаа, мөн гэр бүлийн бүх гишүүдийн халуун дулаан уур амьсгал

⁴³ Страус 1994, 179-81; Саймонс 2004, 60 дахь тал.

юм. Хайр халамж дутуу, туйлбаргүй, хэт хатуу зан авиртай, үлгэр дууриалгүй, хараа хяналт тавьдаггүй эцэг, эхчүүдийг ерөнхийд нь өсвөр насны хүн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлөх хүчин зүйлс гэж үзнэ.

Эцэг, эх нь салсан гэр бүл ба өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг, зөрчилд хийсэн судалгаанаас үзэхэд, энэ төрлийн гэр бүлд өссөн хүүхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэх магадлал өндөр байгаа нь тогтоогдов.

Санал

- Гэр бүл болж байгаа залуу хосуудад хүүхдийн боловсрол, хүмүүжил, төлөвшил гэр бүлээс эхэлдэг гэдгийг ойлгуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Сум, дүүрэгт гэр бүлийг дэмжих, хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчийг хамтад нь сургалтад хамруулж, эцэг, эх, хүүхдийн хамтын харилцааны талаар сургах;
- Гэмт хэрэг үйлдсэн, үйлдэж болзошгүй хүүхэдтэй ажиллахдаа мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг ажиллуулах.

--o0o---

ХАРЬЦУУЛСАН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Г.Гантөмөр

*ДХИС-ийн Гэмт явдал судлалын профессорын судалгааны багийн
тэргүүлэх профессор, доктор (Ph.D), профессор*

Нгуен Ван Хунг

*ДХИС-ийн магистрант, БНСВУ-ын Ханой хотын
Ардын Цагдаагийн Их сургуулийн багш, ахлах дэслэгч*

Монгол Улс ба Бүгд Найрамдах Социалист Вьетнам улс /цаашид БНСВУ гэх/ 1990 оноос өмнө нийгмийн байгууллын хувьд ижил, социалист системийн орнуудад багтан, Азийн социалист улсуудаас⁴⁴ ЭЗХТН-ийн гишүүн орон болж, уг байгууллагын хүрээнд хамтран ажиллаж ирсэн найрамдалт харилцаатай орнууд билээ. Одоо ч манай хоёр улс уламжлалт харилцаагаа өнөөгийн шинэ нөхцөлд хөгжүүлэн улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт идэвхтэй хамтран ажиллаж байна.

БНСВУ нь Зүүн Өмнөд Азид Энэтхэг-Хятадын хойгт оршдог, 331.210 км.квадрат газар нутагтай, 97 сая хүн амтай, НҮБ-ын болон АСЕАН-ийн гишүүн орон билээ.

БНСВУ нь 1992 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталсан шинэ Үндсэн хуулиар төрийн хэлбэрийн хувьд Бүгд найрамдах улс, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс, улс төрийн дэглэм нь социалист улс, нэг намын тогтолцоотой, эрх зүйн тогтолцооны хувьд социалист эрх зүйн бүлд хамаардаг.

Тус улс 1990 оны сүүлээс БНХАУ-ын хөгжлийн загвараар улс төрийн тогтолцоогоо хэвээр авч үлдэн, эдийн засгаа либералчилж, нээлттэй эдийн засгийн бодлогыг явуулан гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татсанаар эрчимтэй хөгжиж, эдийн засгийн хөгжлийн өсөлтөөрөө⁴⁵ дэлхийд тэргүүлж байгаа орны нэг мөн.

а/Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхийн товчоон:

БНСВУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн түүх нь тус улсын түүх, төр, хууль цаазын хөгжил, уламжлалтай салшгүй холбоотой. Вьетнам улс нь эртний түүхтэй улс бөгөөд манай эрины өмнөх нэг мянган жилээс төр улсаа байгуулж, Эрүүгийн хууль цаазаа гарган Вьетын улсаас эхлэн Хонг Ванг, Ван-ланг, Аулак, Чьеу, Намвьет, Дин, Ли, Ле, Чан, Тайшон, Нгуен зэрэг хаант улс оршин тогтнож байсан ба нэгэн үе Монголын Их Юань болон Хятадын Мин улсын хараат улс байж XVIII зуунтай золгожээ.⁴⁶

18 дугаар зуунд тус улс Энэтхэг-Хятадын хойгийн улсуудын адил Францын колони болсон ба энэ үед Вьетнамын хаант улсуудын хууль цаазад суурилсан, Хятадын Мин улсын эрүүгийн цаазын нөлөө туссан, Францын колончлогчдын тогтоосон эрүүгийн хууль тогтоомж үйлчилж байсан байна.⁴⁷

Дэлхийн II дайны төгсгөлд 1945 оны 8 дугаар сард тус улсын умард хэсэгт Францын колончилогч эсэргүүцсэн Хо Ши Мины тэргүүлсэн Вьетнамын Коммунист намын удирдлагаар

⁴⁴ Азид БНМАУ, БНХАУ, БНАСАУ, БНСВУ гэсэн 4 социалист улс байсан. БНСВУ нь Зүүн Өмнөд Азийн анхны социалист улс орон билээ.

⁴⁵ БНСВУ-ын эдийн засгийн жилийн дундаж өсөлт нь 6.7 хувь, энэ үзүүлэлтээрээ Энэтхэг Улсын дараа орж байна. //ru.m.wikipedia.org.vietnam

⁴⁶ Колованова.И.А, Нгуен.В.Н. История формирования уголовного законодательства Вьетнама // ж.Вестник МГОУ. Серия: Юриспруденция. 2016 № 3 с.59

⁴⁷ Мөн тэнд с 59

үндэсний эрх чөлөөний хувьсгал гарч, үүний үр дүнд мөн оны 9 дүгээр сарын 2-нд Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам улс /Хойд Вьетнам/ тусгаар тогтнолоо зарласан билээ.

1950-1954 онд Францын цэргийн оролцоотойгоор Өмнөдын болон Хойд Вьетнамын хооронд болсон дайнд Өмнөд Вьетнамын тал ялагдаж, 1954 онд Женевын хэлэлцэээр байгуулагдан, дайныг зогсоож хоёр улсын цэрэггүй бүсийг байгуулсан юм. 1955 онд Америкийн талын дэмжлэгтэйгээр Өмнөд Вьетнам улс албан ёсоор байгуулагдан 1959-1973 он хүртэл удал үргэлжилсэн “Вьетнамын” гэгдэх дайны үр дүнд 1976 онд Хойд болон Өмнөд Вьетнам нэгдсэнээр БНСВУ байгуулагдсан түүхтэй.

БНСВУ байгуулагдсанаар тус улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэнд шинэ үе эхэлсэн нь Вьетнамын төрт улс байгуулагдснаас хойш анх удаа 1985 онд төрөлжүүлж нэгтгэсэн Эрүүгийн хуулийг баталж мөрдүүлсэн явдал байлаа.

Үүнээс өмнө 1945 онд Хойд Вьетнам улс байгуулагдсанаас хойш нэгдсэн БНСВУ 1976 он хүртэл тус улсын нутаг дэвсгэрт Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсын Ардын Дээд Хурал, Засгийн газраас баталсан хууль, тогтоол, дүрэм зэрэг тусгайлан гаргасан эрүүгийн эрх зүйн шинжтэй олон системчлэгдээгүй актууд үйлчилж байсан. Тухайлбал, 1945 оны 10 дугаар сард “Шинэ Эрүүгийн хууль батлах хүртэл хуучин Эрүүгийн хуулийг түр хугацаагаар хэрэглэх тухай” 47 дугаар зарлиг, 1945 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн “Цагаан будааг хууль бусаар нөөцлөх, дамлан худалаалахтай тэмцэх тухай” 7 дугаар тогтоол, 1947 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн “Капиталыг /хөрөнгө, мөнгийг/ эх орноос гадаадад гаргахыг хориглох тухай” 61 дүгээр зарлиг, 1959 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн “Эртний болон феодалын үеийн хууль цаазыг хэрэглэхгүй байх тухай” хууль, 1970 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн “Социалист өмчид халдсан үйлдэлд эрүүгийн хариуцлага /ял/ хүлээлгэх тухай” хууль зэргийг нэрлэж болно.⁴⁸

1976 онд нэгдсэн БНСВУ байгуулагдсанаас өмнөх Ардчилсан болон Өмнөд Вьетнам улсад үйлчилж байсан эрүүгийн хууль тогтоомжийг нэгдсэн тогтолцоонд оруулах, хооронд нь нийцүүлэх, эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг системчлэх ажлыг хийснээр 1985 онд анхны төрөлжүүлж нэгтгэсэн Эрүүгийн хуулийг батлах нөхцөл бүрэлдсэн. Эрүүгийн хуулийг боловруулах ажлын хэсгийн төслийг БНСВУ-ын Үндэсний ансамблей хэлэлцэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг 1983 оны 6 дугаар сарын 30-нд, тусгай ангийг 1984 оны 7 дугаар сарын 30-нд тус тусад нь батлан, 1985 оны 6 дугаар сарын 27-ны өдөр бүхэлд нь эцэслэн баталж, 1986 оны 1 дүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн.

БНСВУ 1980 оны дунд үеэс ЗХУ болон социалист орнуудад хэрэгжүүлсэн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, 1990 оны эхэн үед социалист систем задарснаас хойш бий болсон өөрийн орны нийгэм-улс төр, эдийн засгийн амьдралд гарсан нөхцөл байдлын үнэлж, Марксист-Ленинист онол, Хо-Ши-Мины үзэл санааг цаашид хөгжүүлэн, социалист нийгмийг үргэлжлүүлэн байгуулах, нэг намын тогтолцоотой улс төрийн системээ хэвээр хадгалан үлдэх явдлыг Вьетнамын Коммунист намаас нийгмийн өмнө тавигдах зорилт болгон шинээр тодорхойлон, түүний үндсэн дээр тус улсын Үндсэн хуулийг 1992 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Үндэсний Ансамблейн чуулганаар баталсан билээ.

Энэ үеэс БНСВУ нь БНХАУ-ын хөгжлийн загвар болох Дэн Ся Пины боловсруулсан Хятадын онцлогтой социалист нийгмийг байгуулах туршлагаар улс төрийн тогтолцоогоо хэвээр авч үлдэн, эдийн засгаа либериалчилж, нээлттэй эдийн засгийн бодлогыг явуулан гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогыг барьж эрчимтэй хөгжиж эхэлсэн юм.

Нийгэм, эдийн засгийн дээрх өөрчлөлт шинэчлэлтэй холбоотойгоор гэмт хэргийн бүтэц өөрчлөгдөж, гэмт хэргийн гаралт нэмэгдсэн, нээлттэй эдийн засгийн хөгжлийг даган бий болсон шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагын үүднээс тус улс төрөлжүүлж нэгтгэсэн хоёр дахь Эрүүгийн хуулийг 1999 онд шинээр баталсан.

Тус улсын Коммунист намын XII их хурлаас социалист хууль цаазат төрийг цогцлоон хөгжүүлэх, хууль тогтоомжийг XXI зуунд Вьетнамын нийгэмд гарсан нөхцөл байдалд нийцүүлэн боловсронгуй болгон шинэчлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, хууль бус бусад үйлдэлтэй тэмцэх намын улс төрийн зорилтыг тодорхойлсонтой холбоотойгоор 1999 оны Эрүүгийн хуулийг 16 жил мөрдсөний дараа төрөлжүүлсэн гурав дахь Эрүүгийн хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталж, 2016 оны 7 дугаар сарын 1-ээс дагаж

⁴⁸ Колованова.И.А, Нгуен.В.Н. История формирования уголовного законодательства Вьетнама // ж.Вестник МГОУ. Серия: Юриспруденция. 2016 № 3 с.61-62

мөрдүүлсэн нь Вьетнам улсын нийгэм, эдийн засгийн болон эрх зүйн хөгжилд шинэ хуудас нээсэн үйл явдал болов.⁴⁹

Б/Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн онцлог:

БНСВУ-ын 2015 оны Эрүүгийн хууль нь бүтцийн хувьд 3 хэсэг, 26 бүлэг, 426 зүйлээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэг буюу ерөнхий анги нь “Нийтлэг үндэслэл” гэсэн нэртэй ба 12 бүлэг, 107 зүйлээс тогтоно. Харин тусгай анги болох “Гэмт хэрэг” гэсэн хэсэг нь 15 бүлэг, 218 зүйлээс тогтох бол гуравдугаар хэсэг буюу “Төгсгөлийн заалт” гэсэн хэсэг нь 426 дугаар зүйл гэсэн нэг хэм хэмжээнээс тогтож байгаараа өмнө 1985, 1999 оны Эрүүгийн хуулиас ялгагдана.⁵⁰

Ерөнхий ангийн 1 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн зорилтыг тодорхойлохдоо “Эрүүгийн хуулийн зорилго нь Вьетнам улсын тусгаар тогтнол, социалист нийгмийн байгуулал, үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, хүний болон иргэний эрхийг, улс нийгмийн эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэгтнийг цээрлүүлэх, иргэдийг хууль ёсыг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.” гэжээ.

Эрүүгийн хариуцлагын үндэслэлийг “Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж тодорхойлсон байна. /2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг/

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Зөвхөн Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлд гэмт хэрэгт худалдааны хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан нь тус улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэнд гарсан шинэ үзэгдэл, өөрөөр хэлбэл, манай улсын дараагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон явдал билээ.

Ерөнхий ангийн “Гэмт хэрэг” гэсэн 3 дугаар бүлэгт гэмт хэрэг, түүнтэй холбоотой эрүүгийн эрх зүйн институтуудыг хуульчилсан байна.

БНСВУ нь Эрүүгийн хуульдаа гэмт хэргийн материаллаг тодорхойлолтыг хуульчилсан орны нэг юм. Тус улсын Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлд “Вьетнам улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй байдал, социалист нийгмийн байгуулал, улс төрийн болон эдийн засгийн харилцаа, батлан хамгаалах хүчин чадал, улсын аюулгүй байдал, төрийн байгууллага, хүний болон иргэний хууль ёсны эрх ашиг, сонирхолд халдсан, хэрэг хариуцах чадвартай хувь хүн, худалдааны хуулийн этгээдээс санаатай болон болгоомжгүй үйлдсэн, Эрүүгийн хуульд заасан, нийгэм аюултай үйлдлүүдийг гэмт хэрэг гэнэ.” гэж заажээ.

БНСВУ-ын Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн ангилал манай улсын 2002 оны Эрүүгийн хуулийн гэмт хэргийн ангилалтай ижил, гэмт хэргийг шинж чанар, нийгэмд аюул учруулах байдлаас хамаарч 4 ангилдаг. Тус улсын Эрүүгийн хуулийн 9 дүгээр зүйлд тодорхойлсноор тусгай ангид зааснаар торгох ял, эсхүл олон нийтийн хяналт тогтоох ял, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэргийг “хөнгөн”, 3 жилээс 7 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг “хүндэвтэр”, 7 жилээс 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг “хүнд”, 15 жилээс дээш 20 жил хүртэл хугацаагаар хорих ял, эсхүл бүх насаар нь хорих ял, эсхүл цаазаар авах ял шийтгэхээр заасан гэмт хэргийг “онц хүнд” гэмт хэрэг гэнэ.

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар бүлгийн 8-9 дүгээр зүйлд гэм буруу, түүний хэлбэрийг /гэмт хэргийг санаатай үйлдэх, гэмт хэргийг болгоомжгүй үйлдэх/, 12 дугаар зүйлд эрүүгийн хариуцлага хүлээх насны хязгаар, 13 дугаар зүйлд согтуурсан болон мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, 14-16 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэх үе шат /гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзах, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх, завдах/, 17 дугаар зүйлд гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэлбэр, төрөл/, 18-19 дүгээр зүйлд гэмт хэрэгт хамаарах /гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах/ асуудлыг хуульчилсан байна.

БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлд зааснаар 16 насанд хүрсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ба хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндах, насанд хүрээгүй

⁴⁹ Ван Кам, Нгуен Тхи Лан. Уголовное законодательство Вьетнама после третьей кодификации: некоторые новые главные особенности норм Общей части // ж.Вестник СПбГУ. Право. 2017. Т. 8. Вып. 4. С. 452

⁵⁰ БНСВУ-ын 1985, 1999 оны Эрүүгийн хууль нь ерөнхий анги, тусгай анги гэсэн хоёр хэсгээс тогтож байв./Г.Г/

хүний эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх, бэлгийн мөлжлөг, хүн худалдах, арван зургаан насанд хүрээгүй хүнийг худалдах, бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх, мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, хадгалах, завших, хууль бус уралдаан зохион байгуулах, уралдах⁵¹, хууль бусаар ашиглах зорилгоор компьютерийн программ, хэрэгслийг үйлдвэрлэх, худалдах, солилцох хандивлах, компьютерийн сүлжээ, харилцаа холбооны сүлжээ, бусдын цахим төхөөрөмжид хууль бусаар нэвтрэх, компьютерийн сүлжээ, харилцаа холбооны сүлжээ, цахим төхөөрөмжид гэмтээх, нянтай программ тараах, бусдын эд хөрөнгийг завшихаар компьютерийн сүлжээ, харилцаа холбооны сүлжээ, цахим төхөөрөмж ашиглах, террор үйлдэх, үндэсний аюулгүй байдалд хамаарах барилга байгууламж, хэрэгслийг устгах, цэргийн техник хэрэгслийг хууль бусаар үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, худалдаалах зэрэг гэмт хэрэгт 14 наснаас эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Тус улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 17 дугаар зүйлд гэмт хэргийг бүлэглэн үйлдэх, зохион байгуулалттайгаар хамтран оролцох гэсэн хамтран оролцохын 2 хэлбэрийг, гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч гэсэн гэмт хэрэгт хамтран оролцогчдын 4 төрлийг хуульчилсан байна.

Ерөнхий ангийн 4 дүгээр бүлэгт “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд”-ыг хуульчилсан ба аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хохирол учруулах, гэмт этгээдийг баривчлах үед хохирол учруулах, үндэслэл бүхий эрсдэл хийх, захирагч /командагч/ буюу даргын тушаал биелүүлэх гэсэн нөхцөл байдлыг манай улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалттай төстэй байдлаар хуульчилжээ. Энэ бүлэгт золгүй үйл явдал буюу казус /20 дугаар зүйл/, хэрэг хариуцах чадваргүй байдал /21 дүгээр зүйл/-ыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын төрөл болгон хуульчилсан нь анхаарал татна.

Ерөнхий ангийн 5 дугаар бүлэг нь “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа ба эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх” гэсэн нэртэй ба энэ бүлэгт гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг тогтоож өгснөөс гадна эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, төрлүүдийг тогтоож өгсөн. Тухайлбал, 27 дугаар зүйлд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хөнгөн гэмт хэрэгт 5 жил, хүндэвтэр хэрэгт 10 жил, хүнд гэмт хэрэгт 15 жил, онц хүнд гэмт хэрэгт 20 жил байхаар заасан нь манай улсын 2002 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг санагдуулна.

Харин хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэхгүй байх тохиолдлуудад үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 353 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг /Албан тушаалын байдлаа урвуулж, хэтрүүлж өмч хөрөнгийг завших/, 354 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг /Хээл хахууль авах/ гэмт хэрэг үйлдсэн байх хамаардаг ба манай улсын Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг хуульчлахад анхаарах, хэрэгжүүлэх сайн туршлага байж болох юм.

Тус улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6 дугаар бүлэгт ял, түүнтэй холбоотой институтууд хуульчлагджээ. Тухайлбал, 30 дугаар зүйлд ялын ойлголт, 31 дүгээр зүйлд ялын зорилго, 32 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд оногдуулах ялын төрлүүдийг, 33 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн худалдааны хуулийн этгээдэд оногдуулах ялын төрлүүдийг, 34-45 дугаар зүйлд тодорхой ялын төрлүүд, тэдгээрийн шинж, онцлог, оногдуулах хугацаа, хэмжээ зэргийг заасан.

“Гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхолд энэ хуульд заасан тохиолдолд халдаж, хязгаарлалт тогтоож байгаа төрийн албадлагын арга хэмжээг ял гэнэ.” гэж 30 дугаар зүйлд ялын ойлголтыг хуульчилсан бол, 31 дүгээр зүйлд “Ял нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдийг шийтгэж цээрлүүлэхээс гадна хууль, дүрмийг дагаж мөрдөхийг ард иргэд, хуулийн этгээдүүдэд таниулж ойлгуулах, тийм дадал, боловсрол эзэмшүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой.” гэж ялын зорилгыг нилээд онцлог байдлаар тодорхойлсон нь харагдана.

Ерөнхий ангийн 32 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд дараах үндсэн 7 төрлийн ял, нэмэгдэл 7 төрлийн ял, нийт 14 төрлийн ял оногдуулахаар хуульчилсан нь ялын төрлийн тоо, тэдгээрийг оногдуулах хугацаа хэмжээ, нөхцөл, журмын хувьд өөрийн гэсэн онцлогтой

⁵¹ Хууль бус уралдааныг зохион байгуулах, уралдах нь БНСВУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21 дүгээр бүлгийн 1 дүгээр хэсэгт заасан тээврийн эсрэг гэмт хэргийн төрөл бөгөөд авто зам дээр машин, мотоциклийн шагнал, бооцоотой хууль бус уралдааныг зохион байгуулсан бол 265 дугаар зүйлээр, ийм уралданд оролцсон уралдсан бол 266 дугаар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. /Г.Г/

болохыг харж болно. Хувь хүнд оногдуулах үндсэн ялд: 1.сануулах, 2.торгох, 3.олон нийтийн хяналт тогтоох, 4.албадан гаргах, 5.хугацаатай хорих ял, 6.бүх насаар хорих ял, 7.цаазаар авах ял хамаарна.

Сануулах ял нь 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд хуульчилсан байсан олон нийтийн өмнө буруушаах ялтай төстэй, хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн хүний ялыг хөнгөрүүлэх нөхцөл байдлууд байгаа боловч түүнийг ялаас чөлөөлөх боломжгүй тохиолдолд шүүхээс буруушаан зэмлэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байхыг сануулах хэлбэрээр хэрэгждэг үндсэн ялын төрөл юм. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 34 дүгээр зүйл/

Торгох ялыг үндсэн болон нэмэгдэл ялын шинж чанартайгаар оногдуулж болох ба хөнгөн болон хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн этгээд, эдийн засаг, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал, нийтийн хэв журмын эсрэг болон Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэрэгт үндсэн ялын шинж чанартайгаар, харин авлига, албан тушаалын гэмт хэрэг, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт нэмэгдэл ялын шинж чанартайгаар оногдуулах ба ба торгуулын хэмжээг үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, учруулсан хохирол, шүүгдэгчийн санхүүгийн байдал, үнийн хэлбэлзэл /инфляци/-ийг харгалзан оноогоор заасан ба доод хэмжээ нь 1 сая Вьетнам донгоос эхэлнэ, харин дээд хэмжээг нь зааж өгөөгүй, дээд хэмжээг шүүх тогтооно. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйл/

Олон нийтийн хяналт тогтоох ял. Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүн ажил хөдөлмөр эрхэлдэг, өөрийн гэсэн тодорхой оршин суух хаягтай, заавал нийгмээс тусгаарлаж хорих шаардлагагүй бол 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар уг ялыг оногдуулах бөгөөд уг этгээдэд түүний ажиллаж байгаа байгууллагын хамт олон болон оршин суугаа орон нутгийн төрийн байгууллага хяналт тавих ба тодорхой үүргүүдийг биелүүлэн, өөрийн олсон ажлын цалин хөлсний 5-20 хувийг улс орлогод төвлөрүүлэх үүрэг хүлээнэ. Дээрх ял нь 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд байсан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх болон хорих ялыг тэнсэж хянан харгалзах арга хэмжээний шинжийг зэрэг агуулсан онцгой төрлийн ял гэж үзэх бүрэн үндэстэй юм. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйл/

Албадан гаргах ял: БНСВУ-ын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гадаадын иргэнийг тус улсын нутаг дэвсгэрээс шүүхийн шийдвэрээр албадан гаргах явдлаар хэрэгждэг ялын төрөл ба үндсэн болон нэмэгдэл ялын аль алиных нь шинж чанартайгаар хэрэглэнэ. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйл/

Хугацаатай хорих ялын хэмжээ 3 сараас 20 жилийн хугацаатай байх ба анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, байнгын оршин суух хаягтай хүнд уг ялыг оонгдуулахгүй байх, цагдан хоригдсон нэг өдрийг хорих ялын нэг өдөртэй тэнцүүлэн шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаанд оруулан тооцох талаар БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлд хуульчилжээ. Хорих ялыг эдлүүлэх газар, түүний дэглэмийн талаарх зохицуулалт Эрүүгийн хуульд байхгүй.

Бүх насаар нь хорих ял: Хугацаагүй хорих буюу бүх насаар нь хорих ялыг гэмт хэргийн ангилалаар онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулна. Гэмт хэрэг үйлдсэн 18 насанд хүрээгүй хүнд уг ялыг оногдуулахгүй ба өөр хязгаарлалтыг зааж өгөөгүй байна. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 39 дүгээр зүйл/

Цаазаар авах ялыг Вьетнам Улсын үндэсний аюулгүй байдал, хүнийг санаатай алах, авлига, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг болон Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэрэгт оногдуулна. Гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй хүн, жирэмсэн болон 3 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй, 75-аас дээш настай хүнд цаазаар авах ял оногдуулж болохгүй. Мөн өмч хөрөнгийг их хэмжээтэй шамшигдуулсан болон авлигын гэмт хэрэгт цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд шамшигдуулсан болон авсан хахууль, авлигынхаа 3/4-аас доошгүйг сайн дураар төрд буцааж өгсөн, гэмт хэргийг илрүүлэх болон мөрдөн шалгах байгууллага, шүүхтэй сайн дураар идэвхтэй хамтран ажилласан бол цаазаар авах ялыг бүх насаар хорих ялаар сольж болох зохицуулалт байдаг. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл/

Нэмэгдэл ял: БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлд зааснаар нэмэгдэл ялд дараах ялууд хамаарна. Үүнд: тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, оршин суух эрхийг хасах, зорчих эрхийг хасах, иргэний тодорхой эрхийг хасах, эд хөрөнгө хураах ял, торгох ял /үндсэн ял болгож оногдуулаагүй тохиолдолд нэмэлт ял болгон оногдуулж болно/, албадан гаргах /үндсэн ял болгож оногдуулаагүй тохиолдолд нэмэлт ял болгон оногдуулж болно/.

Тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагааг явуулах эрхийг хасах ял. Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн хашиж буй албан тушаалын байдал, эрх мэдэл болон явуулж байгаа тодорхой үйл ажиллагаагаа хууль бусаар урвуулан ашиглаж гэмт хэрэг үйлдсэн ба түүнийг үргэлжлүүлэх хашин эрхлэх нь Вьетнам Улсын эрх ашиг сонирхолд харшилж байгаа тохиолдолд 1-5 жилийн хугацаагаар оногдуулна. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйл/

Оршин суух эрхийг хязгаарлах ял: Энэхүү ялын төрөл нь 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд хуульчилсан байсан уг нутгаас зайлуулах ялыг санагдуулна. Гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүнийг шүүхээс тодорхой нутаг дэвсгэрт түр хугацаагаар эсвэл бүрмөсөн оршин суухыг хориглох явдлаар цээрлэл нь илэрдэг нэмэгдэл ялын төрөл бөгөөд хугацаа нь хорих газраас суллагдсанаас хойш тоологдох ба 1-5 жил байна. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйл/

Зорчих эрхийг хязгаарлах ял: Хорих ял шийтгүүлсэн хүнд нэмэгдэл ял болгон оногдуулах ба түүнийг суллагдсны дараа шүүхээс заасан тодорхой нутаг дэвсгэрт 1-5 жилийн хугацаанд орон нутгийн захиргааны хяналтын дор амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, уг нутаг дэвсгэрээс гарч явахгүй байх явдлаар уг ялын цээрлэл илрэх ба 1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд байсан нутаг зааж суулгах ялтай төстэй. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйл/

Иргэний зарим эрхийг хасах ял: Вьетнам Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн болон Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял оногдуулахын зэрэгцээ сонгуульд нэр дэвших, төрийн албанд ажиллах, сонгогдох албан тушаалд нэр дэвшүүлэх, зэвсэгт хүчинд алба хаах зэрэг эрхийг 1-5 жилийн хугацаагаар хасдаг нэмэгдэл ялын төрөл юм. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйл/

Эд хөрөнгө хураах ял: Шүүгдэгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгийн заримыг эсхүл бүгдийг шүүхийн тогтоолоор албадан гаргуулж улсын орлогод шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ. Энэ ялыг Вьетнам Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг хүнд, онц хүнд гэмт хэрэг, мансууруулах бодитой холбоотой хүнд, онц хүнд гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэрэг оногдуулна. Эд хөрөнгө хураах ялыг хэрэглэхдээ ялтны гэр бүлийн гишүүдийн амьдрах нөхцлийг алдагдуулж болохгүй. /БНСВУ-ын Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйл/

Худалдааны хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага, оногдуулах ялын төрөл хэмжээг тус улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 11 дүгээр бүлэгт хуульчилжээ⁵².

Хуулийн этгээдэд дор дурдсан ялуудыг үндсэн болон нэмэгдэл ялыг оногдуулна. Үндсэн ялд торгох, үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, татан буулгах, нэмэгдэл ялд тодорхой үйл ажиллагааны чиглэлийг хориглох, хөрөнгө оруулахыг /босгохыг/ хориглох, торгох /нэмэгдэл ял болгон оногдуулахаар тусгай ангид заасан тохиолдолд оногдуулж болно/ хамаарна.

БНСВУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн VII бүлгийн 46 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд хэрэглэх 3 төрөл /гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, эд зүйлийг хураах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм хорыг арилгах, олон нийтийн өмнө уучлал гуйх, эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээ/, гэмт хэрэг үйлдсэн худалдааны хуулийн этгээдэд хэрэглэх 4 төрөл /гэмт хэрэг үйлдэж олсон ашиг орлогыг хураах, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх, гэм хорыг арилгах, олон нийтийн өмнө уучлал гуйх, төлбар төлөх, гэмт хэрэг дахин гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах/-ийн шүүхийн албадлагын буюу эрүүгийн хариуцлагын албадлагын арга хэмжээний төрлийг хуульчилсан.

Мөн ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт ял оногдуулах, тухайлбал, ял оногдуулах нийтлэг үндэслэл, ялыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлууд, давтан ба рецидив гэмт хэрэг үйлдэх /53 дугаар зүйл/, хуульд зааснаас хөнгөн ял оногдуулах /54 дүгээр зүйл/, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах /55 дугаар зүйл/, хэд хэдэн шүүхийн шийтгэх тогтоолоор ял оногдуулах /56 дугаар зүйл/, гэмт хэргийн үе шатуудад ял оногдуулах /57 дугаар зүйл/ болон гэмт хэрэгт хамтран оролцогчдод ял оногдуулах /58 дугаар зүйл/ асуудлыг хуульчилжээ.

Эдгээрээс тус улсын Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд ялыг хөнгөрүүлэх 22, 52 дугаар зүйлд ялыг хүндрүүлэх 15 нөхцөл байдлуудыг тун тодорхой байдлаар нарийвчлан хуульчилж

⁵² Эрдэм шинжилгээний өгүүллийн хэмжээнд тавигдах хэмжжнээс шалтгаалан БНСВУ-ын Эрүүгийн хуулиар худалдааны хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын онцлог, оногдуулах ялын төрөл, хэмжээг дараагийн удаа тусдаа бие даасан өгүүллийн хэмжээнд авч үзэх болно. /Г.Г/

өгсөн нь сайшаалтай, манай улсын Эрүүгийн хуульд авч хэрэгжүүлж болохоор сайн туршлага байна гэж бид үзлээ.

“Ялаас чөлөөлөх” гэсэн ерөнхий ангийн 9 дүгээр бүлэгт шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа /60 дугаар зүйл/, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа хэрэглэж болохгүй гэмт хэргүүд⁵³ /61 дүгээр зүйл/, өршөөл, уучлал үзүүлж ялаас чөлөөлөх, өвчний учир ялаас чөлөөлөх, /62 дугаар зүйл/, эдэлж байгаа ялыг хөнгөрүүлэх, хугацааг багасгах /63, 64 дүгээр зүйл/, ялсныг хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллах /65 дугаар зүйл/, ял хойшлуулах /67 дугаар зүйл/ үндэслэл, журмыг хуульчилжээ.

Ерөнхий ангийн 10 дугаар бүлэгт ялтай байдлын асуудалд зориулагдсан ба ялтай байдлын ойлголт /69 дүгээр зүйл/, ялтай байдал арилах /70 дугаар зүйл/, ялгүй болох /71 дүгээр зүйл/, ялгүйд тооцох /71 дүгээр зүйл/, ялгүй болох хугацааг тоолох журам /72 дугаар зүйл/ нь манай улсын 2002 оны Эрүүгийн хуульд байсан зохицуулалттай үндсэндээ ижил юм.

Насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага. БНСВУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий анги нь насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын тухай асуудлыг хуульчилсан 12 дугаар бүлгээр төгсөж байна.

Насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх хэм хэмжээг 1999 оны БНСВУ-ын Эрүүгийн хуульд анх удаа тусгайлан бүлэг болгон хуульчилсан⁵⁴ ба 2015 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн өөрчлөлт оржээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 91 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүнд оногдуулах ялын зорилгыг “18 насанд хүрээгүй хүний эрх ашгийг хамгаалах, хууль бус үйлдэлдээ гэмших, зан үйлээ засч залруулах, өндөр хүмүүжил, ёс суртахуунтай иргэн болж төлөвшихөд нь туслах явдал” гэж тодорхойлсноос гадна, тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь насанд хүрээгүй хүний бие махбодь, сэтгэл зүй, нас, хүйсийн онцлогт тохирсон байх ёстойг дурджээ.

Мөн 91 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүнд цаазаар авах ял оногдуулахгүй байх, мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдээс /хүнийг санаатай алах, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах, хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндах, насанд хүрээгүй хүний эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдах, арван зургаан насанд хүрээгүй хүнийг худалдах, бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, бусдын эд хөрөнгийг санаатай устгаж гэмтээх, мансууруулах бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, худалдах, хадгалах, завших/ бусад гэмт хэрэг үйлдсэн бөгөөд хохирлоо нөхөн төлсөн, үйлдсэн хэрэгтээ гэмшсэн бол эрүүгийн хариулагаас чөлөөлөх талаар заасан байдаг. Ерөнхий ангийн 93 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн насанд хүрээгүй хүнд үүрэг хүлээлгэх /хохирогчтой эвлэрэх, хохирлоо нөхөн төлөх, уучлал гуйх, суралцаж боловсролоо дээшлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх/ 96 дугаар зүйлд сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагад байлгах арга хэмжээ хэрэглэх талаар хуульчилсан.

Тус бүлгийн 98 дугаар зүйлд насанд хүрээгүй хүнд оногдуулах 4 төрлийн ялыг тусгайлан заасан. Үүнд: сануулах, торгох, олон нийтийн хяналт тогтоох, хорих ял хамаарна.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүн ажил хөдөлмөр эрхэлдэг, өөрийн гэсэн орлоготой бол торгох ял оногдуулж болох ба торгуулийн хэмжээ нь насанд хүрсэн хүнд оногдуулах торгох ялын талаас хэтрэхгүй байх /99 дүгээр зүйл/, мөн цаазаар авах болон бүх насаар хорих ял оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг 16-18 насны этгээд үйлдсэн бол тэдэнд оногдуулах хорих ял 18 жилээс дээш, хэрэв 14-16 насны хүүхэд үйлдсэн бол хорих ялын хэмжээ 12 жилээс дээш, хугацаатай хорих ялын хэмжээ 10 жилээс дээш байж болохгүй /101 дүгээр зүйл/ зэрэг онцлогтой байна.

в/БНСВУ-ын Эрүүгийн хуулийн тусгай анги:

БНСВУ-ын Эрүүгийн хуулийн тусгай анги нь 14 бүлэг, 218 зүйлээс бүрдэнэ. Нэг удаагийн өгүүллийн хүрээнд тус улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ба тусгай ангийн бүхэлд нь авч үзэх боломжгүй тул тусгай ангийн бүлгүүдийг нэрлэх байдлаар өгүүллээ өндөрлөх зүйтэй гэж үзлээ. Тус улсын Эрүүгийн хуулийн тусгай анги нь:

⁵³ БНСВУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар бүлэгт заасан “Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, 26-р бүлэгт заасан “Энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон дайны гэмт хэрэг”-т шүүхийн гийтгэх тогтоолыг биелүүлэх хугацаа өнгөрнө гэсэн ойлголт байхгүй, шүүхийн шийтгэх тогтоол гарсан бол хэзээ ч уг тогтоолыг биелүүлж болохоор заасан байна. /Г.Г/

⁵⁴ Чан Тхи Ту Ань. Виды наказаний, назначаемые несовершеннолетним, по уголовному законодательству СРВ //ж.Вопросы современной юриспруденции. № 1 2015 г. стр 207

13 дугаар бүлэг. Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг /108-122 дугаар зүйл/
 14 дүгээр бүлэг. Хүний амь нас, эрүүл мэнд, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг⁵⁵ /123-156 дугаар зүйл/
 15 дугаар бүлэг. Хүний болон иргэний эрхийн эсрэг гэмт хэрэг /157-167 дугаар зүйл/
 16 дугаар бүлэг. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /168-180 дугаар зүйл/
 17 дугаар зүйл. Гэр бүлийн эсрэг гэмт хэрэг /181-187 дугаар зүйл/
 18 дугаар зүйл. Эдийн засгийн гэмт хэрэг /188-234 дүгээр зүйл/
 19 дүгээр зүйл. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг /235-246 дугаар зүйл/
 20 дугаар зүйл. Мансууруулах бодистой холбоотой гэмт хэргүүд /247-259 дүгээр зүйл/
 21 дүгээр зүйл. Олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг⁵⁶ /260-329 дүгээр зүйл/
 22 дугаар бүлэг. Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг /330-351 дүгээр зүйл/
 23 дугаар бүлэг. Албан тушаал, авлигын гэмт хэрэг /352-366 дугаар зүйл/
 24 дүгээр бүлэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг /367-391 дүгээр зүйл/
 25 дугаар зүйл. Цэргийн гэмт хэрэг /392-420 дугаар зүйл/
 26 дугаар бүлэг. Энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг, дайны гэмт хэрэг /421-425 дугаар зүйл/ гэсэн бүлгээс тогтоно.

Эцэст нь дүгнэхэд, шинэ үеийн БНСВУ-ын эрүүгийн эрх зүй нь хоёр Вьетнам улс нэгдснээс хойш эрчимтэй хөгжиж, гурав дахь төрөлжсөн Эрүүгийн хуулийг 2015 онд баталж, хэрэгжүүлж байна.

Тус улс нь нийгмийн байгууллын хувьд социалист улс учраас эрүүгийн эрх зүй нь социалист эрх зүйн бүлийн орнуудын эрүүгийн эрх зүйн нийтлэг шинжийг агуулахын зэрэгцээ БНХАУ, БНАСАУ-ын эрүүгийн эрх зүйгээс ялгагдах өөрийн гэсэн онцлогтой байна. Түүнчлэн, манай хоёр улсын эрүүгийн эрх зүй нь нэг уг гарвалтай, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн болон эрүүгийн хууль тогтоомжийн боловсруулалтын түвшин ойролцоо, эрх зүйн зохицуулалтын хувьд төсөөтэй зохицуулалт цөөнгүй байгаа хэдий ч нийгмийн байгуулал, улс төрийн тогтолцоо, нийгмийн хөгжлийн чиг баримжаа, үнэт зүйл өөр, тусдаа эрх бүлд хамаардаг учраас ялгагдах онцлогтой байна.

Гэхдээ манай хоёр улс эрүүгийн эрх зүйн зохицуулалтын хувьд бие биенээсээ харилцан суралцах, сайн туршлагаа хуваалцах замаар эрүүгийн хууль тогтоомжоо цаашид улам төгөлдөржүүлэх, боловсронгуй болгох шаардлага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

--oOo--

⁵⁵ Энэ бүлэгт хүний хувийн халдашгүй байдалд халсан гэмт хэргүүд, амь бие эрүүл мэндийг аюултай байдалд хүргэх, орхих гэмт хэргүүд, хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд хуульчилгдсан байдаг онцлогтой. /Г.Г/

⁵⁶ Энэ бүлэгт тээврийн гэмт хэрэг, мэдээлэлийн технологи, телевизийн холбооны сүлжээн дэх гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг багтсан байна. /Г.Г/

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН БУС ХОХИРЛОО НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХИЙГ ХАНГАХ АСУУДАЛ

Б.Батхуяа

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн
эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч

Товч агуулга. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Оролцогч улсууд эрүүдэн шүүх бүх үйлдлийг Эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзнэ” гэж заасан. Монгол Улс олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсноор Эрүүгийн хуульдаа эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хуульчилсан. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг гэж төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон үйлдлийг нэг удаа болон янз бүрийн давтамжтайгаар удаан хугацаанд санаатай хийгдэж байгаа үйлдлийг хэлдэг.

Энэ гэмт хэргийн хохирогчид эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол учирдаг. Эд хөрөнгийн бус хохиролд учирсан тохиолдолд түүнийг хэрхэн тогтоох талаар тусгайлан зохицуулсан хууль, журам, аргачлал байхгүйн улмаас тус гэмт хэргийн хохирогчид хохирсон хэвээр үлдэж байна. Иймд эрүү шүүлтэд өртсөн хохирогчдын эд хөрөнгийн бус хохирлыг хэрхэн барагдуулах, эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлж буй практик, эрх зүйн зохицуулалтын талаар судалж, санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Хууль тогтоомж, сэтгэл санаа, бие махбод, аргачлал, шүүх, шинжээч, нотлох баримт.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй”,⁵⁷ Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно”⁵⁸ гэж тус тус заасан.

Доктор (Sc.D), профессор С.Жанцан “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг гэдэг нь мэдээ сэлт, мэдүүлэг авах зорилгоор уг эх сурвалжийг мэдэх буюу гаргуулан авах этгэдийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг нэг удаа болон янз бүрийн давтамжтайгаар удаан хугацаанд санаатай хийгдэж байгаа үйлдлийг хэлнэ”⁵⁹ гэсэн бол доктор (Ph.D), профессор Н.Баатаржав “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг гэдэг нь хүч хэрэглэж эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх, тулган шаардах зэрэг янз бүрийн хууль бус арга хэрэглэж, тодорхой мэдүүлэг өгөхийг албадахыг хэлнэ”⁶⁰ гэж тодорхойлжээ. Бидний үзэж байгаагаар, эрүү шүүлт тулгах гэмт хэрэг нь төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж, бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон үйлдлийг нэг удаа болон янз бүрийн давтамжтайгаар удаан хугацаанд санаатай хийгдэж байгаа үйлдлийг ойлгоно.

⁵⁷ Монгол Улсын Үндсэн хууль. УБ.1992

⁵⁸ Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал.1946

⁵⁹ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий ба тусгай анги /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал. УБ., 2011. 616 дахь тал

⁶⁰ Н.Баатаржав нар. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ., 2012. 276 дахь тал

Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг нь тодорхой зорилго, сэдэлтэйгээр тодорхой хугацаанд, бусдыг ялгаварлан гадуурхах үндэслэл бүхий төлөвсөн үйлдэл, эс үйлдэхүйн бодит илрэл болж өгдөг. Мөн энэ төрлийн гэмт хэргийг өөрөө эсхүл бусад этгээдийг хатгах, зөвшөөрөл олгох, бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаар илэрхийлэх аргаар үйлддэг. Үүнээс үзвэл, эрүү шүүлтэд өртсөн хохирогчид бие махбод, сэтгэл санааны хувьд хохирдог учраас хохирсон хүний эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх нь чухал юм.

Сүүлийн 2 жилийн байдлаар прокурорын байгууллагад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй 2018 онд 56, 2019 онд 68 гомдол, мэдээлэл ирсэн бөгөөд 2018 онд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 5, татгалзсан 51 байсан бол 2019 оны байдлаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 22, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 46 гэмт хэрэг бүртгэгдсэн.⁶¹ Үүнээс үзвэл, энэхүү гэмт хэргийн гомдол, мэдээллийн тоо жил ихсэж байгаа нь харагдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдын эд хөрөнгийн бус хохирлыг хэрхэн барагдуулах вэ? гэсэн асуудал үүнээс үүдэн бий болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй"⁶² Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалын 2.27-д "Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй"⁶³ гэж иргэний сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан.

Монгол Улсад эрүү шүүлтийн улмаас учирсан эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх талаар эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн хэдий ч түүнийг хэрхэн тооцох тусгайлсан аргачлал байхгүй байна. Хэдийгээр тусгайлсан аргачлал байхгүй ч эрүү шүүлт тулгах нь гэмт хэрэг тул гэмт хэргийн улмаас учирсан хохирол гэдэг утгаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар тогтоох, шийдвэрлэх, боломжтой. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д "Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй" гэж заасан.⁶⁴ Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд "Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон **эд хөрөнгийн бус хохирол** хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хэлнэ" гэж заасан.⁶⁵

Эд хөрөнгийн бус хохирол нь (материаллаг бус) хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зэрэг эд хөрөнгийн шинжгүй мөнгөөр илэрхийлдэггүй сэтгэл санааны үр дагаврыг ойлгоно.⁶⁶

Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эд хөрөнгийн бус хохиролд хамаарна. Энэ хохиролын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаар арга, аргачлал дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсон хэвээр үлддэг.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн, эд зүйлийн үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлд "Хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй"⁶⁷ гэж заасан байдаг. Гэтэл

⁶¹ Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/793 дугаар албан бичиг

⁶² Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

⁶³ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ.

⁶⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017

⁶⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017

⁶⁶ Х.Доржпалам. Иргэний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2012. 117 дахь тал

⁶⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017

хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад учирсан эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлөх шүүхийн шийдвэр давамгайлж байна. Энэ нь эд хөрөнгийн бус хохирол учирсныг тогтоох төдийлөн шаардлагагүй, гэм буруутай этгээд нь эд хөрөнгийн бус хохирол учруулснаа хүлээн зөвшөөрдөг зэргээс шалтгаалан шийдвэрлэхэд хялбар байдаг байж болох юм. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн бус хохирлыг ямар нэг бичмэл нотлох баримтад бус өнгөрсөнд болж өнгөрсөн зүйлсийг /хууль бусаар хоригдсон, эрүүдэн шүүсэн, хилсээр, ял шийтгэгдсэн/ үндэслэн нөхөн төлүүлж буй практик илүү байдаг.

Шүүхийн шийдвэрээс үзэхэд, нэхэмжлэгчид эд хөрөнгийн бус хохирлын хэмжээгээ өөрсдөө тодорхойлж байна. Энэ нь эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг тодорхойлох арга, аргачлал байхгүйтэй холбоотой. Хоёрдугаарт, эд хөрөнгийн бус хохирлыг тогтоосон бус эд хөрөнгийн бус хохирол учирсан үйл баримтад үндэслэн шийдвэрээ гаргадаг. Тиймээс иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг дан ганц шүүгч, шүүх бүрэлдэхүүний дотоод итгэлээр тогтоож байгаа нь бодит байдалд нийцэхгүй байх талтай.

Монгол Улсын хувьд эдийн хөрөнгийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлдөг. Түүнийг хэрхэн хангадаг талаар авч үзвэл :

Нэр	Хангасан	Хангахаас татгалзсан
Эрүүл мэндэд учирсан хохирол	78'865'730	30'803'137
Нэр төр, алдар хүндэд учирсан хохирол	9'150'000	14'189'000
Сэтгэл санаанд учирсан хохирол	196'022'519	40'492'548 ⁶⁸

Гадаадын зарим улсад:

Англи Улсын хувьд хожим шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хилс ял эдэлсэн болон эд хөрөнгийн бус хохирол учирсан буюу сэтгэл санааны гэм хор болон тухайн хүний нэр төр, алдар хүндийг нь гутаасан бол хохирсон этгээдэд нөхөн төлбөр олгодог. Англи Улсын хуульд зааснаар Төрийн нарийн бичгийн дарга нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийддэг боловч үнэлгээг түүний томилсон бие даасан шинжээч тогтоож,⁶⁹ шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан зардлыг төлүүлэхээр хуульчилсан байна.

Үүнээс авч үзвэл, Англи Улс нь хохирол учруулсан этгээдэд хохирлыг нөхөн төлүүлэх үүргийг хүлээлгэдэгээрээ манай улстай ижил боловч эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд тус улсад шинжээч томилж ажиллуулдаг байна. Манай улсын хувьд шүүгч өөрийн дотоод үнэлэмжээр хохирлыг төлүлдэг нь учир дутагдалтай. Иймд Англи Улстай адил шинжээч томилж, шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрээ гаргавал илүү хуульд нийцнэ гэж үзэж байна.

Дүгнэлт

Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэрхэн тооцож, барагдуулах талаар арга, аргачлал дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсон хэвээр үлдэж байна.

Манай Улсад эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудал Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдсан хэдий ч эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх асуудал хангалтгүй.

Улсын хэмжээнд эд хөрөнгийн бус хохирлыг тодорхойлох зохицуулалт боловсронгуй бус, аргачлал байхгүй, ялангуяа, гэмтлийн зэрэг тогтоох, нөхөн сэргээх, нөхөн төлүүлэх журам байхгүй байна. Практикт эд хөрөнгийн бус хохирлыг мөнгөөр үнэлж, сэтгэл санааг хэмжиж болохгүй хийсвэр зүйл мэтээр төсөөлдөг буруу хандлага байна. Иймд эд хөрөнгийн бус хохирол гэж юу болохыг анагаахын шинжлэх ухааны талаас нь тогтоолгож, гэмт хэргийн улмаас үүссэн сэтгэл зүйн гэмтлийн зэрэг тогтоодог нэгдсэн заавар, журамтай болох, эргээд

⁶⁸ <http://mn-nhrc.org/index.php?do=cat&category=32>

⁶⁹ Stephanie Roberts. "Unsafe "Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice. London. 2003., at 2

эмчлэх нөхөн сэргээхэд гарах зардлын хэмжээг эмнэлгийн байгууллагын эмчилгээ, үйлчилгээний зардалтай уялдуулж цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Санал

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчид учирсан эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг дан ганц шүүгч, шүүх бүрэлдэхүүний дотоод итгэлээр бус мэргэжлийн шинжээч /эдийн засгийн үнэлгээчин, сэтгэл судлаач, эмч нар/-ийн дүгнэлтийг үндэслэн тогтоодог байх шаардлагатай байна. Ингэхдээ дор дурдсан шалгуур үзүүлэлтийг харгалзан эд хөрөнгийн бус хохирлыг тогтоох нь зүйтэй. Үүнд:

- Гэмт хэрэгт шалгагдсан хугацаа;
- Баривчлагдсан, цагдан хоригдсон хугацаа;
- Хэрэгт шалгагдах хугацаанд эрүү шүүлтэд өртсөн эсэх;
- Хилсээр ял эдэлсэн эсэх, ялыг ямар дэглэмд эдэлсэн эсэх зэрэг хүчин зүйл байж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэж заасны дараа “Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тогтооно” гэж нэмж хуульчлах.

Олон улсын өвчний 10 дугаар ангиллыг баримтлан эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг тогтоох аргачлалыг бий болгох талаар Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран хууль зүй, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэснийг үндэслэн хохирогчийн эд хөрөнгийн бус хохирлыг тогтоох талаар аргачлал боловсруулж, батлуулах. Эд хөрөнгийн бус хохирлыг тогтоох аргачлалд дараах зүйлсийг тусгах. Үүнд: Гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ, хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодын болоод сэтгэл санааны зовлон, зовиур, шаналлын шинж чанар, шударга ёсны шаардлага зэрэг болно.

Эрүү шүүлтэд өртсөн хохирогчийн эд хөрөнгийн бус хохирлыг дан ганц мөнгөөр нөхөн төлүүлэх биш, эмнэлгийн байгууллагад хэвтүүлэх, сэтгэл заслын арга хэмжээ авах, эмчлэх нөхөн сэргээхэд гарах зардлын хэмжээг эмнэлгийн байгууллагын эмчилгээ, үйлчилгээний зардалтай уялдуулан цогц байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Монгол Улсын Иргэний хууль. 2002
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017
- Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал. 1946

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

- Ц.Батчимэг, Б.Энхбаяр, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй. УБ., 2005
- Н.Баатаржав нар. Монгол Улсын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ., 2010
- С.Гантулга, Б.Энхболд. Монгол Улсын эрүүгийн эрх зүй: тусгай анги /нэмж засварласан 2 дахь хэвлэл/. УБ., 2020
- Х.Доржпалам. Иргэний эрх зүйн зохицуулалтын асуудал. УБ., 2012
- С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий ба тусгай анги /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ., 2011
- П.Оюунчимэг. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг ба хүний эрх. УБ., 2009
- Ё.Кают, Шленгпер, Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар толь. УБ., 2010
- Stephanie Roberts, Unsafe, Convictions, Defining and Compensating Miscarriages of Justice, Лондон. 2003

Гурав. Бусад эх сурвалж

- <http://mn-nhrc.org/index.php?do=cat&category=32>
- <http://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/01/08/go8kd8smlvmred5n/>

ГАЗАР, ОРОН БАЙРАНД ҮЗЛЭГ ХИЙХ АЖИЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛД

Т.Мөнхбадрах

Орхон их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, магистр

Товч агуулга. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон зарчмын шинжтэй өөрчлөлтөөр шүүх хуралдааны явцад талуудын хүсэлтийг үндэслэн шүүх нь хэрэг гарсан газар, орон байранд үзлэг хийх, нэмэлт шинжилгээ хийлгэх зэргээр тодорхой ажиллагаа явуулах эрхтэй болсон. Энэхүү өгүүлэлд шүүх хэрэг гарсан газар, орон байранд үзлэг хийх ажиллагааны болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтын талаар судалсан болно.

Түлхүүр үг. Шүүх, үзлэг, газар, орон байр, хэргийн газрын үзлэг.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13-т “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”⁷⁰ гэж заасан.

НҮБ-аас 1948 онд баталсан Хүний Эрхийн Түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд дур мэдэн оролцох, иргэний орон байр, хувийн харилцааны нууц, нэр төрд нь дураар халдах ёсгүй. Хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”⁷¹ гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Орон байр халдашгүй байна”. Мөн хуулийн 23.1 дүгээр зүйлд “Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ” гэж тус тус заасан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.22 дугаар зүйлд “Газар, орон байранд үзлэг хийх” талаар хуульчилсан. Тухайлбал,

1. Хэргийн бодит байдлыг өөрөөр тогтоож шинжлэн судлах боломжгүй бол шүүх талуудын хүсэлтээр хэрэг гарсан газар, орон байранд талууд, гэрч, шинжээч, оролцогчийг байлцуулан үзлэг хийж болно.
2. Үзлэг хийх газар ирмэгц шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан үргэлжилж байгааг зарлах ба талууд үзлэгт оролцож байгаа шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээч, мэргэжилтэнд үзлэг хийхтэй холбогдсон асуулт тавьж болно.
3. Үзлэгт оролцогч хэргийн байдлыг тодруулахад ач холбогдолтой гэж үзсэн бүх зүйлийг шүүхэд хандан тайлбарлаж болно.
4. Үзлэг хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.⁷²

Шүүхийн хэлэлцүүлэг нь яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдана.⁷³

Акедемич С.Нарангэрэл “Мэтгэлцээн /англи-adversarial process, орос-состоятельность/ эрүүгийн шүүн таслах ажиллагааны ардчилсан зарчим⁷⁴ ба талуудын маргааны хэлбэрээр явагдана. Бүх оролцогчид тэгш эрхтэй, шүүх үндэслэлтэй шийдвэр гаргахын тулд үнэнийг тогтоох, хэргийн нөхцөл байдлыг бүх талаас нь бүрэн бодиттой шинжих хуульд заасан бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.1.1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй”⁷⁵ гэж заажээ.

Үндсэн асуудал

⁷⁰ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. Төрийн мэдээлэл.№1

⁷¹ Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал.1948

⁷² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017

⁷³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. ДХИС. 2020. 196 дахь тал

⁷⁴ С.Нарангэрэл. “Эрх зүйн толь бичиг”. УБ., 2006. 352 дахь тал

⁷⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017

“Газар, орон байр” гэдэг нэр томьёонд анхаарал хандуулах шаардлагатай.

1. Аливаа нэг тодорхой газар, орон зай, дэлхийн гадаргууны хэсэг, уулархаг талархаг газар, ил задгай газар;
2. Аймаг, нийслэл, баг, хороо, дүүрэг, хөдөө орон нутаг, зуслангийн газар

Үүнээс үзвэл, газрын гадаргуу дээрх ил хэсгийн талаар яригдаж байна. Монгол хэлний тайлбар тольд “Орон байр” гэдэг нь хүний оршин амьдрах, суух газар, оромж, байр байшин, гэр, суурин, сууц⁷⁶ гэж тайлбарлажээ.

Үзлэг нь болж өнгөрсөн гэмт үйл явдлыг ойлгож мэдэх, гэмт хэрэгтэй холбоотой материалаг зүйлийг илрүүлж, бэхжүүлэх зорилгоор хийгдэж буй танин мэдэхүйн шинж чанар бүхий эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны нэг хэлбэр юм.⁷⁷

Шүүх нь мөрдөн байцаалтын шатанд үзлэг хийгдээгүй байна гэж үзсэн, эсвэл урьд нь хэрэгжүүлсэн үзлэгийн бүрэн гүйцэт хийгдээгүй, үзлэгийн тэмдэглэлд бүрэн гүйцэд тэмдэглэгдээгүй, эрүүгийн процессын оролцогчид хэргийн нөхцөл байдал, баримт нотолгоонд янз бүрийн тайлбар өгсөн тохиолдолд хэрэг гарсан газар, орон байранд үзлэг хийж болно.

Орон байранд үзлэг хийх ажилагааны эрх зүйн зохицуулалт

Шүүх газар, орон байранд үзлэг хийх ажилагааны эрх зүйн зохицуулалтын асуудлыг тодруулахдаа дараах 3 асуултад хариулт өгөх шаардлагатай. Үүнд:

- Ямар зорилгоор газар орон, орон байрны үзлэг хийх вэ?
- Шүүх орон байрны үзлэгийг хэрэгжүүлж болох үеийг тодорхойлох уу?
- Шүүх газар, орон байранд үзлэг хийх эрхтэй юу?

Орон байр, гэр, албан газар хийх үзлэг нь хэргийн газрын үзлэг хамаарч болохын зэрэгцээ гэмт этгээдийн амьдралын хэв маягийг тодорхойлох гэмт үйл ажиллагаандаа хэрэглэсэн багаж зэвсэг, хэрэг үйлдэх үедээ өмсөж явсан хувцас, гэмт үйлдийн замаар олсон зүйлийг илрүүлэх зорилгоор хийгддэг.⁷⁸

“Орон байр” гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.⁷⁹ “Бусад газар” гэж хүн, хуулийн этгээдийн орон байрнаас бусад өмчлөл, эзэмшлийн байр, байгууламж, бусад объектыг⁸⁰ ойлгоно.

Улсын Дээд Шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолын 1.9-д “Орон байр” гэдэгт хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц байшин, гэр урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй түр шинжтэй байж болно” гэж заажээ. Гэхдээ эрүүгийн процессын эрх зүй дэх орон байр тухайн иргэний өмч мөн эсэх нь ач холбогдолгүй бөгөөд гагцхүү хууль ёсоор түр болон удаан хугацаагаар эзэмшиж байх нь халдашгүй байдлын хамгаалалтад багтах үндэслэл болно.⁸¹

Гэмт хэрэг гарсан байдал, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэг гарсан газар болон эд зүйл, баримт бичигт үзлэг хийх нь орон байрны дотор болон гадна байж болно. Орон байр гэдэгт төвлөрсөн суурин газарт тодорхой хорооллын нийтийн орон сууцны өрөө болон хувийн орон сууц, тухайн өрх гэрийн граж, агуулах ногооны талбай, гэр хорооллын байшин буюу гэр амбаар, нохойн оромж, бие засах газар, харин хөдөө орон нутагт тухайн айлын байшин, өвөлжөө, малын хашаа, саравч хороо зэргийг хамааруулан авч үзнэ. Дашрамд дурдахад орон байр гэдэгт ямагт орон сууц гэдэг ойлголт багтаж байдаг бөгөөд үүнд гэр байшин, урц овоохой, пүнз, асар, майхан, тэрэгт сууц, дотуур байр зочид буудал, амралт сувиллын тодорхой өрөөг багтаан ойлгож болох юм.⁸² Ингэж үзвэл, хэрэг бүртгэгч, мөрдөгчийн үзлэг хийж нотлох баримт илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээ өргөн болох нь харагдана.

⁷⁶ Ш.Одонтог, М.Баттөгс Монгол хэлний гучтын тайлбар толь. 2013. 497 дахь тал

⁷⁷ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. 2003. 132 дахь тал

⁷⁸ Ред Ж.Болдбаатар. Гэмт хэрэг илрүүлэхүй /Хамтын бүтээл/. 2015 259 дэх тал

⁷⁹ Эрүүгийн хууль. УБ., 2015

⁸⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017

⁸¹ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. 2003. 16 дахь тал

⁸² Мөн тэнд 196 дахь тал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орон байрны үзлэг явуулах гэмт хэрэг үйлдэгдсэн газар нь гэр, орон сууц байж болно. Гэр, орон сууцанд хийх үзлэгийг шүүх хэрэгжүүлэх эрхтэй. Энэ нь гэр, орон сууц нь орон байр гэдэг ойлголтод хамрагддагтай холбоотой.

Шүүхийн хэлэлцүүлгийн шат буюу мөрдөн шалгах ажиллагааны дүнг шинжлэн судлах⁸³ явцад процесст оролцогчдын санаа бодлыг сонссоны дараа талуудын хүсэлтээр шүүх орон сууцанд үзлэг явуулах тухай шийдвэр гаргаж болно.

ОХУ-д хийсэн судалгааны үр дүнд орон байранд явуулсан үзлэгийн үед нотлох баримт илрүүлсэн нэг ч эрүүгийн хавтаст хэрэг байгаагүй нь анхаарал татна.⁸⁴ Гэхдээ энэ нь шүүх хуулийн хэм хэмжээг хэрэглэхгүй байгаатай холбоотой гэж үзэж болох талтай.

Орон сууцанд үзлэг хийсэнтэй холбоотой ОХУ-д гарсан тохиолдлыг авч үзье. Хохирогчийн хүсэлтээр шүүх ажиллагааны явцад орон байранд буюу гэмт хэрэг үйлдэгдсэн хохирогчийн орон байранд үзлэг хийх шийдвэр гаргасан. Үзлэгийн явцад шүүх орон сууцны нэг өрөөнд орших нэгэн шүүгээний араас даавууны хэсэг үлдэгдэл бүхий товч илрүүлсэн байна. Явуулсан шүүхийн шинжилгээний үр дүнд бүс даавууны үлдэгдэл бүхий товч мөрдөн байцаалтын үед явуулсан нэгжлэгийн явцад шүүгдэгч этгээдээс хурааж авсан хүрэмний нэг хэсэг байсныг тогтоосон. Шүүхийн хэлэлцүүлгийн процесст эд мөрийн нотолгооны чанартай мэдүүлсэн мөрийн баримтын /утасны үлдэгдэлтэй товч/ тусламжтай шүүх тухайн хэргийг шийдвэрлэсэн байна.

Газар оронд үзлэг хийх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Шүүх хуралдааны явцад газар орны үзлэгийг хэрэгжүүлж болно. Тухайлбал, ОХУ-д автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон тээврийн хэрэгслийн зөрчилтэй холбогдолтой хэргийн газар очиж, зам тээврийн зөрчил үйлдэгдсэн машин авто замын нөхцөл байдлыг бодитоор төсөөлөх, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад гаргасан дүгнэлтүүдийг хянаж шалгах, шүүхийн хэлэлцүүлэгт оролцогчдын мэдүүлгийг гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байр байдалтай харьцуулах зорилгоор үзлэг хийдэг байна. ОХУ-ын судлаач М.Р.Ягубович 300 эрүүгийн хавтаст хэргийг судалсан байна. Судалсан 300 хэргийн 31 хэрэгт шүүх газар, орон байранд үзлэг хийсэн байна. Гэмт хэрэг тус бүрээр авч үзвэл:

- Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой гэмт хэрэгт 17 тохиолдол буюу /54.8%/,
- Хулгайлах, дээрэмдэх гэмт хэргийн 12 тохиолдол буюу /38.7%/,
- Бусад хэрэг 2 тохиолдол буюу /6.5%/⁸⁵,

Гэхдээ шүүхийн үйлдлийг хэрэгжүүлэхэд шинэ эд мөрийн нотлох баримтыг илрүүлэх нь маш ховор байдаг ажээ.

Шүүгдэгч хохирогч ба гэрчүүдийн мэдүүлгийг нягталж шалгах ажиллагаа нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад хэрэгждэг. Шүүх шинжээч, тусгай мэргэжилтнийг оролцуулан шинжилгээгээр тогтоогдсон бие эрхтний бэртэл гэмтлийг хохирогчид учруулах боломжгүй талаарх шүүгдэгчийн гаргаж буй нотлох баримтыг хянаж шалгадаг. Үүний тулд шүүгдэгч шүүх хуралдааны хуралдааны танхимд хохирогч, мэргэжилтнийг оролцуулан, хохирогчийг хэрхэн цохиж, зодсоноо дүрслэн харуулсны дараа шүүгдэгчийн үйлдэл мэдүүлгийн дагуу тогтоогдсон бие эрхтний бэртэл гэмтэл учрах боломжтой эсэх, эсвэл боломжгүй талаар шинжээч, мэргэжилтнүүдийн дүгнэлтийг сонсдог. Дурдаж буй нөхцөл байдалд мэдүүлгийн хяналт шалгалт хэргийн газарт очихгүйгээр хэрэгждэг. Энэ нь мэдүүлгийг газар дээр нь шалгах эрүүгийн процессын тодорхой ажиллагаанд багтах ёстой юм. Тухайн шүүхийн үйлдэл шинэ эд мөрийн баримт нотолгоонууд олоход чиглэгдэхгүй нь мэдээж.

Иймд шүүхээс явуулах газар орон ба орон байрны үзлэгийн зорилго нь шүүгдэгч, хохирогч, гэрчийн мэдүүлгийг газар дээр нь магадлан шалгах, тэдгээрийн мэдүүлгийг хэргийн газрын байр байдалтай харьцуулах, хэргийн газрын тухай өөрийн харьцуулсан төсөөлөлтэй болох, мөрдөн байцаалт явуулдаг албадын дүгнэлтийг нягтлан шалгах аас ялгаатай гэж үзэж

⁸³ Ред Ж.Болдбаатар. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. УБ., ДХИС. 2020. 202 дахь тал

⁸⁴ М.Р.Ягубович “Способы собирания вещественных доказательств в Российском уголовном процесс”. Краснодар. 2016

⁸⁵ Краснодар мужийн Тихорецк хотын дүүргийн шүүхийн архив. Эрүүгийн хэрэг №1-137/12.2012

болно. Харин шүүгч газар орон ба орон байранд үзлэг явуулахдаа шүүгдэгч, хохирогч, гэрчийн мэдүүлгийг газар дээр нягтлан шалгаж болно.

Хэргийг шүүхээр хэлэлцэх хүртэл тодорхой хугацаа өнгөрсөн байдаг учраас хэргийн газрын үзлэг нотлох баримтыг илрүүлж, хурааж авахад шууд чиглэгддэггүй. Гэсэн ч эд мөрийн нотолгооны шинж чанартай шинэ зүйл илрэх магадлалтай гэж үзэж болно. Иймд илэрсэн нотлох баримтыг нотолгооны ач холбогдолтой болгохын тулд шүүх, тэдгээрийн эрүүгийн хэргийн материалд хамааруулах процессын ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

Дүгнэлт

Шүүхийн хэлэлцүүлгийн явцад шүүх нь мэдүүлгийг газар дээр нь магадлан шалгахын зэрэгцээ шүүх газар орон ба орон байранд үзлэг хийх нь оновчтой зохицуулалт болжээ.

Шүүх талуудын хүсэлтээр хэрэг гарсан газар, орон байранд үзлэг хийх ажиллагаа нь шүүх хуралдааны нэг хэсэг юм.

Орон сууцанд хийх үзлэгийг шүүх хэрэгжүүлэх эрхтэй субъект юм. Харин ямар газар орон, ямар орон байранд үзлэг хийж болохыг тодруулах шаардлагатай байна. Орон байр, орон байрны эргэн тойрон дахь газар, гэр, хашаа, тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, усан онгоц, тухайн хэрэг гарсан нутаг дэвсгэрийн хүрээг нарийвчлан тодруулж хуульчилж өгөх нь зүйтэй.

Газар орон, орон байрны шүүхийн үзлэгийг гүйцэтгэх үед шинэ нотлох баримт илэрч болох бөгөөд илэрсэн нотлох баримтыг нотолгооны ач холбогдолтой болгохын тулд тогтоол гаргах шаардлагатай.

Шүүх газар орон ба орон байранд үзлэг хийх нь хэргийг шүүх хуралдаанаас хэрэг шүүхийн өмнөх шат руу буцаахгүйгээр шийдвэрлэх боломж гэж үзэж болно.

Ном зүй

Нэг. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ. 1992. Төрийн мэдээлэл №1
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017
3. Эрүүгийн хууль. УБ. 2015
4. Хүний Эрхийн Түгээмэл тунхаглал. 1948

Хоёр. Ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

5. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ. 2003
6. Ш.Одонтог, М.Баттөгс Монгол хэлний гучтын тайлбар толь. 2013
7. Гэмт хэрэг илрүүлэхүй /Хамтын бүтээл/. УБ. Хууль сахиулахын их сургууль. УБ., 2015
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /Хамтын бүтээл/. УБ. Дотоод хэргийн их сургууль. 2020
9. М.Р.Ягубович “Способы собирания вещественных доказательств в Российском уголовном процесс”. Краснодар. 2016 г

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АНХАН ШАТНЫ НЭГЖ, АЛБА ХААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б.Баянмөнх

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд ОХУ, БНХАУ, Япон Улсын цагдаагийн анхан шатны нэгжид ажилладаг алба хаагчдын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог, түүнчлэн, манай улсын цагдаагийн хэсгийн байцаагчийн ажил, үүрэгтэй төсөөтэй болон ялгаатай шинж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж болох зарим туршлагын талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг: Цагдаагийн байгууллага, цагдаагийн хэсэг, хэсгийн байцаагч, Кобан, Чузайшо.

Үндсэн хэсэг

ОХУ, БНХАУ, Япон Улсын 100.000 хүнд ногдох цагдаагийн алба хаагчийн тоог харьцуулж үзвэл, ОХУ нь 2016 оны байдлаар 623⁸⁶, Япон Улс 2017 оны байдлаар 234⁸⁷, БНХАУ 2018 оны байдлаар 143⁸⁸, Монгол Улс 272 алба хаагч тус тус ногдож байна.

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс нь хагас Ерөнхийлөгчийн засаглалт бүгд найрамдах, 85 субъектээс бүрдэх холбооны улс юм. ОХУ нь 17.075.400 километр квадрат газар нутагтай бөгөөд газар нутгийн хэмжээгээрээ Хойд Азийг бүхэлд нь, Европын 40 хувийг эзэлдэг, хөндлөнгөөрөө 11 цагийн бүсд хуваагддаг, нийт 146.780.720⁸⁹ хүн амтай.⁹⁰

Оросын Холбооны Улс нь Үндсэн хуулийн 68 дугаар зүйлд заасан засаг захиргааны хувиараар бүгд найрамдах улс⁹¹, хязгаар⁹², муж⁹³, өртөө засах муж⁹⁴, холбооны хот⁹⁵, өөртөө засах тойргоос⁹⁶ тус тус бүрддэг.

ОХУ-ын Цагдаагийн тухай хуулийн 1.1-д “Цагдаа нь ОХУ-ын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, эд хөрөнгийг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ” гэж заажээ. Уг хуулийн 2 дугаар зүйлд ОХУ-ын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж өгчээ. Үүнд:

- Хувь хүн, нийгэм, төрийг хууль бус халдлагуудаас хамгаалах;
- Гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох;
- Гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэргийг бүртгэх;
- Хүмүүсийг эрэн хайх;
- Захиргааны зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх, захиргааны шийтгэлийг биелүүлэх;

⁸⁶ <http://publication.pravo.gov.ru>. Указ Президента Российской Федерации от 20.09.2016 № 480 "Об изменении и признании утратившими силу некоторых актов Президента Российской Федерации"

⁸⁷ <https://en.wikipedia.org>. List_of_countries_and_dependencies_by_number_of_police_officers

⁸⁸ <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Asia-South-Pacific/CHINA>

⁸⁹ <http://www.statdata.ru/russia>

⁹⁰ <https://ru.wikipedia.org/wiki>.

⁹¹ Бүгд Найрамдах Улс (Оросоор республика)

⁹² хязгаар (оросоор край).

⁹³ муж (оросоор область)

⁹⁴ өөртөө засах муж (Оросоор автономная область)

⁹⁵ холбооны ач холбогдолтой хот (оросоор город федерального значения)

⁹⁶ Өөртөө засах тойрог (Оросоор автономный округ)

- Олон нийтийн газар хууль ёсыг хангах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гэрч, хохирогч, бусад оролцогч болон шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хууль сахиулах болон хяналтын байгууллагын алба хаагчид, мөн хамгаалалтад байгаа бусад хүмүүсийг хамгаалах;
- Криминалистикийн шинжилгээний үйл ажиллагаа.⁹⁷

ОХУ-ын нутаг дэвсгэрийн цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь ОХУ-ын “Цагдаагийн хууль” болон ДЯЯ-ны сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн “Цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан засаг захиргааны нутаг дэвсгэртээ зохион байгуулж явуулах үйл ажиллагааны тухай” 205 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан засаг захиргааны нутаг дэвсгэрт албан үүрэг гүйцэтгэх заавар”, “Цагдаагийн хэсгийн байцаагчийн албыг зохион байгуулах журам”⁹⁸-аар тус тус зохицуулагджээ.

Уг зааврын 1.3-т Оросын цагдаагийн хэсгийн байцаагч нь ОХУ-ын 2011 оны зургаа, 2012 оны хоёр, 2013 оны тав, 2016 оны хоёр, 2017 оны дөрөв, 2018 оны дөрөв, 2019 оны нэг хууль, нийтдээ 24 хуулийг үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллахаар тусгасан байна. Энэхүү шинэ заавраар хэсгийн байцаагчийн үйл ажиллагаатай холбоотой дараах онцлог бүхий зохицуулалтуудыг оруулсан байна. Тухайлбал,

Хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээ, хил хязгаарын талаар:

- Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын тушаалаар хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээ, хил хязгаарыг тогтоож болох;
- Хотын хувьд оршин суугч иргэдийн тоо, түүнчлэн урьдчилан сэргийлэх бүртгэлд авагдсан иргэдийн тоо, тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, засаг захиргааны онцлогийг харгалзах;
- Хөдөө орон нутагт баталж өгсөн орон тоо, төсөвтөө багтаан нэг болон хэд хэдэн нутаг дэвсгэрийг хамааруулан томилж болох зэрэг болно.

Цагдаагийн хэсгийн хүний нөөцийн талаар:

- Хоёр хэсгийн байцаагч тутамд нэг хэсгийн ахлах байцаагч томилох;
- Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлаас шалтгаалан хэсгийн байцаагчийн нөөцийг хангах, сургах зорилгоор нутаг дэвсгэрийн байгууллага хэсгийн байцаагчийн туслахыг томилж болох;
- Нэг ахлах байцаагчийн орон тоонд нэг туслах томилж болох;
- Хөдөө орон нутаг болон алслагдсан газар нэг хэсгийн байцаагчийн орон тоонд нэг туслахыг томилж нөөцийг бүрдүүлэх;
- Хэсгийн байцаагчийн туслахыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын тушаалаар тодорхой хэсгийн байцаагчид хариуцуулан өгч, түүний шууд удирдлагын дор бага даргалах бүрэлдэхүүний албан тушаал дээр ажиллуулах зэрэг болно.

Дээрх зохицуулалтуудыг Оросын хэсгийн байцаагчийн ажлын зааварт оруулсан бөгөөд энэ нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага бие даасан шийдвэр гаргах эрхийг олгосон, нөгөө талаараа хэсгийн байцаагчийн нөөцийг бэлтгэх боломжийг бүрдүүлсэн байна.

Оросын цагдаагийн хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэр дээр дараах үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- ОХУ-ын ДЯЯ-наас гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх талаар гаргасан эрх зүйн актууд болон албан үүргийн хуваарийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэргийг илрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч, захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх.
- ОХУ-ын Эрүүгийн хуулийн⁹⁹ 112 дугаар зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах”, 115-р зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд санаатай хөнгөн

⁹⁷ <http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi>. Федеральный закон от 07.02.2011 N 3-ФЗ (ред. от 06.02.2020) "О полиции"

⁹⁸ <http://www.consultant.ru/document>. Приказ МВД России от 29 марта 2019 г. № 205 “О несении службы участковым уполномоченным полиции на обслуживаемом административном участке и организации этой деятельности”

⁹⁹ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/. "Уголовный кодекс Российской Федерации" от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 18.02.2020)

хохирол учруулах”, 116 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Захиргааны шийтгэл хүлээсэн этгээд бусдыг дахин зодох”, 117 дугаар зүйлд заасан “Эрүүдэн шүүх”, 118 дугаар зүйлд заасан “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах”, 119 дүгээр зүйлд заасан “Хүнийг алах, эрүүл мэндэд хүнд хохирол учруулахаар заналхийлэх”, 134 дүгээр зүйлд заасан “Арван зургаагаас доош насны хүнтэй бэлгийн харьцаанд орох”, ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуулийн¹⁰⁰ 6.1.1 дүгээр зүйлд заасан “Зодох”, 19.24 дүгээр зүйлд заасан “Захиргааны хяналт шалгалтын явцад тогтоосон үүргээ биелүүлээгүй, захиргааны хязгаарлалтыг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн, ахуйн шинжтэй” гэмт хэргүүдийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

- Урьдчилан сэргийлэх бүртгэлд байгаа этгээдүүдтэй нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Иргэдийг хүлээн авч уулзах.
- Харьяалалд хамаарах иргэдийн өргөдөл, мэдээллийг эрх хэмжээний хүрээнд хүлээн авч шийдвэрлэх.
- Хорих байгууллагаас суллагдсан этгээдүүдэд захиргааны хяналт тавих тухай Холбооны хуулийн дагуу захиргааны хяналтад байгаа болон шүүхээс эрх, эрх чөлөөг нь түр хязгаарласан этгээдүүдэд ажиглалт явуулж, хяналтыг хэрэгжүүлэх.

Оросын хэсгийн байцаагчийн явуулах дээрх үйл ажиллагааны олонх нь манай хэсгийн байцаагчийн явуулж буй үйл ажиллагаатай адил төстэй боловч дараах ялгаатай тал байна. Үүнд:

- Оросын хэсгийн байцаагчийн явуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээг хуульд тусгайлан зааж өгсөн;
- Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй этгээдүүдтэй нэг бүрчилсэн ажил зохион байгуулдаг;
- Хорих байгууллагаас суллагдсан этгээдүүдэд захиргааны хяналт тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг.

Харин манай хэсгийн байцаагчийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар хязгаарладаггүй, хорих байгууллагаас суллагдсан иргэн бүрт захиргааны хяналт тогтоодоггүй, урьдчилан сэргийлэх нэгдсэн бүртгэл гэж байдаггүй, зөвхөн судалгаа байдаг нь ялгаатай байна.

Оросын цагдаагийн хэсгийн байцаагч нь байгууллагын дарга болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах ажил эрхэлсэн орлогч даргын баталсан хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэдэг бөгөөд уг цагийн хуваарьт албаны болон амралтын өдрүүд, ээлжийн амралт, түүнчлэн ажилд гарах, буух цагийг тусгажээ. Цагдаагийн хэсгийн байцаагч ажилд гарахын өмнө шуурхай жижүүрийн хамт цагдаагийн байгууллагын дарга, нийгмийн хэв журам хамгаалах орлогч дарга, эсхүл шууд удирдах даргаас зааварчилгаа авдаг, уг зааварчилгаа нь 20 минутаас илүүгүй байдаг байна. Мөн хэсгийн байцаагч нь ажлын өдөр дууссаны дараагаар байгууллагын даргад, түүний эзгүйд удирдлагаас томилсон хариуцлагатай ажилтан, эсхүл шуурхай жижүүрт илтгэж, хийсэн ажлын талаарх мэдээллийг өдөр тутмын тайланд оруулдаг байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын үндсэн хэлбэрийг зааварт дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хариуцсан нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх эргүүл хийх;
- Иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- Иргэдийг хүлээн авах;
- Хийсэн ажлаа оршин суугчдад тайлагнах.¹⁰¹

Оросын цагдаагийн хэсгийн байцаагч нь гэмт хэрэг, захиргааны зөрчил, үйл явдлын талаар өргөдөл, мэдээлэл, гомдлыг эрх бүхий албан тушаалтанд танилцуулсны дараа шалгах ажиллагаа явуулдаг зохицуулалттай юм байна. Түүнчлэн хэсгийн байцаагч нь иргэдийг хүлээн

¹⁰⁰ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/. "Кодекс Российской Федерации об административных правонарушениях" от 30.12.2001 N 195-ФЗ (ред. от 01.03.2020)

¹⁰¹ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_328491. ОХУ-ын “Цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан засаг захиргааны нутаг дэвсгэрт албан үүрэг гүйцэтгэх заавар”-ын 2.22.

авах ажлыг өөрийн ажлын байранд мягмар, пүрэв гарагийн 17-19 цаг, харин бямба гарагт 15-16 цагт хариуцсан нутаг дэвсгэртээ үүрэг гүйцэтгэх үедээ хүлээн авахаар¹⁰² зохицуулж өгчээ. Иргэдийг хүлээн авах цаг, байрны мэдээллийг иргэдэд хүргэхдээ эргүүл хийх, оршин суугчдад ажлаа тайлагнах үед, түүнчлэн хүмүүс ихээр цуглардаг газарт байрлах мэдээллийн самбараар дамжуулан хүргэдэг байна.

Оросын цагдаагийн хэсгийн байцаагч нь нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах этгээдүүдэд авч хэрэгжүүлдэг юм байна. Үүнд:

- Захиргааны хяналт тогтоогдсон;
- Хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдээд хорих газраас суллагдсан, рецетив гэмт хэрэгтэн;
- Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг санаатай гэмт хэрэг үйлдсэн;
- Гэр бүл, ахуйн зөрчил гаргадаг;
- Эмнэлгийн байгууллагын хяналтад байдаг архидан согтуурах донтой этгээд;
- Нийгэм, улс төрийн арга хэмжээ, эсвэл нийтийг хамарсан спортын болон бусад арга хэмжээний үед нийгмийн хэв журам болон нийтийн аюулгүй байдалд халдсан захиргааны зөрчил үйлдсэн этгээдүүдэд нэг бүрчилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Оросын хэсгийн байцаагч хариуцсан нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэхдээ дараах төрлийн урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Хариуцсан нутаг дэвсгэрийн иргэд, оршин суугчдад иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалахад чиглэсэн болон гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийг гаргуулахгүй байлгах, гаргасан тохиолдолд үйлдсэн гэмт хэрэг, зөрчилд заавал хариуцлага хүлээлгэх талаар мэдээлэл хүргэх;
- Урьдчилан сэргийлэх ярилцлага хийх;
- Гэмт зан үйлийг үргэлжлүүлэхийг зогсоох, түүнчлэн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх нөхцөлийг бий болгосон үйл ажиллагааг гаргуулахгүй байх тухай албан ёсны сануулга өгөх;
- Урьдчилан сэргийлэх бүртгэлд бүртгэх;
- Захиргааны хяналт тавих.¹⁰³

Оросын хэсгийн байцаагч дараах этгээдүүдийг бүртгэлд авдаг байна. Үүнд:

- Хорих байгууллагаас суллагдсан, урьд өмнө ял шийтгэгдсэн;
- Орчин тойрондоо аюул учруулж болзошгүй болон эмнэлгийн байгууллагын хяналтад байдаг сэтгэцийн өөрчлөлттэй;
- Галт зэвсэг эзэмшигч этгээдүүд.

Цагдаагийн хэсгийн байрыг холбооны хэрэгсэл, компьютер, техник хэрэгсэл, тавилга, эд зүйл, галын аюулгүй байдлыг хангах болон аж ахуйн эд хөрөнгөөр хангах ажлыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хариуцан зохион байгуулах үүргийг хүлээдэг байна. Тухайлбал: байрны хаалганы өргөн, ашиглах материал, цонхны хамгаалах тор, гэрэлтүүлэг, дохиолол хамгаалалтын систем, агааржуулалт, усан хангамжид холбогдсон байх, хэсгийн байрны хаяг, ажлын хуваарийн болон мэдээллийн самбар, түүний агуулга, байршуулах газар гэх мэтийг нарийн зааснаас гадна жилд нэгээс доошгүй удаа шалгадаг байна.

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга, даргын нийгмийн хэв журам хариуцсан орлогч дарга /газар, хэлтэс, тасаг, хэсэг/ нар удирдан чиглүүлж, үйл ажиллагаанд нь хагас жил тутам хяналт шинжилгээ хийдэг байна. Түүнчлэн, "Цагдаагийн хэсгийн байцаагч нарын албыг зохион байгуулах журам"-аар ОХУ-ын ДЯЯ-ны районы түвшний нутаг дэвсгэрийн цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий албан тушаалтны үүргийг тусгайлан зааж өгсөн нь манай "хэсгийн байцаагчийн ажлын заавар"-аас ялгагдах нэг онцлог зохицуулалт болжээ.

Оросын цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, явуулах үйл ажиллагааны хүрээг заавраар бүрэн тодорхойлж, тодорхой ажиллагааны арга зүйг тусгайлан зааж өгсөн байна. Түүнчлэн, хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хэмжээ, хил хязгаарыг бүс нутгийн цагдаагийн байгууллагын дарга тогтоож өгсөн нь түүний ажлын ачааллыг зохицуулахад чухал болжээ. Мөн хэсгийн байцаагчийн ажлын байр, орчин нөхцөл, ажил үүрэг

¹⁰² Мөн зааврын 4.31.

¹⁰³ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_328491. ОХУ-ын "Цагдаагийн хэсгийн байцаагчаас хариуцсан засаг захиргааны нутаг дэвсгэрт албан үүрэг гүйцэтгэх заавар"-ын 36 дугаар зүйл

гүйцэтгэхэд шаардлагатай материал-техникийн хангамжийн асуудлыг бүс нутгийн цагдаагийн байгууллага бүрэн хариуцахаар шийдэж өгсөн байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь 9.6 сая км² нутаг дэвсгэртэй, 1,3 тэрбум хүн амтай, ард иргэдээ хэл, яс үндсийг нь харгалзан 56 нэрээр бүртгэдэг бөгөөд хятад үндэстэн 91.5 хувийг бүрдүүлж, үлдсэн 8.5 хувийг 16.9 сая жуан, 10.5 сая хотон, 10.3 сая манж, 10.0 сая уйгур, 9.4 сая мяо, 8.7 сая и, 8.3 сая тужа, 6 сая түвд, 6 сая өвөрмонгол, цаашилбал солонгос, хасаг, дуншян, дагуур, татар зэрэг үндэстэн, ястнаас бүрддэг байна.¹⁰⁴

БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам нь улс орны хэмжээнд төр улсын аюулгүй байдал, төрийн дээд удирдлага, улсын хил, онц чухал байгууламж, объектуудыг хамгаалах, нийгмийн хэв журмыг сахиулах, алан хядагчтай тэмцэх, олон нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, жагсаал цуглааны үйл ажиллагааг хяналтад байлгах, гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг гардан гүйцэтгэдэг гүйцэтгэх засаглалын байгууллага юм.

Тус яамны бүтцэд 28 нэгж салбар, газрууд ажилладаг.¹⁰⁵ Тус яамны харьяа Хятадын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь "БНХАУ-ын Ардын цагдаагийн тухай хууль" юм.

Хятадын Бүх ардын төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны 1995 оны 2-р сарын 28-ны өдрийн 12-р хуралдаанаар "БНХАУ-ын Ардын цагдаагийн тухай хууль"-ийг баталж мөрдсөн бөгөөд Бүх ардын төлөөлөгчдийн Их хурлын Байнгын хорооны 2012 оны 10-р сарын 26-ны өдрийн 29-р хуралдаанаас "БНХАУ-ын Ардын цагдаагийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай"¹⁰⁶ 40-р тогтоол гарч, шинэчлэгдсэн байна.

"Ардын цагдаагийн тухай хууль" нь ерөнхий зүйл, эрх мэдэл, үүрэг ба сахилга бат, байгууллагын менежмент, цагдаагийн батлан даалт, хууль сахиулах хяналт, эрх зүйн хариуцлага, нэмэлт зүйл гэсэн 8 бүлэг, 52 зүйлээс бүрддэг байна.¹⁰⁷ Тус хуулийн 2-р зүйлд "Ардын цагдаагийн үүрэг бол үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам сахиулах, иргэдийн хувийн аюулгүй байдал, хувийн эрх чөлөө, хууль ёсны өмчийг хамгаалах, нийтийн өмчийг хамгаалах, хууль бус болон эрүүгийн үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх явдал юм"¹⁰⁸ гэж заажээ.

БНХАУ-ын цагдаагийн байгууллагын бүтэц, тогтолцоо нь таван салбар чиглэлийн үүрэг гүйцэтгэдэг ардын цагдаагаас бүрддэг байна. Үүнд:

- Олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэг бүхий цагдаа.
- Шүүхийн байгууллагын цагдаа.
- Улсын аюулгүй байдлыг хариуцсан цагдаа.
- Зэвсэгт цагдаа.
- Шүүхийн цагдаа.¹⁰⁹

БНХАУ-ын цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь засаг захиргааны хуваарилалтад тулгуурлан хийгдсэн байдаг бөгөөд цагдаагийн анхан шатны нэгжийг хотод хэсэг, хөдөө орон нутагт хороо гэдэг байна.

Засаг захиргааны IY, Y зэрэглэлийн балгас, хороо /хошууны дүүрэг/, бага ардын шянь /сум/, бага ардын сум, гацаа, тосгон зэрэг газруудын хүн амын нягтаршил, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлаас хамаарч цагдаагийн хэсгийн тоог тогтоодог байна.

Цагдаагийн нэг хэсэгт ойролцоогоор 5-6 цагдаа ажиллаж, ахлах цагдаа нь удирддаг.¹¹⁰ Хэсэг, хорооны цагдаа нарын гүйцэтгэх үүргийг авч үзвэл:

- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах сургалт, сурталчилгаа явуулах.
- Хорооны иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.
- Хорооны иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

¹⁰⁴ Ч.Ганболд, Ч.Болдбаатар, Д.Ядамдорж. Police: Дэлхийн цагдаа, Монгол цагдаагийн он дарааллын түүхчилсэн хураангуй. УБ., 2016. 101 дэх тал

¹⁰⁵ <https://www.mps.gov.cn>.

¹⁰⁶ <https://baike.baidu.com/item/中华人民共和国人民警察法>

¹⁰⁷ <http://www.jiuwenlaw.com/fagui/1407.html>

¹⁰⁸ http://news.xinhuanet.com/legal/2012-10/26/c_113513633.htm

¹⁰⁹ <https://www.mps.gov.cn>.

¹¹⁰ <http://police.cpd.com.cn>.

- Нийгэм, улс төрийн тогтвортой байдал, олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг цаг тухайд нь цуглуулж тайлагнах.
- Хорооны нийгмийн байдлыг тогтмол шалгаж, дүн шинжилгээ хийх.
- Олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг тодруулж нягтлах.
- Өөрийн цуглуулсан бүх төрлийн мэдээллийг компьютерт бүртгэх, хуримтлуулах, дүн шинжилгээ хийх, харьцуулах.
- Хүн амыг нарийвчлан бүртгэж, амьжиргааны нөхцөл байдлыг судалж мэдэх.
- Хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг гарах магадлал өндөртэй газруудыг тодорхойлох.
- Гэмт хэрэгт холбогдсон иргэдэд хяналт тавих.
- Түрээсийн байранд болон түр оршин суугчдын судалгааг гаргаж хяналт тавих.
- Аюулгүй байдлыг хангах талаар олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтийн мэдлэг чадварыг дээшлүүлэх.
- Олон нийтийн аюулгүй байдлын эргүүл, хорооллын харуул хамгаалалт болон батлан хамгаалах, хамгаалалтын алба, сайн дурын эргүүл зэрэг үйл ажиллагааг удирдан чиглүүлж, бүлэг байгуулан ажиллах.
- Олон нийтийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулж явуулах.
- Олон нийтийн болон зугаа цэнгэлийн газар, тусгай үйлдвэр, худалдааны газар, түрээсийн байр, аюултай барааны аюулгүй байдлыг чанд сахиулж, аюулгүй байдлын хяналт шалгалтыг тогтмол хийж, аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох, сайжруулах.
- Аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гол нэгжүүдэд хяналт тавьж, удирдан чиглүүлэх.
- Гэмт хэрэг, нийтийн аюулгүй байдал алдагдахаас болон гамшгаас урьдчилан сэргийлэх, багасгах ажил явуулах.
- Харьяаллын дагуу олон нийтийн аюулгүй байдлын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд туслалцаа үзүүлэх.
- Тухайн нутаг дэвсгэрт оршин суугчдад гамшгаас урьдчилан сэргийлэх, өөртөө туслах мэдлэг, ур чадварыг сурталчлан таниулах.
- Гамшгаас урьдчилан сэргийлэх онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж, боловсон хүчний бэлтгэлийг тогтмол зохион байгуулж, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагааг тогтмол сайжруулах.
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах ажиллагааны механизм, бие бүрэлдэхүүний тусгай холбоог бүрдүүлж ажиллах.
- Онцгой байдлын үед дуудах болон гамшгийн ослыг эрт үед нь арилгах ажлыг хийх.
- Гамшгийн бүс дэх нийтийн аюулгүй байдлын менежментийг бэхжүүлэх.
- Гамшгийн дараа гарсан нийгмийн байдал, олон нийтийн санаа бодлыг цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр намын байгууллагууд болон батлан хамгаалах байгууллагуудад илтгэх үүрэгтэй.¹¹¹

Хятадын цагдаагийн байгууллагын анхан шатны хэсэгт ажиллах хорооны цагдаа нарын гүйцэтгэх үүргийг үзвэл хариуцсан нутаг дэвсгэрийн судалгаа, тэр дундаа иргэдийн шилжилт хөдөлгөөний судалгааг нарийвчлан хийдэг бөгөөд тухайн нутаг дэвсгэрт болж байгаа үйл явдлын талаарх бүх төрлийн мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийдэг, тэр дундаа олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаа нь давамгайлсан байгаа нь харагдаж байна.

Хятадын цагдаагийн хэсгийн хорооны цагдаа нарын гүйцэтгэх үүргийг манай цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэгтэй харьцуулахад ижил болон ялгаатай тал харагдаж байна.

Ижил төсөөтэй тал:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Хорооны иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

¹¹¹ <http://police.cpd.com.cn>. The Ministry of Public Security of the People of China.

- Гэмт хэрэг гарах магадлал өндөртэй газруудад хяналт тавих;
- Гэмт хэрэгт холбогдсон иргэдэд хяналт тавих;
- Олон нийтийн болон үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Харьяалах нутаг дэвсгэрт эргүүл хийх;
- Олон нийтийн эргүүлийг зохион байгуулах.

Ялгаатай тал:

- Нийгэм, улс төрийн тогтвортой байдлын талаарх мэдээлэл цуглуулдаг;
- Хорооны нийгмийн нөхцөл байдлыг судалдаг;
- Хүн амын нарийвчилсан бүртгэл судалгаа хийдэг;
- Аюулгүй байдлыг хангах талаар олон нийтэд сурталчлан таниулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт явуулдаг;
- Батлан хамгаалах, харуул хамгаалалтын алба зэрэг бүлэг байгуулж, удирдан чиглүүлдэг;
- Олон нийтийн аюулгүй байдал алдагдах, гамшгаас урьдчилан сэргийлэх, багасгах ажил хариуцдаг.

Япон Улс

Япон Улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн нэгж нь, Токиогийн нийслэлийн тойрог, Хоккайдо арал, 43 префектурууд (мужууд)-д хуваагддаг.¹¹²

Япон Улс нутаг, засаг захиргааны 47 нэгж болж хуваагдана. Үүнд: Токио хот (都 to), Хоккайдо хязгаар (道 dō), Осака, Киото хотожсон аймаг (府 fu), бусад нэр бүхий 43 энгийн аймаг (県 ken) багтана. Энэ түвшнээ японоор тодоофүкэн (都道府県 todōfuken) гэнэ.

Монгол Улсын засаг захиргааны нэгжээр бол аймагтай дүйцүүлж болох Японы аймаг нь дотроо хэд хэдэн хот (市 shi), хошуу (郡 gun) болж хуваагдана. Хошууд нь дотроо балгас (町 chō), гацаа (村 son) болж задарна. Зарим аймаг дотроо завсрын шат үүсгэдгийг тойрог (支庁 shichō) гэнэ. Жишээ нь Хоккайдо дотроо 14 тойрогт хуваагддаг байна.¹¹³

1874 онд үүсэн байгуулагдсан Японы цагдаа нь төв буюу дээд газраасаа хамааралтай 7 бүс нутгийн цагдаагийн газруудтай, Токио, Осака, Киото хот болон Хоккайда арал зэрэг цагдаагийн 43 томоохон салбар газар ажилладаг байна.

Цагдаагийн тухай хууль нь дайны дараа 1947 онд батлагдсан бөгөөд энэ үеэс эхлэн орон нутгийн цагдаа, хотын цагдаагийн хос тогтолцоотой болжээ. Үүний дараа 2017 онд цагдаагийн байгууллагын тухай хуулийг шинэчлэн боловсруулж баталжээ.¹¹⁴

“Японы цагдаа бол Цагдаагийн тухай хуулийн 2-р зүйлийн 1-д заасны дагуу олон нийтийн аюулгүй байдал, дэг журмыг сахиулах, хувийн амьдрал, бие махбод, эд хөрөнгийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэжигтний үйлдлийг таслан зогсоох, эрэн сурвалжлах, баривчлах, замын хөдөлгөөнийг хянах, олон нийтийн аюулгүй байдал, дэг журмыг сахиулах үүрэгтэй төрийн албан хаагч”¹¹⁵ гэж тодорхойлжээ.

Цагдаагийн үндэсний удирдлагын хувьд Нийгмийн аюулгүй байдлын үндэсний комисс (дарга нь сайд, таван гишүүнтэй) Ерөнхий сайдын удирдлагад байдаг.

Япон улсын үндэсний цагдаагийн газрын анхан шатны хэсгийг газар зүйн байршлаас нь хамаараад Кобан, Чузайшо хэмээн нэрлэдэг байна.

Кобан ба Чузайшогийн түүхээс харахад Кобан тогтолцоо нь 140 гаруй жилийн түүхтэй бөгөөд 1874 онд Межийн хаант засаглал байгуулагдсаны дараа Межийн Засгийн газарт Дотоод хэргийн яам, Токиогийн Цагдаагийн газрыг байгуулснаар Токиогийн цагдаагийн газар нь “Koban-Sho”-г өөрийн салбар болгон байгуулжээ. Koban-Sho-г онцгойлсон газруудад байгуулж, томилогдсон цагдаагийн алба хаагчид зогсоогоор харуул хамгаалалт хийдэг байсан бөгөөд 1881 онд эдгээр цэгүүдэд энгийн тоноглол бүхий барилга барьсан нь өнөөгийн Кобаны үндэс суурь болжээ.¹¹⁶

¹¹² Т.Доохүү, Ч.Энхбаатар. Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй. Тусгай анги. УБ., 2009. 88 дахь тал.

¹¹³ <https://mn.wikipedia.org/wiki>.

¹¹⁴ <https://www.npa.go.jp/about/overview/sikumi.html>

¹¹⁵ <https://zh.wikipedia.org/wiki>

¹¹⁶ https://www.police-ch.jp/keisatsu_kaiyuu.html

2018 оны 1-р сарын 1-ний байдлаар Япон улсын хэмжээнд цагдаагийн 15000 орчим кобан, 7592 Чузайшо ажиллаж байжээ.

Кобан, Чузайшо нь олон нийтийн цагдаагийн хэсэгт харьяалагдах бөгөөд цагдаагийн газар, хэлтэс бүрт Кобан, Чузайшо байдаг бөгөөд эдгээр нь үндсэндээ олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаа явуулдаг байна.¹¹⁷

Кобан ба Чузайшод үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн цагдаагийн ажилтны үүрэг бол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг баривчлах, замын хөдөлгөөнийг зохицуулах, насанд хүрээгүй хүмүүст заавар зөвлөмж өгөх, хүүхэд алдагдах, архидан согтуурахтай тэмцэх, гэмт хэрэг гарсан тохиолдолд анхан шатны арга хэмжээг нэн даруй авах зэрэг юм.¹¹⁸

Цагдаагийн бусад алба хаагч нартай харьцуулан үзвэл гэмт хэрэг гарсан үед хэрэг бүртгэлтийн хойшлуулшгүй арга хэмжээ авах эрх мэдэл нь хязгаарлагдмал юм байна. Өөрөөр хэлбэл тэрээр аливаа хэрэг, зөрчил гарсан тохиолдолд гэмт хэрэгтний зураг авах, айж сандарсан, гэмтэж бэртсэн, хохирсон хүмүүст туслах, сэжигтний дүр төрх, онцлох шинж тэмдгийг олж авах, түүний зугтсан чиглэл, машин унааг тогтоох, төв рүү мэдээлэх, хэргийн газрыг хамгаалах, сэжигтнийг баривчлах зэрэг үүргийг гүйцэтгэдэг байна.

Японы цагдаагийн байгууллага нь Кобан болон Чузайшог ард түмний аюулгүй амар тайван байдлыг хангах үндсэн хэсэг гэж үздэг бөгөөд улсын хэмжээнд 22600 орчим Кобан (Чузаишо)-д нийт алба хаагчдын 37 хувь нь ажилладаг байна.¹¹⁹

Кобан, Чузайшогийн цагдаагийн ажилтнууд нь хууль сахиулах байгууллагын нэгэн адил гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих үйл ажиллагааг явуулдаг төдийгүй ард иргэдэд дараах үйлчилгээг үзүүлдэг байна. Үүнд:

- Оршин суугчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар заавар, зөвлөмж өгөх.
- Иргэдээс мэдээлэл хүлээж авах, тэдэнд тулгарсан асуудлын талаар зөвлөгөө өгөх.
- Кобан болон Чузайшогийн зөвлөмж, тэдгээрийн үйл ажиллагааны талаар сонин эрхлэн гаргах.
- Ганц бие ахмад хүмүүсийн гэрээр очиж тусламж үзүүлэх.¹²⁰

Хотод Кобан үйл ажиллагаагаа явуулдаг бол хөдөө орон нутагт ойн аж ахуй, загас агнуурын бүс болон тосгонуудад Чузайшо үйл ажиллагаагаа явуулдаг. Кобанд нэг ээлжинд 3-аас олон цагдаагийн ажилтан 24 цагаар кобаны байрандаа байрлаж ажилладаг бол Чузайшод 1 цагдаагийн ажилтан өөрийн гэр бүлийн хамт ажлын өдрүүдэд 8 цагаар Чузайшогийн байрандаа байрлаж ажилладаг байна.

Кобан болон Чузайшо нь дугуй, мотоцикл, жижиг машин, бороохой, бамбай, хоёр амтай буу, сум нэвтэрдэггүй хантааз, гал унтраах бодис, дуулга, гар чийдэнгээр, зарим кобан personal компьютер, факс, телефоноор /TV phone/ тоноглогдсон байна.¹²¹

Японы цагдаагийн алба хаагч нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сайн дурын бүлэглэл, зөвлөлүүдтэй хамтран ажилладаг. Тухайлбал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Цагдаагийн өндөр настны зөвлөл гэх мэт.¹²²

Цагдаагийн хэсэг өөрийн үйл ажиллагаа болон бусад мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх хамгийн түгээмэл хэрэгсэл нь Кобанаас гаргадаг сонин байна. Түүнчлэн Японы цагдаагийн хэсгүүд нь гудамжны багана, төмөр замын өртөө, банкууд зэрэг хүмүүст харагдахуйц газар “Кобаны мэдээ” нэртэй бичиг наадаг, мөн кабелийн телевизээр шуурхай мэдээлэл явуулж хэвшжээ.

Кобан, Чузайшогийн алба хаагчид харьяалах нутаг дэвсгэрийн айл өрх, албан газраар явж гэмт хэрэг, аваар ослоос урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх, тэдний санал сэтгэгдэл, гомдлыг сонсож, санал бодлоо солилцдог¹²³ байна.

¹¹⁷ <https://www.npa.go.jp>. Police of Japan 2018.

¹¹⁸ https://www.police-ch.jp/beginnings_history.html

¹¹⁹ [https://www.npa.go.jp/english/Police of Japan/Police of Japan 2018 full text.pdf](https://www.npa.go.jp/english/Police%20of%20Japan/Police%20of%20Japan%202018%20full%20text.pdf)

¹²⁰ [https://www.npa.go.jp/english/Police of Japan/Police of Japan 2018 full text.pdf](https://www.npa.go.jp/english/Police%20of%20Japan/Police%20of%20Japan%202018%20full%20text.pdf)

¹²¹ https://www.police-ch.jp/keisatsu_kaikyuu.html

¹²² https://www.police-ch.jp/keisatsu_kaikyuu.html

¹²³ <http://www.shugin.go.jp>.

Мөн настай хүмүүст анхаарал халамж тавихад ихээхэн анхаарч ажилладаг бөгөөд тэднийг настайчуудыг халамжлагч агентлагуудтай холбож өгдөг байна.

Японы Кобан, Чузайшогогийн алба хаагчдын гүйцэтгэх үүргийг манай цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэгтэй харьцуулахад ижил болон ялгаатай тал харагдаж байна.

Ижил төсөөтэй тал:

- Харьялах нутаг дэвсгэрийн айл өрх, албан газраар явж урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгдөг;
- Насанд хүрээгүй хүмүүст зөвлөн тусалдаг;
- Архидан согтуурахтай тэмцдэг;
- Гэмт хэрэг гарсан тохиолдолд хэргийн газрыг хамгаалдаг;
- Сэжигтнийг эрэн сурвалжилдаг;
- Бэртэж гэмтсэн, хохирсон хүмүүст тусалдаг;
- Гэмт хэргийг төв рүү мэдээлдэг;
- Сэжигтнийг баривчилдаг.

Ялгаатай тал:

- Оршин суугчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар заавар, зөвлөмж өгдөг;
- Кобан болон Чузайшогогийн үйл ажиллагааны талаар сонин гаргадаг;
- Ганц бие ахмад хүмүүсийн гэрээр очиж тусламж үзүүлдэг;
- Оршин суугчдын санал сэтгэгдэл, гомдлыг сонсож, асуудлыг шийдвэрлэх санал бодлоо солилцдог;
- Кабелийн телевизээр шуурхай мэдээлэл явуулдаг.

Дүгнэлт

ОХУ, БНХАУ, Япон улсын цагдаагийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа алба хаагчдын явуулж буй үйл ажиллагааны зарим туршлагыг манай хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой байна. Тухайлбал, ОХУ-ын цагдаагийн хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга тогтоодог, үйл ажиллагааны хамрах хүрээг хуулийн зүйл, заалтаар нь нарийвчлан тусгаж өгсөн, ажлын цагийн хуваарийг нарийн зааж өгсөн, БНХАУ-ын хорооны цагдаа нарын багаар ажилладаг, Японы Кобан, Чузайшогогийн цагдаа нарын хариуцсан нутаг дэвсгэрийн иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг туршлагуудыг дурдаж болно.

Санал

ОХУ, БНХАУ, Япон улсын цагдаагийн анхан шатны нэгжид ажиллаж байгаа алба хаагчдын зарим туршлагыг практикт нэвтрүүлэх, турших зорилгоор дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

ОХУ-ын цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн зарим туршлагыг практикт нэвтрүүлж туршиж үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга тогтоодог;
- Шалгах зөрчлийн хязгаарыг тогтоодог;
- “Хэсгийн байцаагчийн туслах” албан тушаалтан ажиллуулдаг;
- “Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбар” ажиллуулдаг;
- Цагдаагийн хэсгийн байцаагчийн “Нэрийн хуудас”-аар дамжуулан мэдээллээ дамжуулдаг;
- Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамаарах этгээдүүдийг тусгайлан зааж өгдөг зэрэг туршлагуудыг практикт нэвтрүүлж туршиж үзэх.

БНХАУ-ын цагдаагийн хэсэг дээр багаар ажиллах зохион байгуулалтын туршлагыг практикт нэвтрүүлж туршиж үзэх.

УСАН ХӨӨРӨГТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АШИГЛАХ АРГАЧЛАЛ

Ш.Чулуун

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн байгууллагаас усан хөөрөгт машиныг хэрхэн ашиглах аргачлал, анхаарах асуудал, усан хөөрөгт машины бүтэц, онцлог, зохион байгуулалтын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Усан хөөрөгт машин, багийн ахлагч, оператор, усан хөөрөгч, механик жолооч, техникч, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, эрх зүйн зохицуулалт.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед түүнийг албадан тараах болон хууль бусаар зохион байгуулж байгаа жагсаал цуглааныг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан тараах үедээ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна.

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна. Үүнд:

1/Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодисыг хэлнэ. /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно./

2/Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч:

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодисыг хэлнэ.

3/Усан хөөрөг:

Усыг өндөр даралтаар хүчтэй цацах төхөөрөмжийг¹²⁴ хэлнэ.

4/Утаан хөшиг үүсгэгч:

Үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно./

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг Цагдаагийн албаны тухай хуулинд¹²⁵ дараах тохиолдолд хэрэглэхээр зааж өгчээ. Үүнийг тодотгон авч үзвэл:

- Цагдаагийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар бүлэглэн довтолсон, эсэргүүцсэн;
- Төрийн тусгай хамгаалалтад байгаа, эсхүл бусад байгууллагын хамгаалалтад байгаа хүн, объектод бүлэглэн халдсан, халдахыг завдсан;
- Бусдын орон байр, эзэмшил газрыг бүлэглэн эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;
- Хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох гэмт хэргийг бүлэглэн үйлдэж байгааг таслан зогсоох, баривчлах;
- Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн бүлэг зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;
- Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал цуглааныг албадан тараах;
- Бүлэглэн оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг баривчлах;
- Хорих анги, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүссэн үед гэж тус тус нарийвчлан тусгажээ.

¹²⁴ Цагдаагийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх заалт

¹²⁵ Цагдаагийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалт

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг цагдаагийн байгууллагын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан¹²⁶ гаргаж дараах журмаар хэрэгжүүлнэ.

- Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хэрэглэх хүрээ, дэс дараалал, эхлэх, дуусгах шийдвэрийг гаргах;
- Цагдаагийн алба хаагчийг хамгаалах тусгай хэрэгслээр хангах;
- Цаг хугацааны хувьд боломжтой бол прокурорт урьдчилан мэдэгдэх;
- Эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэх;
- Уг хэрэгслийн нөлөөлөх бүсэд байгаа жирэмсэн эмэгтэй, насанд хүрээгүй этгээдийг тухайн бүсээс холдох талаар тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө анхааруулах;
- Боломжтой бол тухайн тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар анхааруулах;

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргадаг албан тушаалтан нь дараах үүргийг хүлээнэ.¹²⁷ Үүнд:

- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх хуульд заасан үндэслэл байгаа эсэхийг магадлан, тусгай хэрэгсэл хэрэглэх зорилгыг тодорхойлох
- Цаг агаарын байдал, салхины чиглэлийг харгалзан хэрэглэх тусгай хэрэгслийн төрөл, тоо хэмжээ, хүрээ, дэс дараа, тактикийг тогтоох
- Тухайн орчинд байгаа хүмүүст амьсгал боогдуулах, нулимс асгаруулагч, усан хөөрөг зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх гэж байгааг сануулж, тарж явахыг анхааруулах
- Алба хаагчдыг хамгаалах тусгай хэрэгслээр хангаж олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн бүсэд оруулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай прокурорт мэдэгдэж, бичгээр танилцуулах
- Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн үйлчлэлээр нүд аргаж өвдөх, нулимс асгарах, амьсгаа давхцах шинж тэмдэг илэрч, амьсгалын замын багтраа өвчин, зүрхний эмгэг өвчтэй хүнд онцгой нөлөөлөх тул эмнэлгийн байгууллагын туслалцааг нэн даруй авах

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой аргыг хэрэглэнэ. Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

Олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа хэрэглэх шийдвэрийг гаргасан цагдаагийн байгууллагын дарга, эсвэл түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдсан албан тушаалтан нь холбогдох байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.¹²⁸ Үүнд:

- Хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон аюултай бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох;
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах;
- Орчныг ариутгах арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;
- Тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, явц, үр дүн, хүний эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан тухай дэлгэрэнгүй илтгэх хуудсыг нэн даруй бичиж шууд захирах даргад, шууд захирах дарга нь дээд шатны байгууллагын даргад танилцуулсан байна.¹²⁹

¹²⁶ Цагдаагийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалт

¹²⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан А-224/А-102 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4 дүгээр хэсгийн 4.2 дахь заалт

¹²⁸ Цагдаагийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.6 дахь заалт

¹²⁹ Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ., 2019. 81 дэх тал

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг холбогдох албаны даргын тушаалаар томилогдсон дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.¹³⁰

- Багийн ахлагч: Шуурхай удирдлагын штабын даргын шийдвэр, тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн даргын удирдлагад ажиллаж, багийн үйл ажиллагааг удирдана.
- Усан хөөрөгч: Усан хөөргийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Оператор: Дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Техникч: Нулимс асгаруулагч, будагч бодис, усаар цэнэглэх, усны хоолойг холбох, салгах болон нөөц жолоочийн үүрэг гүйцэтгэнэ.
- Механик-жолооч: Машины техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана гэж тус тус заасан байна.

Багийн гишүүд бусад гишүүдийн үүргийг орлон гүйцэтгэх ур чадварыг эзэмшиж багаар ажиллах чадвартай байна. Багийн гишүүд болон нөөц хүчийг сард нэгээс доошгүй удаа сургалт, дадлага хийлгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн бүхээгт багийн гишүүдээс өөр хүн оруулахыг хориглоно. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг хамгаалалтын бүсийн дотор, гадна талд байрлуулж хэрэглэнэ. Усан хөөргийг жагсаал, цуглааны үед ашиглах тохиолдолд техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангах үүднээс хамгаалалтын тусгай бүлэг томилж ажиллуулна.

Усан хөөргийг +1°C хэмээс дээш дулаантай тохиолдолд ашиглана. Энэ нь усан хөөргөөр тоноглогдсон тээврийн хэрэгслийн бусад төхөөрөмжийг ашиглахад хамаарахгүй. Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн тасралтгүй ажиллагааг хангах ус тээвэрлэгч нөөц тээврийн хэрэгслийг цагдаагийн хамгаалалтад бэлэн байрлуулсан байна.¹³¹

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа газарт ойр байгаа усны эх үүсвэрийг ашиглаж болно. Усан хөөрөгт хуягласан тээврийн хэрэгслийн түрэх төхөөрөмжийг зам чөлөөлөх, учрах саадыг арилгах, гудамж гаргах болон бусад зориулалтаар ашиглаж болно.

Усан хөөрөгт тээврийн хэрэгсэл, түүний бүлгийн ахлагч болон операторыг тус бүрд нь хэт богино долгионы радио станцаар хангасан байна. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, будагчийг агаарын температур -10°C хэмээс дулаан үед хэрэглэнэ¹³² гэжээ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийн үзүүлэлт, хүчин чадал

“Jinjin”-усан буу нь (JRS-6500) хөнөөлт бус өндөр үр дүнтэй нь батлагдсан нийтийн эмх замбараагүй байдал, хууль бус жагсаал, цуглааны үед ашиглах төхөөрөмж юм.



Энэ авто машин нь хамгаалалтын болон шийдвэрлэх үед тусламж үзүүлэх зориулалттай юм. Усан буу нь өндөр даралтат насосоор тоноглогдсон ба засвар үйлчилгээ хийх үед хялбар салгагдана.

Дээврийн буунууд нь хэвтээ чиглэлд 340 градусаар, босоо чиглэлд 80 градусаар дээд тал нь 60 метр дотор хүчтэй буудна. Кабин дотор 5 хүний багтаамжтай ба бүх тоног төхөөрөмжийг тэд ажиллуулах бололцоотой байдаг.

¹³⁰ Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019. 123 дахь тал

¹³¹ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.13 дахь хэсэг

¹³² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 4.17 дахь хэсэг

Онцлог

Өндөр даралтат усан буу нь минутанд 2000 л/мин 14 бар-ын даралттайгаар шахах чадвартай. Уг машин нь дээрээ 6, баруун талдаа 3, зүүн талдаа 3, доод талдаа 4 ус болон бодис гаргах цорготой байна.

Кабин дээр байрлах буу нь автомат удирдлагаар дурын зүгт буудах чадвартай бөгөөд 6500 л багтаамжтай усны савыг түргэн хугацаанд дүүргэх ба юүлэх зориулалтаар тоноглогдсон юм.

Олон талын зориулалт бүхий уг автомашиныг бослого тараах, цэвэрлэгээ хийх, энгийн ард иргэдэд усны тусламж үзүүлэх зорилгоор хэрэглэж болох бөгөөд химийн /хөөс, нулимс асгаруулагч, будаг/ цацах боломжтой байдлаар мөн ашиглаж болно.

Бүрэн тоноглогдсон хяналтын самбараар хөдөлгүүрийн байдал, нэмэлт хөдөлгүүрийг хянахаас гадна бүх буу болон хавхлагуудыг хянах боломжтойгоос гадна түлхүүр багаж хийж болохуйц цоожтой хайрцагнуудтай.

Кабин дээрхи бууны хамт өндөр хүчин чадал бүхий гэрлээр давхар тоноглогдсон байдаг.

Ерөнхий тодорхойлолт¹³³

Тэнхлэг хоорондын зай	4650 мм
Нийт урт	7980 мм
Өргөн	2560 мм
Өндөр	3760 мм
Газраас хамгийн бага өргөгдсөн хэсэг	260 мм

Хүндийн жин

Цэвэр жин	9950 кг
Багийн гишүүд	325 /65*5/
Нэмэлт ачаа	6950 кг /ус, будаг, хөөс, хий/
Нийт жин	17225 кг

Өнгө

Чулуун саарал /stone gray/

Арал

Үйлдвэр	Tato Daewoo motor
Жолооны хүрд	Зөл талдаа
Хөдөлгүүр	DE 12TIS дизель, турботой, 6 цилиндртэй, усан хөргөлттэй 320hp/2100rpm
Дээд хүч	135 кг. м/1260rpm
Дээд эргүүлэх хүч	11051cc
Хөдөлгүүрийн багтаамж	

Гүйцэтгэл

Дээд хурд	99 км/ц
Хамгийн бага эргэх радиус	8.5 м
Хүч дамжуулга	Механик /урагш 6 ухрах 1/
Урд тэнхлэг/даац/	6500 кг
Хойд тэнхлэг/даац/	11500 кг
Дугуй	6 ш /11.00-20-16 pr
Обуд	7,5v*20
Хүрдний механизм	Гидро
Тормоз	Хийн
Түлшний савны багтаамж	200 л цоожтой, галаас хамгаалагдсан

¹³³ ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500B хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

Цахилгаан систем

Аккумулятор	12v-150amp/h*2
Динам	24v-60a
Стартер	24v-660kw

Кабин

Давхар кабинтай халдлагаас сэргийлж цонхыг торлосон хажуу болон дээд талыг хатуу гангаар хийсэн.

Камерын систем

Камер	Дижитал 220*22
Дэлгэц	7 инч өнгөт дэлгэц
DVR систем	500mb HD – тэй бичлэг хийх
	Арыг харах DSP 7 инч өнгөт дэлгэц
Р.А систем	Чанга яригч болон дуут дохиотой
Кабины хөргөлт	A/C хөргөлт
Аюулгүйн гарц	Дээрээ 2 хаалгатай

Усны сав

Материал	Ган төмөр /sts304/ 4.0мм
Гагнуур	Аргон болон хийн
Багтаамж	6500 л усны цалгилтаас хамгаалагдсан тоноглолтой

Цэвэрлэх зориулалт бүхий нүхтэй

Зөөлөвч	Резин ба төмөр
Савны нүх	500мм
Усны түвшин хэмжигч	Датчик болон харж болохуйц
Ус дүүргэх холболт	Эрвээхэй хавхлага 2-1/2"
Сорох холболт	Эрвээхэй хавхлага 4"
Ус гаргах хоолой	Бөмбөгөн хаалт 2"
Усны сав дүүргэх	Гол цөөрөм нуур

Хөөсний сав

Багтаамж	150л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Нулимс асгаруулагчийн сав

Багтаамж	150 л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Будагны сав

Багтаамж	150 л
Материал	Ган төмөр /sts316/ 3 мм
Хөөс дүүргэлт	Савны амсар хүртэл
Хөөс юүлэх хавхлага	Бөмбөгөн хавхлага $\frac{3}{4}$
Хөөсний түвшин үзэх	Датчик болон харж болохуйц

Төвөөс зугтаах насосны тодорхойлолт

/Centrifugal pump specification/

Төрөл	2 шаталбарт турбинтэй насос
Гүйцэтгэл	2650 л/мин 8,5 bar 2000 л/мин 14 bar
Материал	Хайлш гантөмөр хүрэл
Эргэх чиглэл	Цагийн зүүний дагуу
Насосны систем	4 тасалгаа бүхий вакуум
Ажиллах нөхцөл	Араагаар /gear box/
Хяналт	Цахилгаан
Хүчдэл	24 v

Насосны хөдөлгүүр

Төрөл	4 циклийн турботой усан хөргөлттэй Дизель
Цилиндер	4
Багтаамж	3907 cc
Гарах хүч	125 hp/2600rpm
Дээд эргэлтийн хүч	40кг.м/1800rpm
Эргэх чиглэл	Цагийн зүүний эсрэг
Стартер	24v-5kw
Хэрэглээ	24v

Хөөс, нулимс аргаруулагч, будагны системийн хэсэг

Төрөл	Цорго хэсэг
Материал	Ni-Cr
Гүйцэтгэл	410-1050 л/мин 5 bar
Ашиглалтын систем	автомат

Бууны систем

Кабин дээрхи буу/баруун тал/	LP-2-1/2"/65A/
Цорго /диаметр/	29мм
Цацах хүрээ	40м-60м
Эргэх хүрээ	Хэвтээ 340 градус босоо - 45 аас +80 градус
Байрлал	Кабин дээр
Удирдлага	Хяналтын самбараас

Буфер дээрхи буу

Гүйцэтгэл	1000 л/мин 5 bar
Цацах хүрээ	30м-40м
Эргэх хүрээ	Хэвтээ 180% босоо 40-с +80%
Хяналт	Хяналтын самбараас

Хэвтээ буу

Гүйцэтгэл	400 л/мин 5bar
Цацах хүрээ	20 м
Эргэх хүрээ	45 градус
Бууны тоо	2 ш
Байрлал	Хөдөлгүүрийн баруун, зүүн талд

Хамгаалалтын цорго

Цоргоны тоо	дээр 6 ш, доор 4 ш
Гүйцэтгэл	30 л/мин 5 bar
Материал	Хүрэл

Уг усан хөөрөгт тээврийн хэрэгсэл нь хуяглагдсан, тусгай тоноглолтой, дээд хэсэгт үндсэн 2 ширхэг шүршигч буутайгаас гадна урд гуперийн хэсэгт шүршигч буугаар

тоноглогдсон, 2 талын хажуу болон ар талдаа, мөн дээд доод хэсэгтээ 4 усаар шүршигч клапантай байдаг.

Кабин дээр нь 150 литрийн багтаамжтай 3 ширхэг савтай бөгөөд тус савнуудад нулимс асгаруулагч, хөөс, будаг холигч элементийг хийхэд усанд өөрөө найруулагддаг, усны ёмкост нь зэвэрдэггүй гангаар хийгдсэн бөгөөд 6.5 тонн усны багтаамжтай юм.

Хөдөлгүүр нь D6AV цуваа цилиндртэй, турбин дизель хөдөлгүүртэй. Шатахууны сав нь 200 литрийн багтаамжтай бөгөөд сайн түгжээ бүхий банк нь далд байрлахын зэрэгцээ галын аюулаас бүрэн хамгаалагдсан.

Кабин нь давхар кабинтайгаас гадна сайжруулсан төмрөөр хамгаалалт хийгдсэн, салхины болон хажуугийн шилнүүдийг торон хаалтаар хамгаалж тоногдосон байна.

Кабиндаа жолооч, хажуугийн туслах, ардаа 2 суудалтай, ТВ системтэй ба камер дүрс гаргах дэлгэц, дүрс бичлэг 24 цагийн турш хийгдэх боломжтой гэжээ.¹³⁴

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед усан хөөрөгт тээврийн хэрэгсэл ашиглах арга зүй

Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэнэ.¹³⁵

Цагдаагийн албан хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлэх явцад хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах, бүлэглэн танхайрах явдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл байдал бий болох, хориотой арга хэрэгсэл ашиглан төрийн төлөөлөгчийн тавьсан хууль ёсны шаардлагыг зэвсэглэн эсэргүүцэх зэрэгт ердийн арга хэрэгсэл ашиглан тодорхой үр дүнд хүрээгүй тохиолдолд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зохих журмын дагуу тухайн нөхцөл байдалд ялгамжтай байдлаар хэрэглэдэг байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийж бодит үндэслэл байгаа эсэхийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Түүнчлэн хүрээлэн байгаа орчин, эрсдэл бий болох нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлох, хэрэглэсний дараа гарч болох үр дагаврыг тооцоолон төлөвлөгөө гарган ажиллана.

Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулагдсан шуурхай удирдлагын штабын даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал идэвхижиж цагдаагийн байгууллага, алба хаагчийн тавьсан шаардлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнгээ өгөөгүй, хяналтаас гарах нөхцөл бүрдсэн тохиолдолд үймээнд оролцогчдын үйлдлийг цаашид даамжируулахгүй, учирч болох хор уршгийг нэмэгдүүлэхгүй байлгах, тэдний хууль бус үйлдлийг таслан зогсооход усан хөөрөгт машин ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалд¹³⁶ заасны дагуу +1 хэмээс дээш дулаан үед ажиллуулах бөгөөд ЦЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан "Шуурхай удирдлагын штаб"-аас өгсөн үүрэг, чиглэл, захирамж, шийдвэрийн дагуу ажиллагаанд оруулно.

Уг усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ажиллагаанд оруулах зорилго нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд оролцож буй алба хаагч, бүлгүүдийн

¹³⁴ ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500B хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

¹³⁵ 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шинэчлэн баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-504 "Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам"-ын 504-ийн 2 дахь хэсэг

¹³⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"

үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогч этгээдүүдийн хүчийг сарниан бутаргах, тарамдуулах, түүнчлэн Шуурхай удирдлагын штабын дэргэдэх түрэн гаргах, дайчлан баривчлах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байна.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг хэв журмын хамгаалалтанд зогсож байгаа цагдаагийн алба хаагчдын ар талд байрлуулж, жагсаал цуглаан болон эмх замбараагүй байдал үүсгэгчдийн бөөгнөрөл үүсч, нягтарсан хэсэг рүү дээврийн үндсэн бууг ашиглан 14-өөс дээш “bar”-ын даралтаар шүршиж, агшин зуур тараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн эмх замбараагүй байдал үүсгэж, цагдаагийн алба хаагчид руу дайрч, довтолж буй бүлэг этгээдүүдийн урд болон хажуу жигүүрээс нь усаар шүршиж, тэдний үйлдлийг сарниулж, хүчийг тарамдуулах арга хэмжээг тухайн нөхцөл байдлыг үнэлэн ажиллагааг удирдаж байгаа даргын шийдвэрээр түргэн шуурхай хийж гүйцэтгэнэ.

Гэхдээ ажиллагаанд оролцож байгаа бусад бүлгүүдийн үйл ажиллагаатай нарийн нягт харилцан уялдаатайгаар хэрэглэвэл үр дүнд хүрнэ.

Мөн эмх замбараагүй байдлын гол төв хэсэг рүү хүчтэй даралттай усаар шүршиж тараах бөгөөд сарнисан хэсгүүдийн хойноос дагаж шүрших байдлаар тэдний үйл ажиллагааг улам бүр тарамдуулах, улмаар дайчлан баривчлах, түрэн гарах бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

Гэхдээ усан хөөрөгт тээврийн хэрэгсэл усаа хурдан хугацаанд шахдаг учир нөөц усны машинууд байнгын бэлэн байдалд байж, түргэн хугацаанд шуурхай цэнэглэж, дараагийн ажиллагаанд орох нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм.

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг дараагийн ажиллагаанд хэрхэн шилжих үүрэг даалгаврыг гагцхүү шуурхай удирдлагын штабаас өгөх учир бүлгийн дарга болон гишүүд үүрэг, чиглэл иртэл бие даан ямар нэг ажиллагаа явуулахыг хориглоно.

Түрэн гаргах бүлгийн үүрэг бол нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд оролцогсдыг голомтоос түрэн гаргах, тараах, үйл ажиллагааг нь тарамдуулах, тараах явдал юм.

Тухайн эмх замбараагүй байдал гарсан бүс, нутаг дэвсгэрийн байршил, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, тухайн үеийн цаг агаарын байдлаас хамаарч тусгай хэрэгсэл хэрэглэх бүлэгт шуурхай удирдлагын штабаас өгсөн шийдвэрийн дагуу усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ашиглана.¹³⁷

Шуурхай удирдлагын штабаас шийдвэр гармагц тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн дарга усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ашиглан эмх замбараагүй байдлын нягтарсан цөм хэсэг рүү шүршилт хийж, тэдний хүчийг тарамдуулах, үйл ажиллагааг нь сарниулсны дараа түрэн гаргах бүлэг эхэлж орон дараа нь татан гаргаж, салган тусгаарлах бүлэг ажиллагаанд орж тэднийг тараах ажиллагааг гардан гүйцэтгэнэ.

Усан хөөрөгт 2 тээврийн хэрэгслийг эмх замбараагүй байдал үүсгэгчдийн 2 талаас нэгэн зэрэг, эсхүл нэг талаас нэгэн зэрэг шүршиж, хүчийг сарниулах, тарамдуулахыг уг ажиллагааг удирдаж байгаа шуурхай удирдлагын штабаас тандан судлах бүлгийн ирүүлсэн мэдээг үндэслэн шийдвэрлэнэ.

Нөгөө талаар 2 усан хөөрөгт тээврийн хэрэгслийг нэгэн зэрэг ашиглах тохиолдолд жагсаал, цуглаанд оролцогчид болон эмх замбараагүй байдал үүсгэгчдийн 2 жигүүрээс эсвэл төв хэсгээс усаар шүршиж, дундуур нь зүсэлт хийн довтолж, хоёр хэсэгт хуваан хүчийг сарниулсны дараа түрэн гаргах бүлэг хонгилоор довтолж, таслан хязгаарлах улмаар түрэн гаргах ажиллагааг явуулсны дараа татан гаргаж, салган тусгаарлах бүлэг, дайчлан баривчлах бүлгүүд ажиллагаанд орно.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь усан хөөрөгт тээврийн хэрэгслийг ашиглахдаа холбогдох хууль тогтоомжийг нарийн чанд баримтлан түүнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах нь учирч болох аливаа сөрөг үйлдлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ болох юм.

Мөн усан хөөрөгт тээврийн хэрэгслийн багийн бүрэлдэхүүний сургалт, дадлагыг тухай бүр чанартай зохион байгуулж багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, усан хөөрөгт тээврийн

¹³⁷ Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019.129 дэх тал

хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг сайтар сахиулж албанд мөрдлөг болгон хэвшүүлэх шаардлагатай.

Ингэснээр усан хөөрөгт тээврийн хэрэгслийн багийн бүрэлдэхүүний ажиллагаа болон усан хөөрөгт тээврийн хэрэгслийн албаны бэлэн байдал сайтар хангагдаж үндсэн чиг үүргээ зохих ёсоор биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх юм.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж:

- Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017
- ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-504 “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журам” 2017.12.28

Хоёр. Сурах бичиг, гарын авлага

- Ш.Чулуун. “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ., 2019
- ЦЕГ-ын автобаазын инженер техникийн албаны 2009 онд JRC-6500В хуягт, усан хөөрөгний авто машин хүлээн авсан, шалгасан тухай үзлэгийн тэмдэглэл

ОРГАНИЗАЦИЯ КОНТРОЛЯ ЗА ПОВЕДЕНИЕМ УСЛОВНО ОСУЖДЕННЫХ ОРГАНАМИ ПОЛИЦИИ МОНГОЛИИ

*А.Баасанцэрэн
Адъюнкт Омской академии МВД России
полковник полиции*

Аннотация: В статье рассматриваются вопросы осуществления контроля за поведением условно-осужденных в Монголии. Автор раскрывает цель контроля, а также функции контролирующих органов, нормы контроля или правила процедуры, обеспечивающие деятельность органов полиции при осуществлении контроля за поведением условно осужденных.

Ключевые слова: Административного контроля, контролю за поведением условно осужденных, функции контроль, осуществлении контроля.

В Монголии за последние пять лет было осуждено 40069 человек, из них 15483 человека, или 38,6% всех осужденных, применение наказания условно, из них 148 (0,95%) совершили преступление повторно¹³⁸. В 2014 г. из общей численности осужденных (8178 человек) были осуждены условно 3396 (41,5%), из них 88 (2,6%) повторно совершили преступление во время испытательного срока. Статистические показатели свидетельствуют о ежегодном увеличении числа условно осужденных, повторно совершивших преступление.

Эффективность исполнения условного осуждения напрямую зависит от своевременности и целенаправленности деятельности соответствующих государственных органов по контролю за поведением условно осужденных. Осуществление процесса исправления осужденного возможно только на основе реального взаимодействия всех субъектов, участвующих в исправительно-воспитательном процессе.

Монгольский ученый Ж. Долгорсурэн указывает, что основная цель контроля должна быть направлена на обеспечение всеобщего соблюдения общественного порядка, принятие юридической ответственности для лиц, виновных в нарушении законодательства¹³⁹.

Сегодня одной из причин повторного совершения новых преступлений условно осужденным во время испытательного срока становится, скорее, не слабая помощь и поддержка со стороны рабочего коллектива и общества, а недостаточность внимания органов полиции и правоохранительных органов к проведению профилактики совершения преступлений. условно осужденными это связано с большой загруженностью сотрудников полиции. Например, на одного участкового инспектора отдела управления полиции г. Улан-Батора за один месяц в среднем приходится участковые в расследований 4-6 уголовных дел легкой и средней тяжести а более 10 материалов административных расследование. Это и другие обстоятельства свидетельствуют о нехватке сил, средств и времени для организации профилактических работ с условно осужденными.

Помимо основных работ по контролю соблюдения гражданами общественного порядка, органы полиции выполняют различные функции, установленные законодательством страны, в том числе осуществление административного контроля за поведением и исправлением условно осужденных. Сущность контроль заключается в применении полномочий органов полиции согласно законодательству и отличается от различных видов административного надзоров. Например, полномочия органов полиции ограничиваются вызовом условно осужденных один раз в месяц и регистрацией их явки, участковый инспектор имеет только право регистрации и из-за большой нагрузки фактически не успевает организовать каждый месяц встречи с условно осужденными.

При этом контроль за указанными лицами, ограничивающий в определенной степени права и свободы человека, занимает особое место административно-профилактических принудительных мерах.

¹³⁸ По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2010-2014 гг.

¹³⁹ Долгорсурэн Ж. Монгол улсын Цагдаагийн эрх зүй: учебное пособие. Улан-Батор, 2004. С. 251 (на монгольском языке).

Правовые основы участия работников органов полиции в осуществлении контроля за поведением условно осужденных определены Законом Монголии от 05 июля 2013 г. «О полицейской службе»¹⁴⁰, Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии»¹⁴¹, Законом Монголии от 05 декабря 1997 г. «О профилактике преступлений.»¹⁴².

Порядок осуществления контроля за поведением условно осужденных в течение испытательного срока определен Правилами отбывания уголовных наказаний осужденными, которые утверждены приказом начальника Генерального управления полиции Монголии от 19 июня 2012 г. № 352 (Код № 619) «Об осуществлении контроля за условно осужденными и несовершеннолетними, совершившими преступление»¹⁴³.

Специфика этой деятельности заключается в том, что контроль осуществляется: 1) за лицами, освобожденными из мест отбывания наказания, 2) лицами, условно осужденными, 3) лицами, приговоренными к отсрочке срока наказания.

На наш взгляд, подобная ситуация не может способствовать повышению эффективности контроля за поведением условно осужденных со стороны органов исполнения судебных решений и органов полиции. Ведь именно на начальном этапе в отношении осужденного необходимо интенсивное воспитательно-профилактическое воздействие, обеспечивающее действенность контроля в последующем.

Деятельность органов полиции по контролю за поведением условно осужденных организуется на основе взаимодействия с администрацией предприятий, учреждений и организаций, в которых работают осужденные, органами местного самоуправления, прокуратуры, судами и общественными объединениями, осуществляемого путем проведения совместных мероприятий, обмена информацией и т.д.

В отношении условно осужденных, на которых судом возложены обязанности, связанные с их работой, учебой или лечением от алкоголизма, наркомании, токсикомании или венерического заболевания, органом полиции направляется сообщение администрации организаций, учебных заведений и соответствующих лечебных учреждений.

После постановки на учет условно осужденный вызывается в орган полиции для проведения беседы, в ходе которой разъясняются его обязанности, последствия их невыполнения и ответственность за нарушение общественного порядка или совершение нового преступления, уточняются и проверяются анкетные данные, выясняются сведения о близких родственниках и лицах, которые могут оказывать влияние на осужденного, а также другие вопросы, имеющие значение для осуществления контроля за его поведением.

Исходя из этого, следует сделать вывод о том, что органам полиции в дальнейшем невозможно осуществить контроль только своими силами, так как потенциал и ресурсы органов полиции остаются недостаточными.

Одним из недостатков деятельности органов полиции по контролю за поведением условно осужденных является отсутствие в контрольных делах планов работы. Зачастую совместная деятельность участкового уполномоченного заключается в организации и проведении первоначальной проверки по месту жительства сразу же после получения приговора из суда.

Несмотря на установление правовых процедур осуществления контроля в статье 15 «Об административном контроле условно осужденных и некоторых категорий осужденных» закона Монголии «О профилактике преступлений», в статье 10 «О некоторых судебных решениях, выполняемых органами полиции» закона Монголии «Об исполнении судебных решений», контроль органами полиции осуществляется не в полной мере. Она не может самостоятельно организовать общие и индивидуальные меры профилактической работы, организует только меры, запланированные руководством, и выполняет указания, поступившие

¹⁴⁰ Закон Монголии от 05 июля 2013 г. «О полицейской службе» / официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

¹⁴¹ Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии» / официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

¹⁴² Закон Монголии от 05 декабря 1997 г. «О профилактике преступлений» / официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.

¹⁴³ Сборник действующие нормативно-правовые акты деятельности органов полиции Монголии 2013 г. С.444.

сверху, что ограничивается мероприятиями по осуществлению контроля, охватывающими общество в целом 3-4 раза в году.

Для совершенствования осуществления административного контроля органами полиции необходимо принять следующие меры:

1.Повысить уровень квалификации участковых инспекторов по осуществлению профилактических работ по отношению к условно осужденным, находящимся под административным контролем.

2.Снизить рабочую нагрузку участковых инспекторов путем уменьшения численности населения на одного участкового за счет увеличения их контингента в зависимости от специфики районов, городов и сельской местности.

3.Организовать разделение труда участковых инспекторов, чтобы некоторые из них только проводили мероприятия профилактической работы с условно осужденными вместо расследования уголовных дел и принятия решений по заявлениям и жалобам граждан.

4.Совершенствовать контроль за поведением условно осужденных, направлять основную деятельность сотрудников правоохранительных органов на индивидуальные консультации и профилактическую работу.

5.Применять современные информационные технологии в концепции осуществления контроля за поведением условно осужденных с привлечением дополнительных сил и средств взаимодействующих сторон, с применением электронного мониторинга условно осужденных, что позволит систематизировать факторы, определяющие повышение эффективности деятельности полиции Монголии в сфере противодействия повторным преступлениям условно осужденных.

Для снижения количества повторных преступлений необходимо совершенствовать законодательную регламентацию контроля за поведением условно осужденных, правовые акты, регулирующие отношения с условно осужденными, совершенствовать контроль за поведением условно осужденных, повысить степень социальной защищенности и уровень профессиональной подготовки работников органов полиции, которые контролируют исполнение условного осуждения.

Литература:

1. Уголовный кодекс Монголии от 03 декабря 2015 г. /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
2. Уголовный кодекс Монголии от 03 января 2002 г. /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
3. Закон Монголии от 05 июля 2013 г. «О полицейской службе» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
4. Закон от 16 января 2014 г. «Об исполнении судебных решений Монголии» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
5. Закон Монголии от 05 декабря 1997 г. «О профилактике преступлений» /официальный сайт Министерства юстиции Монголии // www.legalinfo.mn.
6. Постановление Президиума Верховного Народного Хурала МНР от 18 октября 1968 г. № 216.
7. Указ Совета Министров МНР от 1985 г. № 95.
8. Приказом начальника Генерального управления полиции Монголии от 19 июня 2012 г. № 352 (Код № 619).
9. Уголовно-исполнительное право: учебник и основные нормативные акты / под ред. О. В. Филимонова. М., 2007.
10. Уголовно-исполнительное право: учебник: в 2 т. Т. 2: Особенная часть / под ред. Ю. И. Калинина. Рязань, 2006.
11. Даль В. И. Толковый словарь живого великорусского языка. М., 1999. Т. 2.
12. Долгорсүрэн Ж. Монгол улсын Цагдаагийн эрх зүй:учебное пособие.Улан-Батор, 2004 (на монгольском языке).
13. Хурэлбаатар Т. Монгол улсын Цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгүүд: учебное пособие. Улан-Батор, 2011 (на монгольском языке).
14. Большая юридическая энциклопедия. М., 2010. Т. 2.
15. По статистическим данным Центра статистики и информации Верховного Суда Монголии в 2010-2014 гг.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ АЛБАДАН СУРГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

Ц.Алтанцэцэг
Хуульч, дэд профессор
С.Эрдэнэболор
Хуульч, докторант
О.Хишигмөнх
Хуульч, докторант

Товч агуулга. Монгол Улс дахь албадан сургалтын өнөөгийн байдал, түүний эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг. Албадан сургалт, эрх зүйн зохицуулалт, гэмт хэрэг, зөрчил, ял, шийтгэл, албадлагын арга хэмжээ.

Удиртгал

Нийгэмд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх тусам хүний эрхийн зөрчил нэмэгдэх хандлагатай байдаг. Хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад үр дүнтэй хариуцлагын механизм чухал үүрэгтэй. Ардчилсан, хүмүүнлэг иргэний нийгэмд амьдарч буй хүн бүр эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд сэргээх эрхтэй, төр нь хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцдаг. Энэ үүргийнхээ дагуу гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн үйлдлийн хор уршиг, сэдэлд нь тохирох хууль зүйн хариуцлага хүлээлгэх нь гэмт хэрэг, зөрчил буурах, улмаар хүний эрхийн зөрчил багасахад нөлөөлөх учиртай.

Судлаачид гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд сургалтаар дамжуулан сэтгэл зүйд нөлөөлөх нь хамгийн үр дүнтэй арга гэдэгтэй санал нийлдэг. Дэлхий нийтийн чиг хандлагад хүн нь оршихын тулд мэдэх, хийх, хамтрах зайлшгүй шаардлагатай бөгөөд эдгээрийг тухайн этгээдэд тохирсон сургалтын хөтөлбөрөөр дамжуулж олгож байна.

Монгол Улсад хуульд заасан тодорхой төрлийн зөрчил, гэмт хэрэгт албадан сургалтыг явуулахаар хуульчилж, зохих байгууллагууд хэрэгжүүлж байна. Албадан үүрэг хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь бусад албадлагатай харьцуулахад хожуу хуульд тусгалаа олсон ба эд хөрөнгө хураах, эрх хязгаарлах зэрэг албадлагаас илүү нөлөөтэй байх боломжтой гэдгээрээ давуу талтай.

Хуульд заасан зан үйлд нөлөөлөх сургалтыг сайн дурын болон албадан гэсэн хоёр төрөлтэй байхаар зохицуулсан боловч практикт албадан сургалт нь давамгайлж байгаа нь гэмт хэрэг, зөрчил гарсны дараа зан үйлийг засах, өөрчлөх оролдлого хийж байгаа нь анхаарах шаардлагатай асуудал юм. Сайн дурын сургалтын эрх зүйн орчин явуулах боломжийг бүрдүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал үүрэгтэй. Гадаадын зарим улсын туршлагаар албадан сургалтыг сайн дурын сургалттай хослуулах нь илүү үр дүнтэй гэж үздэг. Монгол Улсад албадан сургалтыг баривчлах байранд цагдаагийн байгууллага, хорих ангид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрсдийн нөөц боломждоо тулгуурлан зохион байгуулж байгаа боловч албадан сургалт явуулах гэмт хэрэг, зөрчлийн төрөл тус бүр дээр сургалтын зорилгод нийцсэн хөтөлбөр дутагдалтай байна. Иймээс сургалтад хамрагдаж буй этгээдийн үйлдсэн зөрчил, гэмт хэргийн төрөл, шинжээс хамааруулан ялгамжтай хөтөлбөр боловсруулан мөрдөх шаардлагатай байна. Албадан сургалт явуулна гэж заасан зөрчил, гэмт хэргийн төрөл болон согтуурсан, мансуурсан, зан төлвийн доголдолтой эсэхээс нь хамааруулан ялгамжтай сургалтыг зохион байгуулах нь муу зуршлаа орхих, асуудлыг хүчээр бус эв зүйгээр шийдвэрлэхэд дэмжлэг болох юм.

Албадан сургалтын тухай ойлголт, төрөл

Гэмт хэрэг болон зөрчил үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх зорилгоор баривчлагдсан болон хоригдох хугацаанд эрх бүхий байгууллагын шийдвэрээр зан үйлд нь нөлөөлөх болон мансуурах, согтуурах зуршлыг нь засахаар албадан сургалтыг зохион байгуулж байна.

Албадан сургалт нь эрх зүйн буюу төрийн албадлагын нэг төрөл болохын хувьд албадлагын ойлголтыг авч үзэх шаардлагатай. Төрийн албадлагын арга хэмжээг албадан хангах арга хэмжээ болон албадан хамгаалах арга хэмжээ гэж ангилдаг.¹⁴⁴ Албадан хангах арга хэмжээнд эрх зүйн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон байцаан шийтгэх албадлага¹⁴⁵ хамаардаг.

Албадан сургалт нь үүрэг хүлээлгэх албадлагын нэг төрөл юм. Албадан сургалтаар дамжуулж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдүүдийн зан үйлийг засах, өөрчлөх нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хэлбэр төдийгүй эрх зүйн боловсрол олгож буй хэрэг юм. Аливаа сургалт нь хүний хөгжин төлөвших, хөгжүүлэх үйлчилгээ болохын хувьд бие хүн болж төлөвших үйл явцад нөлөө үзүүлэх байдлаар илэрдэг. Боловсролын үйлчилгээг сургалтаар дамжуулан хувь хүнд хүргэдэг. Хуульд заасан албадан сургалтыг боловсролын судлагдахуун гэж үзэх боломжтой боловч албан болон албан бус сургалтын аль нэгэнд нь шууд хамааруулан үзэх талаар тодорхой зохицуулалт болоод онолын ойлголт хомс байна.

Албан боловсролыг боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа болох тул энэхүү боловсролыг сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн үйлдвэрлэлийн төв, коллежоор олгодог. Харин албан бус боловсролыг албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтай үйл ажиллагаа буюу олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу хувийн хоршоолол, нийгэмлэг холбооны шугамаар зохион байгуулан албан бус замаар болгодог боловсрол¹⁴⁶ гэж үздэг.

Бие хүн өөрийнхөө дотоод ертөнцтэй болон гаднах ертөнцтэй харилцан үйлчилж, ажиллаж, амьдрах явцад хийж бүтээж, сэтгэн бодож байгаа үйл ажиллагаа бүхэн цаанаа шалтгаант холбоо бүхий сэтгэцийн ухамсарт бус үйлээр зан үйлээ зохицуулж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэж эрдэмтэн З. Фрейд үзжээ. Сэтгэц нь хүний бие махбодын ихэнх хэсэг. Сэтгэцийг мөсөн уултай зүйрлэвэл далайн түвшнээс дээш өчүүхэн төдий цухуйх оргил нь сэтгэцийн ухамсарт хэсэг, далайн түвшнээс доош үл харагдан байрлах мөсөн уулын хэсэг нь сэтгэцийн ухамсарт бус хэсэг юм. Иймээс хүний ухамсарт бус үйл нь хүний зан үйлийг зохицуулахад чухал үүрэгтэй. Хүний ухамсарт бус үйлээр өдөөгдсөн сонирхол, шаардлага, хэрэгцээг задлан шинжилсэнээр түүний хэвийн бус араншин, төрх байдал, зан чанар, шинж байдлыг тайлбарлах боломжтой¹⁴⁷ гэж үзсэнээс харахад хүн бүрт ухамсарт бус үйлийг судлах, түүнд нөлөөлөх арга замыг эрэлхийлэх нь зан үйлийг засахад чухал нөлөөтэй.

Онолын талаас нь судлаачид бие хүний зан үйл, төрх байдалд хүмүүсийн харилцаа чухал нөлөө үзүүлдэгийг Германы эрдэмтэн Карни Хорни “Бие хүний нийгэм соёлын онолоор “хүмүүсийн хоорондын харилцаа нь тухайн бие хүнд маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүний эрүүл мэнд болон невросыг илэрхийлдэг. Харилцааны ийм эерэг, сөрөг чанар нь хүний төрөлх чанартай холбоотой¹⁴⁸ болохыг судалжээ. “Зан үйлд нөлөөлөх” “зан үйлээ засах” гэх хоёр ойлголтуудыг тодруулвал: “Зан” (англи-character, орос-характер) Сэтгэлийн төлөвийн харьцангуй тогтвортой, төрмөл шинж, хүн амьтны аашлах төлөв байдал¹⁴⁹-ыг илэрхийлдэг бол “Зан үйл” (англи-behavior, орос-поведение) сэтгэлийн шинжийн хэлбэр, амьд амьтны гадаад орчин ба өөр хоорондоо харилцан үйлчлэлцэх явцад илрэх харш үйлдэл буюу үйл, үйлдлийн багц¹⁵⁰ юм.

¹⁴⁴ Ч.Нямсүрэн. “Эрх зүйн ерөнхий онол”. УБ., 2017., 358 дахь тал

¹⁴⁵ Ж.Долгорсүрэн. “Захиргааны хариуцлага”. УБ., 1998. 58 дахь тал

¹⁴⁶ Б.Батсайхан, М.Дэлгэржав. “Боловсрол судлалын тайлбар толь”. УБ., 2019. 5 дахь тал

¹⁴⁷ Л.Жамц. “Боловсрол судлалын үндэс”. УБ., 2017. 73 дахь тал

¹⁴⁸ Л.Жамц. “Боловсрол судлалын үндэс”. УБ., 2017. 76-77 дахь тал

¹⁴⁹ С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг”. УБ., 2011. 203 дахь тал, Я.Цэвэл “Монгол хэлний тайлбар толь”. УБ., 265 дахь тал “Зан нь хүн амьтны аашлах байдал төлөв” гэж тайлбарласан.

¹⁵⁰ С.Нарангэрэл. “Эрхзүйн эх тайлбар толь” УБ 2011 он 3 дахь хэвлэл

Хүний зан үйлийн илрэх хэлбэр, сэдэл зорилго, үр дагавар олон янз байна. Эрх зүйн нөлөөллийн хүрээнд буюу эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж хууль зүйн үр дагавар агуулж байгаа зан үйлийг эрх зүйн зан үйл гэнэ. Эрх зүйн зан үйл нь нийгмийн харилцаанд эерэг болон сөрөг байдлаар нөлөөлж байдаг. Эерэг зан үйлийг сайшаах, дэмжих, урамшуулах, сөрөг зан үйлийг албадлага хэрэглэж хориглох, хязгаарлах, хариуцлага хүлээлгэдэг. Эрх зүйн зан үйл нь хууль ёсны зан үйл ба эрх зүйн зөрчил, эрх зүйг зөрчсөн гэм буруугүй үйлдэл гэсэн төрөлтэй байна.¹⁵¹ Зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь эрх зүйн зарим зөрчил гаргасан этгээдийн эрх зүйн эсрэг үйлдэлд буюу эрх зүйн зөрчилд үндэслэн албадлага хэрэглэж буй үйл ажиллагаа юм.

Монгол Улс дахь албадан сургалтын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан тодорхой зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан сургалтад хамруулахаар заасан.

Аливаа ял шийтгэлийн нэн тэргүүний зорилго нь тухайн этгээдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх учраас зан үйлд нь нөлөөлөх албадан сургалтад хамруулж, сөрөг зан үйлийг засах, дахин давтан гэмт хэрэг, зөрчил үйлдэхгүй байхад нөлөөлөх юм. Ял шийтгэл нь хүний бие махбодид нөлөөлөхөөсөө илүү сэтгэл санаанд нь эерэг нөлөө үзүүлэх нь нийгэмд гарч буй зөрчил, гэмт хэргийг бууруулах ач холбогдолтой. Иймд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг явуулахад анхаарч хэрэгжилтэд ач холбогдол өгөх нь эд хөрөнгө хураах, торгох, хорих ялаас илүү үр нөлөөтэй байх боломжтой. Хүн төрөхөөсөө л гэмт хэрэгтэн байдаггүй, ямар нэг байдлаар олдмол шинжтэй, нийгмийн хүчин зүйл болоод бусад хүмүүсийн хандлага тодорхой хэмжээнд нөлөөлдөг гэж үздэг.

Албадан сургалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, холбогдох журмуудад¹⁵² заасны дагуу зохих шийтгэл оногдуулсан этгээдэд албадлага болгон хэрэглэж байна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг баривчлах шийтгэл оногдуулсан этгээдэд буюу баривчлах байранд явуулах албадан сургалт, хорих ялтанд буюу хорих байранд явуулах албадан сургалт гэж ангилж болно.

Баривчлах байран дахь албадан сургалт нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд 9 төрлийн 17 гэмт үйлдэл хийсэн этгээдийг албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр тусгагдсан байна.

Харин хорих байран дахь албадан сургалт нь дараах төрөлтэй. Үүнд:

- Монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд Монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдэд зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай ялтны зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулах.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 9.2-т сургалт тус бүрийн үргэлжлэх хугацаа, сургалтын нийт цаг /23-56 цаг/-ийг тус тус заасан. Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 4.5.3-т албадан сургалт нь арван цагаас тавин цагийн хугацаатай байна гэж заасантай зөрчилдөж байна. Тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн цаг хуулиар тогтоосон цагаас илүү байх нь хүний эрхийг зөрчих, төсөвт хүндрэл үүсгэх тул хуульд нийцүүлэн дээд хугацааг 50 цаг байхаар өөрчлөх шаардлагатай байна.

Эрүүгийн хуульд үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээнд зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах¹⁵³ гэж заасан. Зан үйлээ засах сургалт гэдэг нь сургалтын оролцогч төвтэй байна, зан зүйлд нөлөөлөх гэдэг нь сургалтыг хэрэгжүүлэгч

¹⁵¹ Ч.Нямсүрэн. “Эрх зүйн ерөнхий онол”. 2017. 337 дахь тал

¹⁵² Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг. “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт-II мониторингийн тайлан. УБ., 2019. 14-16 дахь тал

¹⁵³ Эрүүгийн хууль (2015 6.7.3.2.2)

байгууллага буюу багш төвтэй сургалт байна. Зан үйлд нөлөөлөх сургалт нь дараах төрөлтэй байхаар заасан.¹⁵⁴ Үүнд:

Сэтгэл зүйн сургалт:

- Архинд донтолт болон түүний хор уршгийн талаар ойлголт өгөх;
- Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах;
- Уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стрессийг даван туулах;
- Харилцах ур чадвараа дээшлүүлэх;
- Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх;
- Өөрийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хүчирхийллээс үүдэх хүүхдийн сэтгэл зүйн асуудал сөрөг үр дагавар;
- Гэр бүлийн сэтгэл зүйг төлөвшүүлэх.

Эрх зүйн сургалтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор явуулах бол бясалгалын сургалтыг эрх бүхий байгууллагын даргын тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна гэж заасан. Тухайн оролцогчийн зан үйлийн өөрчлөлтөд тохирсон сэтгэл зүйн сургалтыг эрх зүйн сургалттай хослуулан явуулна. Оролцогчийн хувийн байдал, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжийг харгалзан тэдний сэтгэл зүйн онцлогт тохирсон хэд хэдэн сургалтыг хослуулан явуулна. Сургалтыг хослуулан явуулахдаа хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болохоор тус тус зохицуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь сайн дурын болон албадан гэсэн хэлбэртэй¹⁵⁵ байхаар заасан. Одоогийн хууль тогтоомжид заасан албадан сургалтын төрлүүдээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд чиглэсэн албадан сургалтын эрх зүйн орчин зохих түвшинд бүрэлдсэн бол бусад төрлийн албадан сургалт явуулахтай холбоотой журам, хөтөлбөр дутагдалтай байна. Хорих байранд зохион байгуулагдах албадан сургалт нь шүүхийн шийдвэрийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зохион байгуулдаг. Сургалтын зорилгоос авч үзвэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас зохион байгуулж буй сургалт нь ялтаны зан үйлийг засах зорилготой.

Монгол Улсад дараах зөрчилд баривчлах байранд албадан сургалтыг албадлагын арга хэмжээ болгон явуулахаар зохицуулсан. Үүнд:

Зөрчлийн төрөл	Хориглосон үйлдэл	Шийтгэл
Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	Мансуурсан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Танхайрах	Олон нийтийн газарт, эсхүл орон байранд: -хэрүүл маргаан үүсгэж; -бусдыг өдөөн хатгаж; -бусдын амгалан тайван байдал алдагдуулж; -олон нийтийг үл хүндэтгэж; -үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн	Нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

¹⁵⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”-ын 8 дүгээр зүйлийн 8.1 дэх хэсэг

¹⁵⁵ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016. 44.1)

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон; -хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; -хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Хүүхдийн эрхийг зөрчих	Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Бэлгийн дарамт учруулах	Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн	Долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна
Хулгайлах	Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна
Хөрөнгө завших	Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн	Албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж зөрчих	Гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу зохих шийтгэл оногдуулсан этгээдэд албадлага болгон хэрэглэж байна. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг шүүхийн шийдвэрээр ял оногдуулахаас өмнө, ял оногдуулсан хоригдох хугацаандаа хамрагдах гэж ангилж үзэж болохоор байна.

Зөрчлийн тухай хуульд албадан сургалттай холбоотой харилцааг хуулиар зохицуулна¹⁵⁶ гэж заасан боловч Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар албадан сургалт явуулна гэж заагаагүй үйлдлүүд дээр албадан сургалт явуулж болно гэж зарим хуульд тусгасан нь хуульд

¹⁵⁶ Зөрчлийн тухай хууль (2017.4.5.4)

заасан үндэслэлээр хүний эрхийг хязгаарлана гэсэн хүний эрхийн суурь зарчимтай зөрчилдөж байна.

Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд 9 төрлийн 17 үйлдэлд зөрчил үйлдсэн этгээдийг албадан сургалтад хамруулах албадлага хэрэглэхээр тусгагдсан. Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн дараах 4 төрлийн үйлдэлд Зөрчлийн хуулиар албадан сургалтад хамруулахаар тусгасан байна.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг:

- Зодсон;
- Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан;
- Бусадтай харилцахыг хязгаарласан;
- Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болох зохицуулалтай.

Зөвхөн гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн судалгааг авч үзэхэд, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль мөрдөгдөхөөс өмнөх 2015-2016 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон захиргааны хариуцлагын тоо төдийлэн буураагүй байна. 2017 онд өмнөх онд 1886 байсан зөрчил 4369 болж огцом өссөн. 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 197, 2019 оны эхний 11 сард гэмт хэрэг 281 бүртгэгдсэн бол 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил 4270, 2019 оны 11 сарын байдлаар 8229 болж өссөн¹⁵⁷ үзүүлэлтэй байна. Энэ нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх бодит шаардлага байгааг харуулж байгаа юм.

Турк Улсад гэмт хэрэг үйлдсэн этгээдийг албадан сургалтад хамруулах ерөнхий хөтөлбөрөөр хэл, бичиг эзэмшүүлэх болон хөдөлмөрлөх дадал олгох сургалтыг тусгай хөтөлбөрөөр зан үйлд нөлөөлөх сургалтуудыг зохион байгуулдаг байна.¹⁵⁸ Харин Австрали улс нь албадан болон сайн дурын сургалтыг хослуулан хэрэгжүүлснээр үр дүнд хүрчээ. Албадан сургалтын гол үзэл баримтлал нь хандлагыг өөрчлөхгүйгээр үйлдэл өөрчлөгдөхгүй гэсэн агуулгад тулгуурладаг. Хувь хүний хандлага өөрчлөгдөөгүй байхад хичнээн удаан хориод, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх нь үр дүнгүй гэдэг нь эргэлзээгүй. Иймд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл болон бусад төрлийн үйлдэлд хүлээлгэх албадлагын нэг төрөл болох зан үйлд нөлөөлөх албадан сургалтын үр нөлөөтэй байдлыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой. Иймд сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд зайлшгүй явуулах албадан сургалтын төрөл тус бүрийн агуулга, зорилгод нийцсэн сургалтын хөтөлбөр, сургалт явуулах журмыг боловсруулах хэрэгцээ, шаардлага байна.

Дүгнэлт

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд зохих хуулиудыг шинэчлэн зөрчил, гэмт хэрэг үйлдэгчийн баривчлагдсан болон хорих ял эдлэх хугацаанд нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах, давтан зөрчил, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх улмаар асуудлаа эв зүйгээр шийдвэрлэхэд шаардлагатай хууль зүй, сэтгэл зүй, харилцааны мэдлэг, чадвар олгох замаар хандлагад өөрчлөлт оруулах хүмүүжлийн шинжтэй механизмыг хэрэглэх боломжтой болсон нь сайшаалтай юм.

Хорих ял болон баривчлах шийтгэл хүлээсэн этгээдийг нийтлэг байдлаар хамруулж гэмт хэрэг, зөрчлийн төрлөөс үл хамаарч гэмт хэрэгтэн, зөрчил гаргагч бүрт хамааралтай сургалт мэт хавтгайруулан ойлгогдох нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй байна. Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх бус нэгэнт зөрчил гаргасан этгээдэд сургалт явагдаж буй тул дахин тухайн төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын агуулгад чиглэх ёстой. Сургалтын зорилгоос сургалтын үр дүн тодорхойлогдох бөгөөд зорилго нь тодорхой зорилтод этгээд рүү чиглэсэн үр дүн нь тодорхой байхаар зохицуулагдах, сургалтад хамрагдах зорилтот бүлэг болон сургалтын чиглэл зорилгыг хуульд тодорхой заасан бөгөөд

¹⁵⁷ Хууль дээдлэх ёс сэтгүүл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” 2020 №1 цуврал 76 х.68-69

¹⁵⁸ <https://www.mevzuat.gov.tr/mevzuat?MevzuatNo=2324&MevzuatTur=21&MevzuatTertip=5>

ял эдлүүлэх байгууллагын зохион байгуулалт, ял ба урьдчилан сэргийлэх ажиллагааны дүрэм 86-91 дугаар зүйл.

үүнтэй нийцүүлэн хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох шаардлагатай байна. Иймд албадан сургалт тус бүр дээр тухайлсан журам баталж, сургалтын хөтөлбөр боловсруулах нь үр дүнтэй гэж үзлээ.

Зан үйлийг засах, өөрчлөх агуулга бүхий сургалт нь бусад сургалтаас ялгаатай, сургалтын хөтөлбөр, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн шаарддаг төдийгүй сургалтын зорилго, зорилтод хүрэх үр дүнгийн асуудал, зайлшгүй тавигдах учиртай. Албадан сургалтыг цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өөрийн нөхцөл, боломждоо тулгуурлан зохион байгуулан явуулж байна. Энэхүү сургалтыг зохион байгуулж байгаа практикаас харахад, сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын танхим, багшлах нөөц, чадавхи, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтыг үнэлэх арга, аргачлал дутмагаас шалтгаалж хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь сургалтыг зохион байгуулахад хэрэгцээтэй мэдлэг, мэдээлэл, орчин, нөхцөл хүний нөөц, чадавх, материаллаг бааз нь тухайн сургалтын үр дүнд шууд нөлөөлдөг тул гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн зан үйлд нөлөөлөх, зан үйлээ өөрчлөх, асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх хандлага төлөвшихгүй байна. Албадан сургалт нь бусад сургалтаас эрс ялгаатай сургалтын орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн шаарддаг сургалтын нэг төрөл юм. Иймд албадан сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад материаллаг бааз, боловсон хүчин, тохиромжтой сургалтын орчин нөхцөл, хэрэглэгдэхүүн дутах асуудлууд практик үүсч байгаа нь цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудал юм.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах¹⁵⁹ аар зохицуулсан. Тухайн зохицуулалт нь ямар төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд уг сургалтыг орох, ямар агуулга, хөтөлбөрийн хүрээнд орох нь орхигдсон байна.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд гэр бүлийн харилцаанд хүйсийн шинжээр шууд ялгаварлан гадуурхсан этгээдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулдаг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулж болно¹⁶⁰ гэж заасан. Гэтэл Зөрчлийн тухай хуульд шүүхийн шийдвэрийн дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж заасан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зөрчлийн бүрэлдэхүүнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.

Холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.6-т шүүхийн шийдвэрээр албадан сургалтыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгааллын чиглэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулна¹⁶¹ гэж заасан байна. Энэхүү сургалтын хөтөлбөрийг батлах байгууллага төсөв санхүүг шийдэх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг асуудал нь тодорхойгүй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сургалтын хөтөлбөрийн агуулгаар явуулж болох эсэх, сургалтаар хүлээгдэх үр дүн нь ижил эсэхийг тодорхой болгох шаардлагатай байна.

Ном зүй

Нэг. Хууль тогтоомж

- Эрүүгийн хууль. 2015
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 2016
- Зөрчлийн тухай хууль. 2017
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. 2011
- Хүүхэд хамгааллын тухай хууль. 2016

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага

- Б.Батсайхан, М.Дэлгэржав. “Боловсрол судлалын тайлбар толь” УБ., 2019
- Ж.Долгорсүрэн. “Захиргааны хариуцлага”. УБ 1998
- Л.Жамц “Боловсрол судлалын үндэс”. УБ., 2017
- С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг”. УБ., 2011
- Ч.Нямсүрэн. “Эрх зүйн ерөнхий онол”. УБ., 2017

¹⁵⁹ Эрүүгийн хууль (2015. 7.3.2.2)

¹⁶⁰ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011. 26.3)

¹⁶¹ Хүүхэд хамгааллын тухай хууль (2016. 18.2.6)

Гурав.Судалгааны тайлан, сэтгүүл

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам”, “Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр”
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, НҮБ-ын хүн амын сан, Швейцерын хөгжлийн агентлаг “Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт-II мониторингийн тайлан УБ., 2019
- Хууль дээдлэх ёс сэтгүүл. 2020. №1 /76/

ХОРИХ АНГИ, ЦАГДАН ХОРИХ БАЙРНЫ ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД ГАР СТАНЦНЫ ЧИХЭВЧ АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Б.Сандаг

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

Товч агуулга: Хорих анги, хорих байрны харуул хамгаалалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, албаны мэдээг түргэн шуурхай дамжуулах зорилгоор гар станцыг ашиглах үед мэдээллийн нууцлал алдагдахаас сэргийлэх үүднээс чихэвч хэрэглэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.

Түлхүүр үг: Радио станц, чихэвч, хорих анги, цагдан хорих байр.

Үндсэн хэсэг

Радио бол үзэгдэх гэрлээс доош давтамж бүхий цахилгаан соронзон долгионыг модуляцлан дохиог утасгүй дамжуулах технологи юм. Цахилгаан соронзон цацрагийн тархалт нь агаар буюу хоосон орон зайгаар тархах цахилгаан соронзон орны хэлбэлзлийг илэрхийлнэ.

Радио станц гэдэг нь тодорхой тохируулж өгсөн давтамжийг ашиглан өөр хоорондоо тодорхой зайнд харилцан холбогддог холбооны хэрэгсэл юм.

Радио станцийг дотор нь гар, суурин, машины болон дахин дамжуулах гэж ангилах бөгөөд эдгээр нь бүгд өөр өөрийн гүйцэтгэх үүрэг, онцлог шинж чанараараа ялгаатай.

Радио станцийг 1900 оны эхээр цэргийн болон худалдааны усан онгоцууд ашиглаж байсан телеграфийн холбооноос үүсэж хөгжсөн гэж үздэг бөгөөд анхны машины станц 1923 онд Австралийн Викториягийн цагдаагийн газар ашиглажээ. Түүнээс хойш улам боловсронгуй, загварлаг, хөнгөн авсаархан болж хөгжсөн бол дэлхийн 2 дугаар дайны үед гар станцууд (газар болон агаарын хооронд холбогддог) түлхүү хөгжсөн гэдэг.

2000 он хүртэл аналогои радио станц түлхүү хөгжиж технологийн шинэчлэл, хэрэглэгчийн хүсэлт шаардлагад нийцүүлсэн тоон технологи бүхий станцуудыг (DMR) 2007 оноос хөгжингүй улсууд ашиглаж эхэлсэн. Харин манай улс 2011 оноос тоон техникологийн радио станцуудыг түгээмэл ашиглаж эхэлсэн.

Олон улсын нисэх онгоцны буудал, төрийн үйлчилгээний салбарт ихэвчлэн TETRA (Terrestrial Trunked Radio) (Америк-д P25) системийн радио холбоог түгээмэл ашигладаг бөгөөд энэ системийн радио холбоо нь төрийн тусгай үйлчилгээнд илүү тохиромжтой нэгдсэн хяналт удирдлагын цогц систем юм..

Тоон системийн давуу тал:

- Ярианы чанар өндөр түвшинд боловсруулагддаг.
- Ярианы өндөр түвшний нууцлалтай. Гадны ямар ч төхөөрөмж сонсох, тагнах, саад хийх нөлөөлөх боломжгүй.
- Интернет сүлжээ ашиглан хөдөө, орон нутаг, мөн гадаад улстай ч холбогдож ярих, болон бусад мэдээлэл солицох боломжтой.
- Ганц яриа ч биш, текст мессэж, болон GPS-ын өгөгдөл болон бусад дата дамжуулах солилцох боломжтой.
- Халдлагаас хамгаалах болон станцийг зайнаас хаах нээх, сонсох удирдах зэрэг хяналтын олон функцүүдтэй.

Харуул хамгаалалтад станц ашиглаж буй байдал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төвлөрсөн хорих ангиуд, хорих байрны байнгын харуул хамгаалалтад ТК-278 маркийн хэт богино долгионы гар станц болон KENWOOD TH-79 маркийг гар станцыг албаны мэдээ, мэдээллийг түргэн шуурхай дамжуулах /таних нэр, нууц үг ашиглан/ чихэвчгүйгээр ашиглаж байна.

Тулгамдсан асуудал, эрсдэл:

Хорих анги, хорих байрны байнгын харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчид нь хоригдол, хоригдогч нарын дунд үүрэг гүйцэтгэж байдаг. Холбооны хэрэгсэл буюу гар станц нь нэг сүлжээнд ажиллаж байдаг учир албаны мэдээ, мэдээлэл бүх станцаар дамждаг, зарим албан хаагчид станцны дууны тохиргоог чанга тохируулсан байдаг учир мэдээ

мэдээллийг хоригдогч, хоригдол давхар сонсох, албаны мэдээ, мэдээллийн нууцлал алдагдах эрсдэл үүсэж байна.

Албаны мэдээ, мэдээллийг хоригдол сонссоноор доорх эрсдэлт нөхцөл байдал үүснэ.

Үүнд:

- Албаны хэвийн үйл ажиллагааны эсрэг гэмт санаа төлөвлөх;
- Хоригдол, хоригдогч нарын дунд үл ойлголцол бий болох;
- Албан хаагчдын зүгээс харилцааны зөрчил гаргах;
- Албан хаагчдын аюулгүй байдалд халдах;

Шийдвэрлэх арга зам:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, хорих байрны харуул хамгаалалтын үйл ажиллагаанд түгээмэл ашиглаж буй ТК-278 маркийн хэт богино долгионы гар станц болон KENWOOD TH-79 маркийн гар станцанд чихэвч ашиглах нь зүйтэй. Гар станцны чихэвч 10000-18500 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд үүнийг төсвөөс шийдвэрлэх бүрэн боломжтой болох нь харагдаж байна.

Дүгнэлт

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын нэг болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны нэг чиглэл бол хоригдлыг нийгмээс тусгаарлах, тэднийг үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас хамаарч нээлттэй, хаалттай хорих анги, хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдлүүлэх явдал юм.

Харуул хамгаалалтын албан хаагчдын холбооны хэрэгслээр думжуулах мэдээ мэдээллийн нууцлалыг хангахад гар станцанд чихэвч ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал

1.ШШГЕГ-ийн харьяа хорих анги, хорих байрны харуул хамгаалалтын албан хаагчдыг стандартын шаардлага хангасан чихэвчээр хангах;

2.Харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ гар станцад чихэвч ашиглах заавар боловсруулж, мөрдүүлэх;

3.Гар станцад чихэвч ашиглах видео сургалт зохион байгуулах.

ШИНЖЛЭН МАГАДЛАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХӨРС СУДЛАЛЫГ ГЭМТ ХЭРЭГ ИЛРҮҮЛЭХЭД АШИГЛАХ НЬ

Б.Номин

*ДХИС-ийн Шинжлэн магадлахуйн институтийн Байгалийн ухаан,
техник зүйн шинжилгээний тэнхимийн багш, докторант,
цагдаагийн хошууч*

Товч агуулга. Гэмт этгээдүүдийн гэмт хэрэг үйлдэх, мөрөө нуун далдлах арга заль улам нарийсч буй хирээр хэргийн газраас эзэн холбогдогчийг шууд тодорхойлон заах ул мөр, эд мөрийн баримт олдох нь цөөрч байна. Иймд гэмт хэрэг илрүүлэх чиг үүрэг бүхий хууль сахиулах салбарын албан хаагчид гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн шалгах, ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, шинжлэн тогтоох арга зүй, техник, технологийг боловсронгуй болгох, шинэ арга, аргачлалыг туршин судлаж нэвтрүүлэх нийгмийн зайлшгүй шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг. Хөрс, хөрсний бүтэц, хөрс судлалын шинжилгээ, шинжилгээний арга зүй, ач холбогдол.

Оршил

Гэмт хэргийн газарт түгээмэл үлддэг ул мөрийн нэг бол хөлийн мөр юм. Хөлийн мөрийн ерөнхий шинж тэмдгээр тухайн гэмт этгээдийн биеийн онцлог, өмссөн гутал, явсан чиглэл зэргийг тодорхойлох боломжтой боловч тухайн гутлын мөрийн хувийн онцлог шинж тэмдэг тодорхой сайн гараагүй бол сэжигтэн этгээдийн өмсөж явсан гуталтай харьцуулан тогтоох боломжгүй юм.

Сэжигтний гутлын мөрөөс өөр ул мөр илрээгүй тохиолдолд ерөнхий шинж тэмдгээр нь тухайн сэжигтний гутлын ултай ижил эсэхийг л тогтоож болно. Тэгвэл сэжигтэн этгээдийн гутлын уланд шигдэж үлдсэн хөрс, шорооны дээжээр тухайн хэргийн газарт байсан эсэхийг хөрс судлалын шинжилгээгээр тогтоох боломжтой юм.

Энэхүү шинжилгээ нь зөвхөн гутлын мөрөөр хязгаарлахгүй бөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгсэлийн явагч хэсэг, дугуй болон малын туурай, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бусад мөр эд зүйлүүдэд тогтож шигдэж үлдсэн хөрс, шорооны үлдэгдэл, хэсгүүд хамаарах юм.

Онолын асуудал

Хөрс бол өгөршсөн эрдэс чулуулгийн жижиг хэмхдэст хэсгүүд, ялзмаг, агаар, уснаас тогтох газрын гадаргын өнгөн хэсгийн нимгэн давхарга юм. Эдгээр хэсгүүд хэр их хэмжээтэй байгаагаас хамаарч хөрсний найрлага, бүтэц янз бүр байна.

Хөрс нь эрдэс, органик матери, хий, шингэн ба тоологдошгүй олон организмуудын нийлмэл бөгөөд педосфер¹⁶² гэж нэрлэгдэх байгалийн биет ба дөрвөн чухал үүргийг гүйцэтгэдэг ургамал ургах орчин, ус хадгалах, нийлүүлэх, цэвэршүүлэх хэрэгсэл, дэлхийн агаар мандлыг сайжруулагч, организмуудын амьдрах нутаг нөхцлөөс бүрдэнэ. Эдгээр нь хөрсийг сайжруулах нөлөө байнга үзүүлж байдаг. Хөрс нь хатуу фаз (эрдэс ба органик матери) болон хийн төлөвт байх усыг агуулах сүвэрхэг хэсгээс тогтоно. Хөрсний текстурын хэсгүүд болох элс, лаг, шавар хоорондоо нийлэн агрегатуудыг үүсгэдэг ба агрегатууд нь нийлэн хөрсний бүтцийн илүү том нэгж болох педолитүүдийг үүсгэнэ.

Хөрс нь байнга өсөн нэмэгдэж буй хүнс тэжээлийн хэрэгцээг хангаж, агарыг шүүн, усыг цэвэршүүлж, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрс хүчлийн хийн ялгарлыг тэнцвэржүүлэн нүүрстөрөгчийг шингээж байдаг. Хөрс нь шавхагдах нөөц бөгөөд динамик шинжтэй, буруу

¹⁶² Дэлхийн геосперын харилцан үйлчлэлийн үр дүнд байгалийн хүчин зүйлсийн нөлөөгөөр уулын гадаргаас үүсэж дэлхийн хуурай гадаргын өнгөн сэвсгэр хэсгийг хөрс гэнэ.

ашиглавал хурдан доройтдог. Манай дэлхий дээр үржил шимтэй газар хязгаарлагдмал, дэлхийн хуурай газрын дөнгөж 11 хувийг эзэлдэг.¹⁶³

Зарим хөрсөнд ургамал хурдан ургадаг бол заримд нь ургадаггүй. Энэ нь хөрсний шинж чанараас хамаардаг. Хөрсний шинж чанар нь хөрсний текстур, хөрсний бүтэц, хөрсний үржил шим зэргээс хамаарна.

Хөрс нь дөрвөн гол бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд эрдэс чулуулаг буюу органик бус бодис, органик бодис, ус болон агаар хамаарна. Хөрсний зонхилох хувийг эрдэс чулуулаг буюу органик бус бодис эзэлдэг. Эрдэс чулуулаг нь өгөршин бутарч хөрсний хатуу хэсгүүдийг үүсгэдэг.

Харин хөрсөн дэх органик бодисууд нь амьд бие организмаас гаралтай бөгөөд хөрсний дээд үед унасан модны навч, үндэс, хатсан өвс, ургамлын үлдэгдлээс гадна төрөл бүрийн шавьж, бусад амьтдын үлдэгдлийн задралаас бүрддэг. Ус нь хөрсний үүсэл, бүтэц, тогтворжил, элэгдэл, хамгийн гол нь ургамлын ургалтад нөлөөлдөг.

Хөрсний бүрэлдэхүүн хэсгүүдийн харьцаа нь хөрсний шинж чанараас шалтгаалааад өөр өөр байж болох хэдий ч дунджаар эзлэхүүний 45 хувийг нь эрдэс чулуулаг буюу органик бус бодис эзэлдэг. Харин 25 хувийг ус, 25 хувийг агаарын хий, 5 хувийг органик бодис эзэлдэг.

Хөрсний үе давхарга: Хөрсний үе давхаргын зузаан янз бүр байдаг. Үүнд А давхарга, Б давхарга буюу хуримтлалын бүс, В давхарга буюу чулуулаг бүс гэж хамаарна. А давхарга бол хөрсний өнгөн хэсэг бөгөөд 15-30 см байдаг. Харин Б давхарга буюу хуримтлалын бүс /шилжилтийн үе/ нь 30-60 см байдаг. В давхарга буюу эх чулуулаг үе нь 30 см буюу түүнээс дээш зузаантай хөрсний хэсгийг хэлнэ.

Хөрсний механик бүрэлдэхүүн: Хөрсний механик бүрэлдэхүүнд тухайн хөрсний шавар, элс болон тоосны ширхэгүүд хамаарна. Тэдгээрийн хөрсийг бүрэлдүүлж буй хувь хэмжээг тодорхойлсноор тухайн хөрсөнд ургамал, ногоо тарих тохиромжтой орчин мөн эсэхийг тодорхойлно.

Хөрсний өнгө: Хөрсний өнгө нь ялзмаг ба төмрийн агууламжаас шалтгаална. Ялзмаг ихсэх тусам хар бараан, төмрийн исэл их бол улаавтар, шаргал өнгөтэй болно. Хөрсний өнгө нь гүн рүүгээ цайвар болох нь ялзмаг багасч буйн илрэл юм. Мөн хөрсний ширхэгийн бүрдлээр нь хүнд шавар, шавранцар, хөнгөн шавранцар, элсэнцэр гэж ангиалан үздэг.

Текстур: Хөрсөн дэх янз бүрийн хэмжээтэй хэсгүүдийг хөрсний текстур гэнэ. Хөрсний бүрдүүлэгчид болох элс, лаг, шавар ба тэдгээрийн янз бүрийн харьцаа нь хөрсний текстурт тодорхойлно. Сүвшил, нэвчилт, шингээлт, суух-хөөх зэрэг, ус агуулах багтаамж, элэгдэлд өртөмтгий эсэх зэрэг шинж чанаруудад хөрсний текстур нөлөөлдөг.

Хөрсний бүтэц: Хөрсний ширхэг, хэсгүүд хэрхэн нэгдсэнийг хөрсний бүтэц гэнэ. 4 үндсэн бүтцийг ялган авч үздэг ба үүнд: баганан, хавтанлаг, бөөгнөрсөн, үйрмэггүй ширхэглэг гэж байна. Хөрсөнд элс, шавар зэрэг олон төрлийн эрдэс чулуулгийн жижиг хэсгүүд байдаг. Хөрсөн дэх зарим жижиг хэсгүүд нь микроскопоор томруулахад харагдах тийм жижиг ширхэгтэй байхад зарим нь элсний ширхэгтэй адил хэмжээтэй ч бий. Хөрсний энэ байдал нь ус, агаар нэвчихэд чухал нөлөөтэй.

Хөрсний үржил шим: Ургамал ургахад шаардагдах органик бодисын хэмжээг хөрсний үржил шим гэх бөгөөд энэ нь эрдэс чулуулаг болон ялзмагийн хэмжээнээс хамаардаг. Ялзмаг нь амьтан, ургамлын үлдэгдэл задарч хөрсийг шим тэжээлээр хангадаг бол эрдэс чулуулаг нь төмөр зэрэг химийн элементээр ургамал ургах орчныг тэтгэдэг. Ингэснээр хөрсөнд ургамал ургах, амьтан өсч үржих боломж нэмэгдэнэ.

Хөрс үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс: Хүн, цаг хугацаа, рельеф, уур амьсгал, их чулуулаг, ургамал, амьтан, ус нөлөөлнө. Хөрс нь маш удаан буюу 50-100 жилийн хугацаанд үүсэж бий болдог. Харин хөрс элэгдэл гэмтээд цөлжихөд маш бага хугацаа шаарддаг. Хөрс нь нөхөн сэргээгдэхгүй нөөцөд хамаардаг тул маш чухал зүйл юм.

Хөрсний ач холбогдол: Хөрс нь ургамлыг шим тэжээлээр хангаж, хүмний хүнс, хувцас, орон байр, тавилга хийх түүхий эдийг ургуулж өгдгөөрөө ихээхэн ач холбогдолтой юм. Мөн амьтдын идэх хоол, тэжээл, өвч ургамлыг ургуулж байдаг.

Хөрсний хими: Ургамал ургах ба нөхөн үржихэд арван зургаан элемент шаардлагатай. Үүнд нүүрстөрөгч С, устөрөгч Н, хүчилтөрөгч О, азот N, фосфор Р, кали К, хүхэр S, кальци Ca, магн Mg, төмөр Fe, бор В, манган Mn, зэс Cu, цайр Zn, молибден

¹⁶³ Умберто Бланко Раттан Лал. "Хөрс хамгаалал ба менежментийн зарчим". 2011. 2 дахь тал

Мо, хлор Cl зэрэг багтана. Ургамлын амьдралын цикл бүрэн явагдахад шаардлагатай тэжээлийг шаардлагатай тэжээл, ургамлын ургалтад оролцдог боловч, амьдралын цикл бүрэн явагдахад гарцаагүй шаардлагатай бус тэжээлийг шаардлагатай бус тэжээл гэж нэрлэдэг.

Ус ба нүүрсхүчлийн хийгээр нийлүүлэгддэг нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгчийг эс тооцвол, тэжээл нь хөрсний эрдэс бодисуудаас үүсдэг. Хэдийгээр, эрдсүүд нь тэжээлийн эх үүсвэр ч, хөрсний органик нэгдлүүд нь ургамалд хялбар шингэх дийлэнх тэжээлийн агуулах нь болдог.

Хөрсний бохирдол: Хөрсний бохирдол гэдэг нь тухайн хөрсний хэвийн үйл ажиллагаа гадны ямар нэгэн нөлөөллөөр байгалийн шинжээ алдах үйл явцыг хэлнэ.¹⁶⁴ Химийн бохирдолд хүнд металлууд, цацраг идэвхит бодисууд, нефтийн нүүрс-усууд, эрдэс бордоонууд хамаарна. Харин биологийн бохирдолд мал амьтны сэг, хөдөө аж ахуйн, үйлдвэрийн болон ахуйн хог хагядлууд, ойн хортон шавьжтай тэмцэхэд хэрэглэдэг бактериуд хамаарна.

Хүнд металл: Шинжлэх ухааны хувьд хүнд металл нь хортой, өндөр нягтралтай, атомын шинжтэй бага концентрацид (ихэвчлэн) хортой металлын элемент юм. Хөрсөнд байх ёстой хэмжээнээс давсан хүнд металлууд нь хөрсний гүн дэх байгалийн усанд уусч хөрсний үе давхаргаар дамжин улмаар гадаргын усыг бохирдуулж ургамалд хуримтлагдах цаашлаад тэжээлийн хэлхээгээр дамжин мал амьтан, хүний эрүүл мэндийг хордуулах аюултай.

Хүнд металлын жишээнд хар тугалга, мөнгөн ус, кадми хамаарна. Хүнцлийн хоронд 5 ба түүнээс дээш жил өртвөл арьс, давсаг, уушигны хорт хавдраар өвдөх магадлалтай ба мэдрэлийн архаг хордлого, чихрийн шижин, зүрх судасны тогтолцооны өвчний эрсдэлийг нэмэгдүүлнэ.¹⁶⁵

Судалгааны ажлын үндэслэл

Дэлхийн хүнс тэжээл нь газрын гадаргын 15-16 см-ийн зузаантай өнгөн хэсгийн хөрснөөс хамаарч байдаг. Хөрсний гүн, бүтэц, ялзмагийн агууламж нь бүс нутагт ургаж болох ургамалжилтыг тодорхойлно.

Хөрсний ялгаатай байдалд нөлөөлдөг хүчин зүйл нь уур амьсгалын бүсүүдтэй адил хөрсний бүс, бүслүүрүүд ч бий. Газрын гадаргын хотгор гүдгэрийн хэв шинж буюу рельефтэй холбоотойгоор өндрийн хөрс ялгаатай байдаг. Мөн хөрсний шинж чанарт нөлөөлж буй нэг хүчин зүйл бол хүмүүсийн үйл ажиллагаа, амьдралын хэв маяг, орчны бусад нөлөөлөл юм.

Энэхүү шинж чанарыг үндэслэн гэмт хэрэг илрүүлэх салбарт тухайн сэжигтэн этгээдийн эдэлж хэрэглэсэн зүйлс, өмсөж явсан гутал хувцас, тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл зэрэгт үлдсэн хөрс, шорооны дээжийг шинжлэн тогтоож хэргийн газарт тухайн сэжигтэн этгээд байсан эсэхийг тогтооход ашиглах бүрэн боломжтой юм.

Тухайлбал цөлийн ба арктикийн бүсийн хөрс нь хур тунадас бага орсны улмаас хөрс үүсэх үйл явц удаан явагддагаас шалтгаалан ялзмагийн хэмжээ бага байна. Мөн сэрүүн бүсийн ой ба өвслөг газарт хур тунадас их биш тул хөрсний үржил шим их байдаг нь олон төрлийн ургамал ургаж ялзмаг үүсгэж байдагтай холбоотой. Манай орны тариалангийн талбайн зонхилох хэсгийг хөнгөн шавранцар хөрс эзлэдэг.¹⁶⁶

Тэгвэл тропикийн ширэнгэн ой бүхий нутаг дэвсгэрт хур тунадас ихтэй тул төмрийн агууламж нь үлдэж хөрсийг улаан өнгөтэй харагдуулдаг онцлогтой гэх мэтчилэн тухайн нутаг дэвсгэр, уур амьсгалаас шалтгаалан хөрс бүр өөр өөр онцлогтой байдаг.

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 85 хувь нь далайн түвшнээс дээш дунджаар 1000 метр өргөгдсөн бөгөөд уулын хэв шинжийн хөрс нийт хувийн 50.8 хувьтай тэнцэх нутаг дэвсгэрт тархсан. Уулын бүлэгт далайн түвшнээс дээш 1000-4000 метр хүртэл өргөгдсөн, 100 метрээс дээш харьцангуй өндөртэй уул толгод, гүвээг багтаан үзсэн.¹⁶⁷

Тэгвэл хүний үйл ажиллагаа, амьдралын хэв маягаас шалтгаалан тухайн хөрсөн дэх бүтэц найрлага өөр өөр байна. Үүнд арьс шир боловсруулах байгууламж, авто машин угаалга, засварын газар, нүүрс боловсруулах, хадгалах цэг гэх мэт химийн бодис ашиглан үйл

¹⁶⁴ ДХИС, ХААИС. “Аюулгүй байдал судлал-2019” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2019. 227 дахь тал

¹⁶⁵ ДХИС, ХААИС. “Аюулгүй байдал судлал-2019” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2019. 235 дахь тал

¹⁶⁶ “Монгол орны хөрс судлал сэтгүүл” “Монгол орны тариалангийн газрын ашиглалт, хөрсний элэгдэл эвдрэл” Н.Нямсамбуу, Д.Ихбаяр. УБ., 2016

¹⁶⁷ ДХИС, ХААИС. “Аюулгүй байдал судлал-2019” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2019. 228 дахь тал

ажиллагаа явуулдаг иргэн, байгууллага, аж ахуй нэгжийн орчмын хөрсөнд тухайн үйл ажиллагаа явуулахдаа ашигладаг химийн бодис уг хөрснөөс илэрдэг.

Судалгаа

Хөрсийг шинжлэн судлахдаа дээрх хөрс судлалын үндсэн асуудлуудыг ашиглан шинжлэх бөгөөд хөрсний РН хүчил шүлт, хөрсний ялзмагийн бүрэлдэхүүн, хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсний фосфор, калийн хэмжээг тогтоох шинжилгээ хийдэг.

Ийнхүү Хөрс судлалын шинжилгээ хийж тухайн хөрсний бүтэц, найрлагыг тодорхойлох агрохимийн шинжилгээ хийнэ. Тус шинжилгээг Монгол орны нөхцөлд тухайн газрын хөрсөнд ургамал, ногоо, мод тарьж ургуулахад тохиромжтой орчин эсэхийг тогтоох зорилгоор хийдэг.

Харин гэмт хэрэг илрүүлэх салбарт төдийлөн ашигладаггүй бөгөөд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 2019-2020 онд хөрс судлалтай холбоотой шинжилгээ хийлгэх 2 хүсэлт ирүүлсэн бөгөөд хүснэгтлэн харуулбал:

№	Огноо	Хэргийн утга	Шинжилгээ томилсон байгууллага	Шинжээчээс асуусан асуулт	Шинжээчийн дүгнэлтийн товч агуулга	Шинжилгээ хийсэн лаборатори
1	2019 9 сар	Машинтайгаа шатсан байдалтай нас барсан гэх	Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар	Машин шатсан хэргийн газраас авсан хөрсөнд шатах, тослох материал илрэх эсэх?	Шинжилгээнд ирүүлсэн хөрснөөс шатах, тослох материалын найрлага илэрч байна.	Химийн шинжилгээ-хөрсний бохирдол тогтоох шинжилгээ
2	2020 8 сар	Байшин дээрээс хүн унасан гэх	Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс	Шинжилгээнд хүргүүлсэн хөрснөөс илэрсэн цусны ДНХ-г тогтоох.	Шинжилгээнд ирүүлсэн хөрснөөс илэрсэн цус нь ДНХ-н шинжилгээнд тэнцэхгүй.	Биологийн шинжилгээ-хөрсний бохирдол тогтоох шинжилгээ

Дээрх шинжилгээний нөхцөл байдлаас харахад хөрс судлалын шинжилгээг нарийвчлан хийдэггүй нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хөрсөн дэх бохирдлыг (химийн бодис, хүнд металл, ахуйн хэрэглээний бодис, хүн мал амтны биеийн сэг гэх мэт) тогтоох шинжилгээ хийдэг.

Харин хөрсөн дэх агро-химийн агууламжийн үзүүлэлтийг тодорхойлох буюу хөрсний РН хүчил шүлт, ялзмагийн хэмжээ, механик бүрэлдэхүүнийг тогтоох шинжилгээ хийхгүй байна.

Гэхдээ физикийн шинжилгээний лабораторид рентген флуоресценз спектрофотометрийн төхөөрөмжөөр хөрсний элементийн анализыг хийх боломжтой. Өөрөөр хэлбэл хөрсний үндсэн химийн найрлагыг тодорхойлох боломжтой. Гэвч энэ төрлийн шинжилгээ төдийлөн томилогдож ирдэггүй байна.

Тэгвэл судалгааны ажлын хүрээнд гэмт хэрэг илрүүлэх салбарт хөрс судлалын шинжилгээ хийгддэггүй шалтгааныг тогтоох зорилгоор 10-аас дээш жил ажилласан 45 мөрдөгчөөс санал асуулга авахад нийт судалгаанд хамрагдсан мөрдөгчдийн 65 хувь нь “Энэ төрлийн шинжилгээ хийх шаардлага гарч байгаагүй”, 48 хувь нь “Энэ төрлийн шинжилгээ хийх боломжтойг мэдэхгүй”, 10 хувь нь “Хөрсний бохирдолд (химийн бодис, хүнд металл, ахуйн хэрэглээний бодис, хүн мал амтны биеийн сэг гэх мэт) хийх химийн шинжилгээг томилж байсан”, 60 орчим хувь нь “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн энэ төрлийн шинжилгээг хийх боломжгүй тул шинжилгээ томилдоггүй”, 50 орчим хувь нь “Шүүхийн шинжилгээг Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэхэд олон асуудлууд тулгардаг тул төдийлөн шинжилгээ томилдоггүй, бусад байдлаар хэргээ шалгадаг”, 25 хувь нь “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Геологийн төв лаборатори, Их сургуулиудад энэ төрлийн шинжилгээ хийлгэхээр томилж байсан” гэж тус тус хариулжээ.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад хөрс судлалын шинжилгээ хийх нөхцөл, лаборатори тоног төхөөрөмж, шинжилгээгээр шийдвэрлэх асуудал, шинжилгээ томилох эрх бүхий этгээдүүдийн мэдлэг, туршлага дутмаг байгаа нь харагдаж байна.

Арга зүйн асуудал

Хөрс судлалын шинжилгээ хийхдээ хими, физик, биологи, геологийн шинжлэх ухааныг өргөнөөр ашиглах ба дараах 2 төрлийн шинжилгээг хийх боломжтой. Үүнд:

1. Хөрсний бохирдолд (химийн бодис, хүнд металл, ахуйн хэрэглээний бодис, хүн мал амьтны биеийн сэг гэх мэт) хийх шинжилгээ;
2. Хөрсөн дэх агро-химийн агууламжийн үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээ юм.

Хөрсний бохирдолд хийх шинжилгээ: Хөрсний бохирдлын шинжилгээгээр тухайн шинжилгээнд хүргүүлсэн хөрсөн дэх хими, биологийн гаралтай зүйлс байгаа эсэхийг тогтооно. Өөрөөр хэлбэл тухайн хөрсний үндсэн агууламжаас гадна бусад гадны нөлөөгөөр тухайн хөрсөнд нөлөөлсөн органик ба органик бус нэгдлийн үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээ юм.

Үүнд төрөл бүрийн химийн бодис, хар тамхи, мансууруулах бодис, хүнд металлууд, нүүрснээс үүсэх химийн бодисууд, авто машины аккумулятор, батерейны шингэн, тос тосол, бинзен, угаалгын шингэн бодис гэх мэт ахуйн зориулалтын химийн бодисууд, хүн, мал амьтны сэг үлдэгдэл зэрэг хамаарна.

Эдгээр хөрсний бохирдлыг тодорхойлох шинжилгээг хими, биологийн шинжилгээний лабораторид тухайн чиглэлийн мэргэжилтэн зориулалтын тоног төхөөрөмж, урвалж бодисыг ашиглан хийх боломжтой.


Хөрсөн дэх агро-химийн агууламжийн үзүүлэлтийг тодорхойлох шинжилгээ: Хөрсний PH хүчил шүлт, ялзмагийн хэмжээ, хөрсний химийн найрлагыг тодорхойлоход лабораторийн тоног төхөөрөмж шаардагдана.

Харин хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээ хийхэд спектрофотометрийн төхөөрөмж шаардагдахгүй байх бөгөөд гэмт хэргийн газрын хөрстэй сэжигтэн этгээдээс авсан хөрсний дээжийг хөрсний механик бүрэлдэхүүнээр нь харьцуулан тодорхойлох боломжтой юм. Мөн тухайн хөрсний агро-химийн агууламжийн үзүүлэлтээр нутаг дэвсгэр, орчны хөрсний онцлогийг тодорхойлох оношлогооны шинжилгээ хийх боломжтой.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээний арга зүй:

Гэмт хэрэг илрүүлэх салбарт ашиглахад тохиромжтой шинжилгээний төрөл бол хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээ юм. Өөрөөр хэлбэл хөрсөн дэх шаварлаг, элсэрхэг, тоосны ширхэгийн эзлэх хувийг тодорхойлно. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох агро-химийн шинжилгээг хийхдээ дараах арга зүйг баримтална. Үүнд:

1. Хэргийн газраас эсвэл сэжигтэн этгээдийн өмсөж явсан гутал, хувцас, авч явсан эд зүйлс (хүрз, лоом гэх мэт), унаж явсан тээврийн хэрэгсэл, мал амьтны хөл, туурайнд байх хөрс, шорооноос хамгийн багадаа 50-100 грамм хэмжээтэй дээж авч бэлтгэнэ.
2. Дээжийг задлах зориулалттай талстлаг бодис болох Натри Трифосфат бодисыг бэлтгэхдээ 100 мл цэвэр усанд уг бодисноос 1 граммыг хийж хутган найруулна. Хөрсний дээжний онцлогоос хамаарч 100 мл найруулсан уг бодисоор дунджаар 8-10 хэсэг хөрсний дээжид шинжилгээ хийх боломжтой.
3. Шинжлэх гэж буй хөрснөөс 10 граммыг авч түүн дээр 5-10 мл Натри Трифосфат бодис хийж нийлүүлэн 15 минутын туршид нухаж хутгана. Нухаж бэлтгэсэн дээжийн тоосонцорын хэсгийг шүүж салгах зорилгоор 0,25 мл хэмжээтэй нарийн шигшүүрээр шигшинэ. Шигшсэн дээжийг цилиндрэн шилэн саванд хийж дээрээс нь тасалгааны температуртай 1 литр цэвэр ус хийж холино.
4. Хольсон дээжээ нийт 4 төрлийн хугацааны дараа 25 мл-ийг авч шаазан аяганд хийж зөөлөн галанд ширгээнэ. Дараахь 4 төрлийн хугацааны дараа 25 мл дээж авна. Үүнд:
 - 155 секунд
 - 19 минут
 - 60 минут
 - 22-24 цагийн дараа дээж авна. Хөрсний 1 дээжээс 4 удаагийн дээж авч шинжилгээ хийнэ.
5. Ширгээсэн 4 дээжүүдийг харьцуулан дундажлаж шинжилсэн хөрсний нунтаг дээжийг анх дээж авсан 10 грамм хөрсний дээжтэйгээ хувьчлан харьцуулж тухайн хөрсөнд шавар, элс, тоосны ширхэгийн эзлэх хувийг тодорхойлно.
6. Шинжилсэн хөрсний дээжин дэх механик бүрэлдэхүүнийг эзлэх хувийг уг бүрэлдэхүүнийг тогтоох дараахь гурвалжин схемд оруулан байрлуулж тухайн шинжилсэн хөрсний онцлогийг тодорхойлон гаргана.



Ийнхүү хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлсноор хэргийн газрын орчмын хөрсийг сэжигтнээс авсан хөрсний дээжтэй хөрсний механик бүрэлдэхүүнээр нь харьцуулан шинжилж ижил байгаа эсэхийг тодорхойлно.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээний дутагдалтай тал:

1. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээ хийхэд хөрсний дээжний хэмжээ нь оношлогооны болон адилтгалын шинжилгээ хийхэд тэнхцэхүйц хангалттай байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл уг шинжилгээ хийхэд багадаа 50-100 грамм хэмжээтэй хөрсний дээж байх шаардлагатай.
2. Сэжигтэн этгээд бүрээс хөрсний дээж авч шинжилгээ хийх боломжгүй.
3. Уг шинжилгээг хийхэд химийн бодис ашигладаг тул тухайн шинжилгээ хийж буй лаборант, шинжээч нь химийн бодист хордох эрсдэл байж болно.
4. Хөрсний бохирдлын шинжилгээг хийхэд спектрофотометрийн төхөөрөмж, бусад урвалж бодисууд шаардлагатай.

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээний давуу тал:

1. Орчны нөхцөл байдал, амьдрал ахуйн хэв маяг, уур амьсгал зэргээс шалтгаалан газар, орны хөрс бүр ялгаатай тул тухайн орчныг илэрхийлсэн бүтэцтэй хөрсийг тээж явсан эд зүйлс, хүн, мал, амьтны хөл, туурайнаас дээж авч шинжлэн харьцуулан тодорхойлох боломжтой.
2. Хөрсний дээжийн бохирдлыг (химийн бодис, хүнд металл, ахуйн хэрэглээний бодис, хүн мал амьтны эд, биеийн сэг гэх мэт) тогтоох шинжилгээ хийж химийн элементүүдийг тодорхойлох боломжтой.
3. Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох шинжилгээ хийхэд хөрсний дээж нь багадаа 50-100 грамм байх шаардлагатай байх боловч дараагийн шатны хими, микробиологийн шинжилгээ хийхэд багадаа 5-10 грамм байхад хангалттай тул бүх бусад хими, физик, геологийн шинжилгээг хийж хэргийг бусад байдлаар нотлон тогтоох боломжтой.
4. Хөрсний бохирдлын шинжилгээний урьтач болгох, шуурхай эрэн сурвалжлах ажиллагаанд яаралтайгаар мэдээлэл олох, эрлийн хүрээг умих зорилгоор хөрсний механик бүрэлдэхүүнийг тогтоох шинжилгээ хийх боломжтой.

Дүгнэлт, санал

Хөрс үүсэхэд 5 хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд уур амьсгал, эх чулуулаг, организм, газрын хотгор гүдгэр, цаг хугацаа хамаарна. Хөрс нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол хэрэгсэл болохоос гадна байгаль орчны чанар, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх, мөн хот суурин, үйлдвэрийн хог хаягдлыг агуулах орон зай болох зэрэг олон талт үүрэгтэй юм. Тэгвэл гэмт хэрэг илрүүлэх салбарт хөрс судлалыг ашиглах боломжтой юм. Хөрс судлалын шинжилгээгээр тогтоох асуудал тодорхойгүй, түүний хэрэглээ, туршлага бага тул энэ төрлийн шинжилгээ төдийлөн сайн хөгжөөгүй байна. Харин иргэний хэрэг болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд хувийн үйлдвэрлэл, аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор тухайн газарт хөрс судлалын шинжилгээг хийлгүүлдэг байна. Зарим тохиолдолд буюу хөрсөн дэх бусад элементүүд байгаа эсэхийг тогтоолгохоор эрүүгийн хэрэгт Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шинжилгээ томилж байна.

Тэгвэл хөрс судлалын үндсэн асуудал болох хөрсний үндсэн агууламжийн хувийг тодорхойлох, аль газарт нутгийн хөрс болохыг тодорхойлж сэжигтэн этгээдийн бие, эд зүйлсээс хураан авсан хөрсний дээжтэй харьцуулан нэг газрын хөрс мөн болохыг тодорхойлох шинжилгээ хийгдэхгүй байна. Энэ нь олон шалтгаан нөхцөлтэй бөгөөд энэ төрлийн шинжилгээний асуудлууд тодорхойгүй, шинжилгээний лабораториуд хангалтай биш байгаа нь үндсэн шалтгаан болж байна. Иймд энэ төрлийн шинжилгээг хөгжүүлэх, гэмт хэрэг илрүүлэх салбарт ашиглахад дараахь асуудлуудыг шийдвэрлэх нь чухал юм. Үүнд:

1. Шинжилгээнд ирүүлсэн хөрсийг аль газрын хөрс болохыг тогтоон хөрсний дээжийг оношлох зорилгоор нутаг дэвсгэрийн хөрсний дээжүүдийн сан бүрдүүлэх.
2. Шинжилгээнд ирүүлсэн хөрсийг ямар төрлийн хөрс болохыг тогтоон хөрсний дээжийг оношлох зорилгоор ой хээр, уулархаг, намгархаг, элсэрхэг гэх мэт өөр өөр төрлийн хөрсний дээжүүдийн сан бүрдүүлэх.
3. Хөрсний бохирдол, хөрсний агро-химийн агууламжийн үзүүлэлтийг тодорхойлох тоног төхөөрөмжийн шинэчлэлт, хэрэглээ, ажиллах арга зүйг тус бүрчлэн ангилж тодорхойлон гаргаж хууль сахиулах салбарт ашиглаж эхлэх.
4. Хөрс судлалын шинжилгээ хийх мэргэжлийн албан хаагчийг судлан суралцуулж экологийн шинжилгээний лаборатори байгуулан ажиллуулах.
5. Хөрс судлалын шинжилгээ хийж буй бусад шинжилгээний лабораториудын онцлог, шийдвэрлэж буй асуудал, тоног төхөөрөмж, арга зүйн талаар харилцан туршлага солилцож цаашид зарим төрлийн хэргүүдэд хамтран ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.
6. Хөрс судлалын шинжилгээгээр шийдвэрлэх асуудал, боломж, шаардлагын талаар хууль сахиулах салбарын албан хаагчдад таниулах ажлыг зохион байгуулах.

Ном зүй

1. Р.Баатар. “Хөрсний хими, агрохими, ус-физикийн шинж чанаруудыг тодорхойлох аргууд”. УБ., 2003
2. Ц.Батчулуун, С.Гэрэлбаатар. “Хөрс судлал”. УБ., 2015
3. Л.Галт. “Хөрсний микробиологийн судалгааны аргууд”. УБ., 2004
4. Д.Доржготов. “Монгол орны хөрс”. УБ., 2003
5. Умберто Бланко Раттан Лал. “Хөрс хамгаалал ба менежментийн зарчим”. 2011
6. ДХИС, ХААИС. “Аюулгүй байдал судлал-2019” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2019
7. Н.Нямсамбуу, Д.Ихбаяр. “Монгол орны хөрс судлал сэтгүүл”. “Монгол орны тариалангийн газрын ашиглалт, хөрсний элэгдэл эвдрэл”. УБ., 2016

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

СЭТГЭЛ САНААНЫ ГЭМ ХОРЫН ХОХИРЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХОД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Ц.Оюунбилэг

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч

